ПАДКО | АЭКОМ

ХОТ БАЙГУУЛАЛТ, ОРОН СУУЦНЫ САЛБАРЫН СТРАТЕГИ

ТТ No. 4352-МОНГОЛ УЛС

Төгсгөлийн тайлан

Боть 2: Хавсралтууд

АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК, МОНГОЛ УЛСЫН БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ-д

ПАДКО- ООС боловсруулав.

2005 оны 5 дугаар сарын 2

Энэхүү тайланг Азийн хөгжлийн банк (АХБ)-ны захиалгаар зөвлөхүүд бэлтгэсэн болно. Тайланд тусгагдсан үзэл бодол нь зохиогчдынх бөгөөд АХБ болон тус банкны Захирагчдын Зөвлөл, тэдний төлөөлдөг улс орнуудын Засгийн газруудын албан ёсны байр суурь, бодлогыг заавал илэрхийлсэн байх албагүй. Энэхүү тайланд тусгагдсан тоо баримтын үнэн зөв эсэх талаар АХБ баталгаа өгөхгүй бөгөөд түүнийг ашигласнаас үүдэн гарах аливаа хариуцлагыг хүлээхгүй болно.

Энэхүү баримт бичгийг олон нийтийн хүртээл болгох зорилгоор монгол хэлнээ хөрвүүлсэн боловч англи хэл нь Азийн хөгжлийн банк (АХБ)-ны албан ёсны хэл тул зөвхөн англи хэл дээрхи эх хувийг нь албан ёсных хэмээн үзнэ. Иймд иш татахдаа англи эхийг ашиглана уу. АХБ орчуулгын үнэн зөв эсэх талаар баталгаа өгөхгүй бөгөөд эх хувиас утга нь гажсан тохиолдолд аливаа хариуцлага хүлээхгүй болно.

Хот байгуулалт ба орон сууцны салбарын стратеги
Азийн хөгжлийн банк ТТ 4352 – Монгол

Төгсгөлийн тайлан
Боть II: Хавсралтууд

Хавсралт А. Хот байгуулалт, орон сууцны салбарын үндсэн тоо мэдээлэл

Хавсралт Б. Канадын орон сууцны үндэсний код болон Монголын “нэг айлын сууц” БНбД-ийн харьцуулалт

Хавсралт Д. Хархорин хотын хөгжлийн Ерөнхий төлөвлөгөөнд хийсэн үнэлэлт

Хавсралт Е. 40.000 айлын орон сууцны хөтөлбөрт оролцохоор БХБЯ-д бүртгүүлсэн компаниуд

Хавсралт Ё. Хотын Ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажил үүргийн хуваарийн загвар

Хавсралт Ж. Олон нийтийн оролцоотой үйл ажиллагааны төлөвлөлтийн чиг хандлага

Хавсралт З: Санхүүгийн удирдлагын үнэлгээний асуулга

Хавсралт И: Орон сууцны хэрэгцээг тооцох

Хавсралт К: Санхүүгийн хүснэгтүүд

ХАВСРАЛТ А. Хот байгуулалт, орон сууцны салбарын үндсэн тоо мэдээлэл

Тус ТТ-ны үндсэн гурван дэд хэсгийн нэг нь МУ-ын хот байгуулалт, орон сууцны салбарын тоо мэдээлийг шинэчлэх юм. Энэ хавсралтад Эхлэлийн тайлан, Явцын тайланд тусгагдсан тоо мэдээллийн хураангуйг оруулав.

1. Хүн амын суурьшлын хувьсал хөгжил

Засаг захиргааны нэг дэхь түвшинд 21 аймаг, нийслэл Улаанбаатар хот, хоёр дахь түвшинд аймгууд сумдад, Улаанбаатар хот дүүрэгт хуваагддаг. Эдгээр сум, дүүргүүд нь баг, хороо буюу засаг захиргааны доод нэгжид тус тус хуваагддаг. Дунджаар нэг аймагт 20 сум, нэг суманд 4-6 баг болон багт 50-100 өрх ногдож байна. 2000 оны Хүн амын тооллогоор нийт 342 сум, дүүрэг, 1681 баг, хороо тоологджээ.

2000 оны Хүн амын тооллогоор хотын хүн амыг тодорхойлохдоо Улаанбаатар хот, аймгийн 21 төв, 22 суурин газар буюу тосгоныг хамруулсан байна. Хот, тосгоны эрх зүйн тухай хуулинд тосгоныг 500-15000 оршин суугчтай, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлал, амралт, сувилал, тээвэр, худалдаа зэрэг салбарын аль нэг хөгжсөн, өөрийн удирдлага бүхий суурин газар гэж тодорхойлсон байна. Эдгээр суурин газрын ангиллаар хүн ам, орон сууцны үндсэн хэдэн үзүүлэлтийг 2000 онд явуулсан Хүн ам, орон сууцны тооллогын тоо мэдээллээр Хүснэгт 1.1.-д харуулав. Улаанбаатар хотод оршин суугаа өрхийн тоо хөдөөгийн нийт өрхийн тоотой бараг ойролцоо байна.

Хүснэгт 1.1. Өрхийн тоо, орон сууцны төрөл тооллогын ангиллаар (2000 онд)

	Өрх		Орон сууцны төрөл	
	Тоо	%	Байшинд, %	Гэрт, %
Улаанбаатар	161,273	29.8	78.2	21.8
Аймгийн төв	118,104	21.8	62.5	37.5
Тосгон	17,021	3.1	73.9	26.1
Сумын төв	85,381	15.8	43.3	56.7
Хөдөө	159,470	29.5	10.1	89.9
Бүгд	541,149	100	49.1	50.9

Зураг 1-д МУ-ын бүс нутаг, аймгийн хил хязгаар, аймгийн төв, сум, Улаанбаатар хотын байршлыг харуулав. Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд сумдууд ерөнхийдөө жигд тархан байршсан бөгөөд Улаанбаатар хотоос баруун зүгт төвийн хэсэгт бага зэргийн илүү бөөгнөрсөн харагдаж байна. Төвийн, Хангайн бүсүүд нь Зүүн, Баруун бүсүүдтэй харьцуулахад илүү олон аймгуудыг хамарч байна. 2000 оны хүн ам, орон сууцны тооллогын дүнгээр улс орны төв хэсэгт буюу Улаанбаатар хот, Төвийн бүсэд хүн амын 60 орчим хувь, Баруун бүсэд 18 хувь, Зуун болон Өмнөд бүсэд тус тус 20 хувь нь оршин сууж байжээ.

Хүн ам, өрхийн тоогоор хот суурин газруудын хэмжээг тодорхойлсон 2003 оны ҮСГ-ын тоо мэдээллийг Хүснэгт 1.2-т харуулав. Эндээс харахад хот, суурин газруудын ихэнхи нь 500-1,000 өрхтэй, 2,000-5,000 хүн амтай байна. Нийт хот, суурин газрын 70 орчим хувь нь 1,000-аас цөөн өрхтэй байна. Цөөн хэд нь 1500-аас олон өрхтэй бөгөөд эдгээр нь аймгийн төвийн сум буюу хотын дүүргүүд байна.


ADMINISTRATIVE BASE MAP OF MONGOLIA
Suitable for reference purposes only
88°0'0"E
92°0'0"E
96°0'0"E
100°0'0"E
104°0'0"E
108°0'0"E
112°0'0"E
116°0'0"E
120°0'0"E
52°0'0"N
48°0'0"N
44°0'0"N
40°0'0"N
N
S
W
E
Uvs
Bayan Olgii
Hovsgol
Zavhan
Hovd
Arhangai
Bulgan
Orkhon
Selenge
Darhan Uul
Dornod
Henti
UB
Tov
Govisumber
Sukhbaatar
Govi Altai
Bayanhongor
Ovorhangai
Dundgovi
Dornogovi
Omnogovi
Ulaangom
Ulgii
Hovd
Moron
Sukhbaatar
Erdenet
Darkhan
Bulgan
Choilbalsan
Uliastai
Tsetserleg
Zuunmod
Ondorhaan
Baruunurt
Altai
Bayankhongor
Arvaikheer
Choir
Mandalgovi
Sainshand
Dalanzadgad
0
140
280
560
Kilometers
1:9,500,000
1 centimeter equals 95 kilometers
Map projection and coordinate: UTM Zone48, WGS84
Produced by V.Ulziisaikhan, e-mail: vulzii@yahoo.com
Copyright 2003 by Spatial Data Analyst Lab
Legend
National Boundary
Aimag Boundary
Aimag Boundary
Aimag Center
Soum Location
Names and boundary representation are not necessarily authoritative.
Proper names on this product may not conform to standard names.

Хүснэгт 1.2 Хот суурин газрын хэмжээ

Бүс, аймаг			500-аас цөөн өрх	500-1000 өрх	1001-1500 өрх	1501-2000 өрх	2000-аас олон өрх	Сумын нийт тоо	Өрхийн нийт тоо	Сумын өрхийн дундаж тоо	Хүн амын нийт тоо	Сумын хүн амын дундаж тоо
Баруун бүс												
1	**1**	Баян-Өлгий	1	3	5	4	1	14	21753	1518	98449	6869
2	**2**	Говь-Алтай	0	17	0	0	1	18	15168	843	64042	3558
3	**3**	Завхан	7	14	0	2	1	24	20238	843	84293	3512
4	**4**	Увс	2	12	3	1	1	19	19791	1042	83112	4374
5	**5**	Ховд	1	14	0	1	1	17	19243	1132	91175	5363
			11	**60**	**8**	**8**	**5**	**92**	**96193**	**1042**	**421071**	**4560**
Хангайн бүс												
6	**1**	Архангай	0	7	8	3	1	19	24672	1299	94629	4980
7	**2**	Баянхонгор	1	15	3	0	1	20	21527	1076	83937	4197
8	**3**	Булган	1	11	3	0	1	16	15425	964	58481	3655
9	**4**	Орхон	0	1	0	0	1	2	19962	9981	82018	41009
10	**5**	Өвөрхангай	0	7	7	1	4	19	28865	1519	107801	5674
11	**6**	Хөвсгөл	1	9	13	0	1	24	31021	1293	124126	5172
			3	**50**	**17**	**4**	**9**	**100**	**141472**	**1415**	**550992**	**5510**
Төвийн бүс												
12	**1**	Говьсүмбэр	1	1	0	0	1	3	3170	1057	12519	4173
13	**2**	Дархан-Уул	0	1	1	0	2	4	20110	5028	89857	22464
14	**3**	Дорноговь	6	6	0	1	1	14	13242	946	51567	3683
15	**4**	Дундговь	4	9	0	1	1	15	12540	836	50999	3400
16	**5**	Өмнөговь	4	10	0	0	1	15	12128	809	47821	3188
17	**6**	Сэлэнгэ	4	7	3	1	2	17	22639	1332	93700	5512
18	**7**	Төв	7	14	3	2	1	27	23257	861	92816	3438
			26	**48**	**2**	**5**	**9**	**95**	**107086**	**1127**	**439279**	**4624**
Зүүн бүс												
19	**1**	Дорнод	4	8	1	0	1	14	17079	1220	72670	5191
20	**2**	Сүхбаатар	3	6	3	0	1	13	13316	1024	54585	4199
21	**3**	Хэнтий	4	12	1	1	1	19	17568	925	68135	3586
			11	**26**	**2**	**1**	**3**	**46**	**47963**	**1043**	**195390**	**4248**
Улаанбаатар бүс												
22	**1**	Улаанбаатар	0	1	0	0	8	9	192934	21437	869912	96657
БҮГД			**51**	**185**	**29**	**18**	**34**	**342**	**585648**	**1711**	**2476644**	**7235**

МУ-ын хот суурин газар нь өөр хоорондоо ялгаатай хөгжлийн хоёр загварыг төлөөлдөг. Нэгдүгээрт, оросын загвар бүхий төлөвлөлтөд суурилсан орон сууцны хороолол болон үлэмж тодорхой бус хэлбэр бүхий задгай буюу цэцэрлэгжүүлсэн талбай байна. Хоёрдугаарт, "төлөвлөлтийн" огт өөр аргыг хэрэглэсэн "түр зуурын" гэр хороолол байх бөгөөд үйлчилгээ хүрээгүй, хоёр талдаа өргөн замтай, урт судал бүхий их хэмжээний хэсэг газар байна. Улаанбаатар хотоос эхлүүлээд жижиг суурин газар хүртэл эдгээр хоёр хэв маяг давтагдаж байна.

Орон сууцны болон гэр хорооллыг хэдэн айл өрх амьдарч байгаагаар нь ойролцоогоор тодорхойлж болох юм. 21 аймгийн 12-т нь хотын айл өрхийн 15 хүрэхгүй хувь нь төлөвлөгдөн баригдсан орон сууцанд амьдарч байна. 4 аймагт энэ үзүүлэлт 15-30 хувь, 3 аймагт 30-50 хувь, Улаанбаатар хотод 45 орчим хувьтай байна. Эрдэнэт, Дархан хот ордог 2 аймагт л зөвхөн 50-аас дээш хувьтай байна.

2 Хүн ам зүй ба хотжилт

МУ-ын хүн амын тархалтыг 2000 ба 2003[1] оны байдлаар аймаг, бүс нутгаар Хүснэгт 2.1-д харуулав. Адил газар зүйн байршил, хугацаагаар хот суурин газрын хүн амын тоо, хувийг мөн тусгасан. Нийт хүн амын бараг гуравны нэг нь Улаанбаатар хотод суурьшиж байхад Дархан, Эрдэнэт хот орсон нийт 21 аймаг бүрийн хүн амын тоо 5 хүрэхгүй хувьтай байна. Улаанбаатар хотын хүн амын өсөлт улсын хэмжээнээс дээгүүр байна.

Бүс, аймгийн хэмжээнд 2000-2003 онд гарсан хотжилттой холбогдсон нэмэлт мэдээллийг Хүснэгт 2.2-оос харж болно. Энд Улаанбаатар хот нь улсын хэмжээний хүн амын өсөлтөөс илүү их хүн амыг шинээр татаж, шингээх чадвартай харагдаж байна.

Улаанбаатар хот руу шилжиж байгаа үндсэн шалтгаан нь гол төлөв эдийн засгийн үндэслэлтэй юм. Тооллогоор тоологдсон аж ахуйн нэгжийн талаас илүү нь Улаанбаатар хотод төвлөрч, ДНБ-ний 51.6 хувийг 2000 онд үйлдвэрлэж байсан байна. Дундаж аймаг ДНБ-ний 2.3 хувийн үйлдвэрлэж байгаа нь Улаанбаатар хот, бусад хот суурин газар эдийн засгийн бололцоо боломж, аж үйлдвэрийн хүчин чадал, хөрөнгө, ажиллах хүч зэрэг үзүүлэлтээр хэр их ялгаатай байгаа нь харагдаж байна.

2000 оны хүн амын тооллогын дүнгээр нийт айл өрхийн 55 орчим хувь нь хот суурин газарт амьдарч байна. Хот, суурин газарт оршин суугаа айл өрхийн ихэнх нь (23 хувь) ам бүл 4, удаах нь (18 хувь) - 5 ба (17 хувь) 3 тус тус байна. Улаанбаатар хотын өрхийн дундаж хэмжээ 4.6 хүн бөгөөд Ховд, Баян-Өлгий аймагт л үүнээс илүү (4.7 хүн) байна. Хот, суурингийн нийт айл өрхийн 5.5 хувь нь ганц бие эцэг, эх бүхий өрхүүд байна.

Монголын хот суурин газрын хүн ам маш залуу. Хотын хүн амын олонхи нь 10-14, удаагийнх нь 15-19 насныхан байна. Хотын хүн амын 48 хувь амьдралынхаа эдийн засгийн идэвхтэй (20-55) насанд явж байна.

[1] 2000 оны Хүн ам, орон сууцны тооллого, ҮСГ-ын 2003 оны тооцоог ашиглав.

Хүснэгт 2.1. Хүн амын тархалт аймаг, бүсээр, 2000-2003 онд

Бүс, аймаг			Хүн амын нийт тоо 2000 онд	Хотын хүн амын нийт тоо 2000 онд	Нийт хүн амд аймаг, хотын эзлэх хувь 2000 онд	Аймаг, хотын нийт хүн амд хотын хүн амын эзлэх хувь 2000 онд	Хүн амын нийт тоо 2003 онд	Хотын хүн амын нийт тоо 2003 онд	Нийт хүн амд аймаг, хотын эзлэх хувь 2003 онд	Аймаг, хотын нийт хүн амд хотын хүн амын эзлэх хувь 2003 онд
Баруун бүс										
1	**1**	Баян-Өлгий	91068	28060	3.8	30.8	98449	29889	4.0	30.4
2	**2**	Говь-Алтай	63673	18023	2.7	28.3	64042	20452	2.6	31.9
3	**3**	Завхан	89999	24276	3.8	27.0	84293	19059	3.4	22.6
4	**4**	Увс	90037	26319	3.8	29.2	83112	24540	3.4	29.5
5	**5**	Ховд	86831	26023	3.7	30.0	91175	30527	3.7	33.5
			421608	**122701**	**17.8**	**29.1**	**421071**	**124467**	**17.0**	**29.6**
Хангайн бүс										
6	**1**	Архангай	97031	18519	4.1	19.1	94629	17828	3.8	18.8
7	**2**	Баянхонгор	84779	22066	3.6	26.0	83937	23837	3.4	28.4
8	**3**	Булган	61776	16239	2.6	26.3	58481	15414	2.4	26.4
9	**4**	Орхон	71525	68310	3.0	95.5	82018	75347	3.3	91.9
10	**5**	Өвөрхангай	111420	19058	4.7	17.1	107801	20657	4.4	19.2
11	**6**	Хөвсгөл	119063	31489	5.0	26.4	124126	38957	5.0	31.4
			545594	**175681**	**23.0**	**32.2**	**550992**	**192040**	**22.2**	**34.9**
Төвийн бүс										
12	**1**	Говьсүмбэр	12230	8983	0.5	73.5	12519	7356	0.5	58.8
13	**2**	Дархан-Уул	83271	65791	3.5	79.0	89857	73281	3.6	81.6
14	**3**	Дорноговь	50575	25210	2.1	49.8	51567	27351	2.1	53.0
15	**4**	Дундговь	51517	14517	2.2	28.2	50999	14017	2.1	27.5
16	**5**	Өмнөговь	46858	14183	2.0	30.3	47821	14506	1.9	30.3
17	**6**	Сэлэнгэ	99950	56446	4.2	56.5	93700	29798	3.8	31.8
18	**7**	Төв	99268	16227	4.2	16.3	92816	17758	3.7	19.1
			443669	**201357**	**18.7**	**45.4**	**439279**	**184067**	**17.7**	**41.9**
Зүүн бүс										
19	**1**	Дорнод	75373	41714	3.2	55.3	72670	36356	2.9	50.0
20	**2**	Сүхбаатар	56166	15133	2.4	26.9	54585	11289	2.2	20.7
21	**3**	Хэнтий	70946	27853	3.0	39.3	68135	27700	2.8	40.7
			202485	**84700**	**8.5**	**41.8**	**195390**	**75345**	**7.9**	**38.6**
Улаанбаатар бүс										
22	**1**	Улаанбаатар	760077	760077	32.0	100.0	869912	869912	35.1	100.0
БҮГД			**2373433**	**1344516**	**100.0**	**56.6**	**2476644**	**1445831**	**100.0**	**58.4**

Хүснэгт 2.2. Нийт ба хотын хүн амын өөрчлөлт 2000-2003 онд

Бүс, аймаг			Нийт хүн амын тоо 2000 онд	Нийт хүн амын тоо 2003 онд	Хүн амын тооны өөрчлөлт (2) - (1)	Нийт хүн амд эзлэх өөрчлөлт (3):(1)	Хотын нийт хүн амын тоо 2000 онд	Хотын нийт хүн амын тоо 2003 онд	Хотын хүн амын тооны өөрчлөлт (6) - (5)	Хотын нийт хүн амд эзлэх өөрчлөлт (7):(5)
			1	2	3	4	5	6	7	8
Баруун бүс										
1	**1**	Баян-Өлгий	91068	98449	7381	8.1%	28060	29889	1829	6.5%
2	**2**	Говь-Алтай	63673	64042	369	0.6%	18023	20452	2429	13.5%
3	**3**	Завхан	89999	84293	-5706	-6.3%	24276	19059	-5217	-21.5%
4	**4**	Увс	90037	83112	-6925	-7.7%	26319	24540	-1779	-6.8%
5	**5**	Ховд	86831	91175	4344	5.0%	26023	30527	4504	17.3%
			421608	**421071**	**-537**	**-0.1%**	**122701**	**124467**	**1766**	1.4%
Хангайн бүс										
6	**1**	Архангай	97031	94629	-2402	-2.5%	18519	17828	-691	-3.7%
7	**2**	Баянхонгор	84779	83937	-842	-1.0%	22066	23837	1771	8.0%
8	**3**	Булган	61776	58481	-3295	-5.3%	16239	15414	-825	-5.1%
9	**4**	Орхон	71525	82018	10493	14.7%	68310	75347	7037	10.3%
10	**5**	Өвөрхангай	111420	107801	-3619	-3.2%	19058	20657	1599	8.4%
11	**6**	Хөвсгөл	119063	124126	5063	4.3%	31489	38957	7468	23.7%
			545594	**550992**	**5398**	**1.0%**	**175681**	**192040**	**16359**	9.3%
Төвийн бүс										
12	**1**	Говьсүмбэр	12230	12519	289	2.4%	8983	7356	-1627	-18.1%
13	**2**	Дархан-Уул	83271	89857	6586	7.9%	65791	73281	7490	11.4%
14	**3**	Дорноговь	50575	51567	992	2.0%	25210	27351	2141	8.5%
15	**4**	Дундговь	51517	50999	-518	-1.0%	14517	14017	-500	-3.4%
16	**5**	Өмнөговь	46858	47821	963	2.1%	14183	14506	323	2.3%
17	**6**	Сэлэнгэ	99950	93700	-6250	-6.3%	56446	29798	-26648	-47.2%
18	**7**	Төв	99268	92816	-6452	-6.5%	16227	17758	1531	9.4%
			443669	**439279**	**-4390**	**-1.0%**	**201357**	**184067**	**-17290**	-8.6%
Зүүн бүс										
19	**1**	Дорнод	75373	72670	-2703	-3.6%	41714	36356	-5358	-12.8%
20	**2**	Сүхбаатар	56166	54585	-1581	-2.8%	15133	11289	-3844	-25.4%
21	**3**	Хэнтий	70946	68135	-2811	-4.0%	27853	27700	-153	-0.5%
			202485	**195390**	**-7095**	**-3.5%**	**84700**	**75345**	**-9355**	-11.0%
Улаанбаатар бүс										
22	**1**	Улаанбаатар	760077	869912	109835	14.5%	760077	869912	109835	14.5%
БҮГД			**2373433**	**2476644**	103211	**4.3%**	**1344516**	**1445831**	**101315**	7.5%

МУ-ын хүн амын бичиг үсгийн тайлагдалт 97.6 хувьтай байна. Бичиг үсэг мэдэхгүй нийт хүн амын 30 хувь нь хот, суурин газарт амьдарч байгаа бөгөөд тэдгээрийн 43 хувь нь 10-19 насны голдуу эрэгтэй хүүхэд, залуучууд байна. Бичиг үсэг мэдэхгүй хүн амын 10 хувь нь Улаанбаатар, 15 хувь нь Дархан, Эрдэнэт хотуудад оршин сууж байна.

Хотын эрэгтэй хүн амын 60.2 хувь, харин эмэгтэйчүүдийн 47.9 хувь эдийн засгийн идэвхтэй байна. ҮСГ-ын Ажиллах хүчний судалгаагаар улсын хэмжээний ажилгүйдлийн түвшин 14.2 хувь байна. Энэ нь хот суурин газарт илүү их 18.7 хувь, хөдөөд бага 10 хувь байна. Улаанбаатар хотод гэхэд 31.200 ажилгүйчүүд байгаа нь нийт улсын хэмжээний ажилгүйчүүдийн 22 хувь байна. Улсын хэмжээний ажилгүй 5 хүнийг нэгээс илүү нь Төвийн бүсэд байхад Зүүн бүсэд 10.8 хувь байна.

3. Хот, суурин газрын эдийн засгийн үйл ажиллагаа

Өмнөх онуудтай харьцуулахад цаг агаарын таатай нөхцөл бүрдсэнээс ДНБ-ний өсөлт 2001 онд 1 хувь, 2002 онд 4 хувь байсан бол 2003 онд 5.5 хувь болж өссөн байна. 2001, 2002 оны өвөл болсон зуд гамшгийн улмаас ХАА-н 2001 онд –10.6 хувь, 2002 онд -17.1 хувьд хүрсэн бол 2003 онд сэргэж 5.3 хувь болжээ. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2001 онд 7.4 хувь, 2002 онд 3.8 хувь тус тус өсч байсан бол 2003 онд дөнгөж 1.8 хувиар өссөн (1995 оны суурь үнээр) байна. ОХУ-д төлөх өрийг шийдвэрлэсэн, хувьчлалын хөтөлбөрийн явц, гадаадын хөрөнгө оруулалт, улсын экспортын гол бүтээгдэхүүний үнийн өсөлт зэрэг хүчин зүйлээс хамаарч Монголын эдийн засаг 2004, 2005 онуудад тодорхой хэмжээгээр сайжирна гэж АХБ үзэж байна.

Үйлчилгээний салбар нь ДНБ-ний 50 гаруй хувийг бүрдүүлдэг. Барилга болон үйлчилгээний салбарын өсөлтийг нийслэл хотын хурдацтай хөгжилтэй уялдуулан соёлч боловсон үйлчилгээг нэмэгдүүлэх замаар хангахаар төлөвлөжээ. Барилгын салбарын хувьд авч үзвэл, 2003 онд барилгын компаниуд нийт 131.9 тэрбум төгрөгийн барилга угсралт, их засварын ажил хийж гүйцэтгэсэн нь өмнөх оныхоос 38.3 хувиар өсчээ. Нийт гүйцэтгэсэн ажлын 70 орчим хувийг дотоодын барилгын компаниуд, 30 хувийг гадаадын барилгын компаниуд эзэлж байна.

2003 онд 34 банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) шинээр байгуулагдсан бол таван ББСБ татан буугдсан байна. Ийнхүү, жилийн эцсийн байдлаар 17 арилжааны банк, 88 ББСБ үйл ажиллагаагаа явуулж байна. 2003 онд хадгаламж 363.3 тэрбум төгрөг болж, зээлийн хэмжээ 442.1 тэрбум төгрөгт хүрсэн. Энэ нь өмнөх 2002 оныхоос хадгаламж 66.4 хувиар, зээл 91 хувиар өссөнийг харуулж байна.

ҮСГ-аас явуулсан Ажиллах хүчний судалгаагаар (АХС) 2002 оны 10 сараас 2003 оны 9 дүгээр сарын хооронд МУ-д ажил эрхэлж буй нийт хүний тоо 862,500 байсан бөгөөд түүний 45,5 хувь буюу 392,300 нь хот суурин газарт байна. Мөн хугацаанд ажиллах хүчний оролцооны түвшин (АХОТ) буюу эдийн засгийн идэвхтэй хүн амыг хөдөлмөрийн насны хүн амд харьцуулсан хувь 65,3 байна. Энэ үзүүлэлт хөдөө орон нутагт 76 хувь, хот суурин газарт 56 хувь байна. Хот суурин газарт их дээд сургуульд суралцагсдын тоо өндөр байгаа нь АХОТ доогуур байхад нөлөөлж байна. Зах зээлийн эдийн засгийн шилжилтийн үеийн хүн амын ажил эрхлэлт болон АХОТ-г Хүснэгт 3.1.-д үзүүлэв.

Хүснэгт 3.1 МУ-ын хүн, ажил эрхлэлт ба АХОТ (мян., хувиар)

	1992			1995			1999			2000			2003		
	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд	Эр	Эм	Бүгд
Хөдөлмөрийн насны хүн ам	565.3	569.3	1134.6	596.3	590.4	1186.7	642.3	637	1279.3	697.9	676.5	1374.4	723.5	765.4	1488.9
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	446.1	413.9	860	428.5	384.2	812.7	445.1	408.3	853.4	434.8	412.8	847.6	523.5	481.3	1004.8
Ажиллагсад	421.1	384.9	806	407	360.6	767.6	426.9	386.7	813.6	416.9	392.1	809	448.9	413.6	862.5
Ажилгүйчүүд	25	29	54	21.5	23.6	45.1	18.2	21.6	39.8	17.9	20.7	38.6	74.6	67.7	142.3

АХОТ (%)	78.9	72.7	75.8	71.9	65.1	68.5	69.3	64.1	66.7	62.3	61.0	61.7	69.7	61.1	65.3
Ажил эрхлэлтийн түвшин (%)	74.5	67.6	71.0	68.3	61.1	64.7	66.5	60.7	63.6	59.7	58.0	58.9	62.0	54.0	57.9
Ажилгүйдлийн түвшин (%)	5.6	7.0	6.3	5.0	6.1	5.5	4.1	5.3	4.7	4.1	5.0	4.6	14.2	14.1	14.2

Эх үүсвэр: ҮСГ, МУ-ын статистикийн эмхтгэл1999, 2000. ҮСГ, АХС 2003.

Мал аж ахуй нь ХАА-н салбарын зонхилох үйл ажиллагаа бөгөөд энэ салбарт ажиллаж буй хүмүүс нийт ажиллагсдын тал хувийг эзэлж байна. Хүснэгт 3.2-д харуулснаар 1995-2000 оны хооронд энэ салбарт ажил эрхэлж буй хүмүүсийн тоо өссөн боловч 2000 оноос хөдөөнөөс хот руу шилжих хөдөлгөөн нэмэгдсэний улмаас энэ тоо буурсаар байна.

Худалдаа, үйлчилгээний салбарт ажиллагсдын тоо нэмэгдсэн бөгөөд нийт хүн амын 11,4 хувийг энэ салбарт ажил эрхэлж буй хүмүүс эзэлж байна. Харин боловсруулах салбарт ажиллагсдын тоо аажмаар буурсаар байна. Уг салбарт ажил эрхэлж буй хүний тоо, эзлэх хувь аль аль нь буурсан байна.

Хот суурин газарт албан салбар 1995 оноос эрчимтэй хөгжиж эхэлсэн. Албан бус салбарын үйл ажиллагааны дийлэнх буюу 70,9 хувь нь хот суурин газарт байна.

ДБ-аас Улаанбаатар хотын албан бус эдийн засгийн талаар гаргасан тайланд тусгаснаар албан бус үйл ажиллагаа явуулж буй хотын өрхийн 15 хувь нь амьжиргааны доод түвшингээс дээгүүр амьдарч байна

Хүснэгт 3.2 Ажил эрхлэлт эдийн засгийн гол үйл ажиллагааны салбараар (мян., хувиар)

	1995		2000		2003	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Хөдөө аж ахуй, агнуур,ойн аж ахуй	354.2	46.1	393.5	48.6	402.7	46.7
Уул уурхай, олборлох	18.2	2.4	18.6	2.3	23.3	2.7
Аж үйлдвэр	67.3	8.8	54.6	6.7	46.2	5.4
Цахилгаан, хий, ус	22.6	2.9	17.8	2.2	15.8	1.8
Барилга	29.5	3.8	23.4	2.9	17.5	2.0
Бөөний, жижиглэнгийн худалдаа, засвар үйлчилгээ	64.8	8.4	83.9	10.4	98.1	11.4
Зочид буудал, зоогийн газар	13.7	1.8	13.3	1.6	13.7	1.6
Тээвэр, агуулах,харилцаа холбоо	31.6	4.1	34.1	4.2	51.0	5.9
Санхүүгийн үйлчилгээ	8.3	1.1	6.8	0.8	6.3	0.7
Үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнес	6.7	0.9	7.2	0.9	10.1	1.2
Төрийн захиргаа, батлан хамгаалах	31.1	4.1	34.7	4.3	52.1	6.0
Боловсрол	48.5	6.3	54.4	6.7	63.3	7.3
Эрүүл мэнд ба нийгмийн хамгаалал	38.1	5.0	33.5	4.1	38.0	4.4
Олон нийт, нийгмийн, хувийн үйлчилгээ	26.6	3.5	29.0	3.6	22.3	2.6
Бусад	6.4	0.8	4.2	0.5	2.1	0.2
Бүгд	767.6	100.0	809.0	100.0	862.5	100.0

Эх үүсвэр: ҮСГ, МУ-ын статистикийн эмхтгэл 2000, Ажиллах хүчний судалгаа 2003

4. Хот суурин газрын ядуурал

Улаанбаатар хот 27.3 хувьтайгаар ядууралд хамгийн бага нэрвэгдсэн гэж тооцогдлоо. Аймгийн төвийн ядуурлын түвшин дунджаар 33.9 хувь байна. Улаанбаатар хотын ядуучуудын 90 хувь нь гэр хорооololд амьдардаг бол аймгийн төвүүдэд энэ тоо 80 хувь байна. Суурин газрын ядуу бус өрхүүдийн тал нь төвийн холболттой цэвэр усны эх үүсвэрээс усаа авах боломжтой байхад ядуучуудын ердөө дөрөвний нэг нь л тийм боломжтой байна.

ҮСГ-аас нийтэлсэн сүүлийн үеийн мэдээллийн дагуу МУ-ын нийт хүн амын 36.1 хувь нь бүсчлэлийн байршлаас хамаарч 20,200-26,500 төгрөгийн хооронд хэлбэлзэх амьжиргааны доод түвшнээс доогуур амьдарч байна. Хот хөдөөгийн хүмүүсийн амьдралд чанарын ялгаа маш их байгаа нь бас харагдаж байна. Хөдөөд ядуурал хамаагүй их байна. 1998 онд хотын ядуурал (39.4 хувь) хөдөөгийн ядуурлаас (32.6 хувь) их байсан бол 2003 онд хөдөө орон нутагт ядуурал 43 хувь, харин хот суурин газарт 30 хувь болсон байна.

Халаалтын асуудал ч бас ядуу баяны ялгааг тодорхойлох нэг хүчин зүйл болж байна. Гэр хорооллын нэг өрх жилд 5 -10 тонн нүүрс хэрэглэж, тонн бүрт нь 24,000 төгрөг төлдөг. ҮСГ-аас гаргасан “Өрхийн Орлого, Зарлага, Амьжиргааны түвшний түүвэр судалгааны үндсэн тайлан”-гаас харахад (2002-2003 он) дундаж ядуу бус өрхийн нийт зарлагын 3 хувийг халаалтын хөлс эзэлж байгаа бол ядуу өрхийнх 5 хувь байна. Хотод энэ зөрүү бүр ч их байна. Жишээ нь Улаанбаатарын ядуу бус өрх нийт зарлагын 3 хувийг халаалтын хөлсөнд зарцуулж байхад ядуу өрх 10 хувийг зарцуулж байгаа бөгөөд аймгийн төвүүдийн хувьд энэ үзүүлэлт тус бүр 4, 7 хувь байна. Эндээс харахад хот суурин газарт амьдардаг ядуу өрхөд халаалтын зардал том дарамт болж байна.

Шилжин нүүж байгаа хүмүүсийн 60 хувь нь Улаанбаатар хотод ирж суурьшсан байна. НҮБ-ын ХХ-өөс явуулсан судалгааны дагуу Улаанбаатар хот руу шилжин ирэгчдийн 39 хувь нь нэн ядуу амьдралтай хүмүүс байна[2]. Улаанбаатарт шилжин ирэгсдийн олонх буюу 80 хувь нь гэр хорооololд амьдарч байгаа нь хотын нийт гэр хорооллын хүн амын 45 хувийг эзэлж байна.

5. Засаглал ба институцийн хүрээ

БХБЯ үйл ажиллагааныхаа хүрээнд дараах үүргийг хүлээнэ, үүнд:

3. ЗГ-ын мөрийн хөтөлбөр, жил бүрийн НЭЗХҮЧ-ийн биелэлт;
4. Ерөнхий сайд, Танхимд үзүүлэх мэргэжлийн зөвлөлгөө, дэмжлэг туслалцаа;
5. Хот байгуулалтын төлөвлөгөө боловсруулах, зохицуулах, хэрэгжүүлэх, хяналт тавих;
6. Барилга, хот байгуулалтын салбарыг төсвийн тэнцвэртэй удирдлагаар хангах юм.

[2] НҮБ-н Хөгжлийн Хөтөлбөр, Хот суурин газрын ядуурал ба шилжин ирэх хөдөлгөөн , 2004 он.

Зураг 5.1 БХБЯ-ны үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл ба зорилт



Хүснэгт 5.1-д харуулсан БХБЯ-ны тэргүүлэх чиглэл ба зорилтууд тодорхой боловч орон нутгийн засаг захиргаа, ялангуяа нийслэлийн хотын түвшинд тогтсон харилцаа холбоо нэлээд тодорхой бус байна. Хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах эрхийг хэрэгжүүлнэ:

A. Хот байгуулалтын төрийн бодлогыг хэрэгжүүлж, хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, бүс нутгийн хөгжлийн төсөл, салбарын хөгжлийн ерөнхий төсөл, хот тосгоны ерөнхий төлөвлөгөөний харилцан уялдааг зохицуулж, хэрэгжилтэд хяналт тавих;
B. Хот байгуулалтын тухай хууль тогтоомж, дүрэм, журам, норм, стандартын биелэлтэд хяналт тавих;
C. Аж ахуйн нэгж байгууллагад хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрх олгох;
D. Хот байгуулалтын баримт бичигт улсын экспертизийн дүгнэлт гаргах
E. Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахтай холбогдсон журам батлаж мөрдүүлэх.

Түүнчлэн аймаг, нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал дараах эрхийг хэрэгжүүлнэ:

A. Аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээний хот байгуулалтын баримт бичиг боловсруулах талаар шийдвэр гаргах, уг баримт бичгийг батлах;
B. Хот байгуулалтын баримт бичгийг хэрэгжүүлэхэд орон нутгийн төсвөөс гаргах шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг зохицуулан шийдвэрлэх;
C. Хот байгуулалтын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай гэж үзвэл энэ талаар засаг даргын тайланг хэлэлцэх;
D. Хот, тосгоны хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт, барилга байгууламжийн газар олголт, техникийн нөхцлийн үндэслэл, бүрдэл, гүйцэтгэлд хяналт тавих.

Эдгээрээс харахад зарим байгууллагын үүрэг, функцийн давхардал байна. Аймгийн болон сумын түвшинд захиргааны байгууллагын үүрэг функци давхардаж байгаа нь мөн харагдаж байна. Суманд үйлчилгээ хүргэх нь ихэнхи тохиолдолд өндөр өртөгтэй байгааг харгалзвал захиргааны болон үйлчилгээ хүргэх үүрэг функцийг аймгийн дэд түвшинд нэгтэх шаардлага байна.

6. Хотын дэд бүтцийн байдал

Гэр хороолол болон орон сууцны хорооллын оршин суугчдын хоорондд дэд бүтцийн үйлчилгээний хангамж эрс тэс ялгаатай байна. Гэр хороололд амьдардаг өрхүүдийн 90 гаруй хувь нь цахилгаан хангамжтай боловч дийлэнх хувь нь төвлөрсөн дулааны шугам сүлжээнд холбогдоогүй учраас хоол унд болон дулааны үүсвэрт нүүрс, аргал болон модоор халаадаг зуухыг ашигладаг. Гэр хороололд усыг машинаар зөөвөрлөн усан түгээх байранд шахдаг бөгөөд зарим айлууд 1 хүртэл километрийн зайтай газраас усаа авдаг байна. Ихэнх гэр хороололд амьдардаг айл өрхүүд ундны усаа ойрхон гол, булаг шандаас авч хэрэглэдэг. Гэр хороололд оршин сууж буй нэг хүнд өдөрт ноогдож байгаа усны хэмжээ 4.6 литр байгаа нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас тогтоосон стандартаас нэлээд доогуур байна. Түүнчлэн усан сангаас авдаг усны үнэ нь төвлөрсөн шугаманд холбогдсон орон сууцанд амьдардаг өрхийн усанд төлдөг үнээс даруй 20 дахин үнэтэй байна. Гэр хороололд амьдардаг өрхүүд төвлөрсөн бохирын системд холбогдоогүй улмаас дийлэнх нь өөрсдийн хашаандаа бохир/муу усны нүхтэй бөгөөд айл өрхийн 70 гаруй хувь нь бохироо татан зайлуулах боломжгүй байна.

Орон сууцны өрхүүд гэр хорооллын өрхүүдтэй харьцуулахад дэд бүтцийн үйлчилгээний хангамж илүү сайн хүртдэг, гэвч орон сууцны дэд бүтцийн шугам

сүлжээ ялангуяа аймаг орон нутагт өнөөдрийн байдлаар нэлээд хуучирч, мууджээ. Түүнчлэн дэд бүтэц нь технологийн хувьд хоцрогдсоноос гадна сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд засвар үйлчилгээ тогтмол хийгдээгүйгээс үр ашигтай ажиллаж чадахгүйд хүрээд байна. Тухайлбал хэд хэдэн аймагт усны алдагдал 30-56 хувьтай байгаа нь одоо ашиглаж буй дэд бүтцийн шугам сүлжээ хот суурин газрын цаашдын хөгжилд нэлээд бэрхшээл учруулах юм.

Нийтийн аж ахуйн үйлчилгээний дэд бүтцийн талаарх Улаанбаатар хот болон аймгуудын дүнг нэгтгэсэн тоон үзүүлэлтийг Хүснэгт 7.1-д харууллаа.

Хүснэгт 6.1. Хот суурин газрын дэд бүтцийн үзүүлэлтүүд

Нэр төрөл	Хэмжих нэгж	2000 он	2001 он	2002 он	2003 он
Төвлөрсөн усан хангамжийн системд холбогдсон хүний тоо	Хүн	535,130	642,156	770,587	924,704
Зөөврийн усаар хангагддаг хүний тоо	Хүн	624,109	790,356	801,240	801,000
Дүн	Хүн	1,159,239	1,432,512	1,571,827	1,725,704
Ус түгээх цэгийн тоо	Ш	578	623	692	725
Гүний худгийн тоо	Ш	297	315	324	327
Цэвэр усны өргөх станцын тоо	Ш	56	54	53	53
Хүчин чадал	м3/хон	12,698,100	19,568,160	17,770,160	27,770,160
Шугам хоолойн урт	Км	1881.5	1885.0	1899.7	1912.6
-Цэвэр усны	Км	1196.3	1199.9	1214.5	1220.9
-Бохир усны	Км	685.2	685.2	685.2	691.7
Цэвэрлэх байгууламжийн хүчин чадал	м3/хон	290,000	291,000	291,000	291,000
Шугам хоолойгоор борлуулсан цэвэр ус	м3/жил	86,855,450	82,879,820	73,401,220	74,350,000
-Хүн амд	м3/жил	66,659,430	64,583,870	55,325,870	56,037,590
-Үйлдвэр аж ахуйн газарт	м3/жил	20,196,020	18,295,050	18,075,350	18,312,400
Зөөврөөр борлуулсан цэвэр ус	м3/жил	1,137,720	3,088,860	3,213,990	3,125,000
-Хүн амд	м3/жил	1,009,680	2,682,550	2,803,610	2,713,620
-Үйлдвэр аж ахуйн газарт	м3/жил	128,040	406,310	410,380	411,385
Шугам хоолойгоор зайлуулсан бохир ус	м3/жил	79,485,200	78,940,200	79,430,600	80,350,000
-Хүн амаас	м3/жил	64,386,400	64,429,500	64,107,000	64,802,650
-Үйлдвэр аж ахуйн газраас	м3/жил	15,088,800	14,510,700	15,323,600	15,547,350
Машин механизмын тоо	Ш	291	329	341	344
-Тусгай зориулалтын	Ш	157	202	200	202
-Хог тээврийн	Ш	20	25	25	26
Нийтийн халуун усны газар	Тоо	59	113	183	237

Эх үүсвэр: Барилга хот байгуулалт, нийтийн аж ахуйн хөгжлийг дэмжих төв (хуучнаар Барилга хот байгуулалт, нийтийн аж ахуйн газар)

7. Орон сууцны нөхцөл байдал

Орон сууцны нөхцөл байдлын талаархи тоо мэдээллийг 2000 оны хүн ам, орон сууцны тооллогын дүнгээс авч дараах гурван хүснэгтэд нэгтэн харуулав. 2000 оны хүн ам, орон сууцны тооллогоор МУ-д нийтдээ 541,149 өрх байгаа гэсэн дүн гарчээ. (Хүснэгт 7.1.) Үүнээс 296,398 өрх буюу нийт өрхийн 54,8

хувь нь хот суурин газарт амьдарч байна. Хот суурин газрын өрхийн 72 хувь нь тохиромжийн орон сууцанд (нийтийн болон амины орон сууц, 4 улирлын турш амьдардаг гэр хорооллын байшин орсноор) амьдардаг бөгөөд үүнээс 38 хувь нь нийтийн орон сууцанд (appartments) амьдарч байна.
2000 оны хүн ам, орон сууцны тооллогоор хамгийн олон хүн амтай 25 хот суурин газрыг тогтоожээ. (Хүснэгт 7.2.) Хот суурин газрыг хүн амын тоогоор эрэмбэлхэд хамгийн их 760,077 мянган хүнтэй Улаанбаатар байхад хамгийн цөөн 9,208 хүн амтай Ногооннуур сум байна.

Улаанбаатар, Эрдэнэт, Дархан, Чойбалсан болон Мөрөн зэрэг МУ-ын хамгийн том 5 хот болон үлдэж буй бусдыг нэгтгэн орон сууцны нөхцөл байдлын талаарх тоо мэдээг түүвэрчлэн Хүснэгт 7.3 –д үзүүлэв.

Дээрх 5 аймагт нийт хүн амын 39 хувь, тохиромжийн орон сууцны 62 хувь, нийтийн орон сууцны 81 хувь бөгөөд гэр сууцны зөвхөн 16 хувь ногдож байна. МУ-ын бусад аймгийн төвүүдтэй харьцуулахад дээрх хот суурин газарт төвлөрсөн дулаан хангамж, дэд бүтцийн үйлчилгээг харьцангуй өндөр юм. Бусад аймгийн төвүүдтэй харьцуулахад төвлөрсөн халаалтын үйлчилгээ (тохиромжийн орон сууцанд амьдардаг өрхийн 62,1 хувь байхад бусад аймгийн нэгтгэсэн дүнгээр 15,4 хувь), шугман хоолойгоор дамжих халуун, хүйтэн усан хангамж (58,9 – 9 хувь), дотроо угаалгын өрөөтэй (58,9 -15,5 хувь), дотроо жорлонтой (61,5 17,7 хувь) зэрэг үзүүлэлтээр хамаагүй дээгүүр юм.

Хүснэгт 7.1. Орон сууцны нөхцөл байдал

ЭДИЙН ЗАСГИЙН МУЖУУД			Нийт өрх	Хотын өрх	Хотын өрх хувиар	Тохиромжийн орон сууц	Тохиромжийн орон сууцанд суудаг хотын хотын өрх хувиар	Нийтийн орон сууцанд амьдардаг хотын өрх	Нийтийн орон сууцанд амьдардаг хотын өрх хувиар	Гэр болон амины байшинд амьдардаг өрх	Ус, бохир, цахилгаанд холбогдсон хотын өрх	Ус, бохир, цахилгаанд холбогдсон хотын өрх хувиар
Баруун бүс												
1	**1**	Баян-Өлгий	19270	5799	30.1%	5584	96.3%	452	7.8%	5347	419	7.2%
2	**2**	Говь-Алтай	14796	4034	27.3%	1049	26.0%	418	10.4%	3616	436	10.8%
3	**3**	Завхан	21605	5600	25.9%	2414	43.1%	649	11.6%	4951	430	7.7%
4	**4**	Увс	20307	5729	28.2%	1232	21.5%	629	11.0%	5100	633	11.0%
5	**5**	Ховд	18146	5267	29.0%	2191	41.6%	756	14.4%	4511	1006	19.1%
			94124	**26429**	**28.1%**	**12470**	**47.2%**	**2904**	**11.0%**	**23525**	**2924**	11.1%
Хангайн бүс												
6	**1**	Архангай	24396	4373	17.9%	2567	58.7%	565	12.9%	3808	434	9.9%
7	**2**	Баянхонгор	20630	5098	24.7%	1494	29.3%	635	12.5%	4463	618	12.1%
8	**3**	Булган	15427	4024	26.1%	3034	75.4%	455	11.3%	3569	349	8.7%
9	**4**	Орхон	17332	16516	95.3%	13593	82.3%	9297	56.3%	7219	10154	61.5%
10	**5**	Өвөрхангай	26896	4443	16.5%	1217	27.4%	578	13.0%	3865	576	13.0%
11	**6**	Хөвсгөл	28692	7374	25.7%	3186	43.2%	596	8.1%	6778	500	6.8%
			133373	**41828**	**31.4%**	**25091**	**60.0%**	**12126**	**29.0%**	**29702**	**12631**	30.2%
Төв бүс												
12	**1**	Говь-Сүмбэр	2954	2148	72.7%	1308	60.9%	586	27.3%	1562	528	24.6%
13	**2**	Дархан-Уул	19489	15305	78.5%	13759	89.9%	10429	68.1%	4876	10884	71.1%
14	**3**	Дорноговь	12111	5981	49.4%	4366	73.0%	2113	35.3%	3868	2196	36.7%
15	**4**	Дундговь	12276	3333	27.2%	933	28.0%	389	11.7%	2944	356	10.7%
16	**5**	Өмнөговь	11633	3373	29.0%	1160	34.4%	501	14.9%	2872	610	18.1%
17	**6**	Сэлэнгэ	22814	13017	57.1%	11429	87.8%	4263	32.7%	8754	3509	27.0%
18	**7**	Төв	23638	3792	16.0%	2397	63.2%	1093	28.8%	2699	1026	27.1%
			104915	**46949**	**44.7%**	**35352**	**75.3%**	**19374**	**41.3%**	**27575**	**19109**	40.7%
Зүүн бүс												
19	**1**	Дорнод	17215	9652	56.1%	7934	82.2%	3816	39.5%	5836	4015	41.6%
20	**2**	Сүхбаатар	12780	3570	27.9%	1507	42.2%	582	16.3%	2988	429	12.0%
21	**3**	Хэнтий	17469	6697	38.3%	3998	59.7%	1951	29.1%	4746	2271	33.9%
			47464	**19919**	**42.0%**	**13439**	**67.5%**	**6349**	**31.9%**	**13570**	**6715**	33.7%
Улаанбаатар бүс												
22	**1**	Улаанбаатар	161273	161273	100.0%	126115	78.2%	72264	44.8%	89009	76678	47.5%
		ДҮН	**541149**	**296398**	**54.8%**	**212467**	**71.7%**	**113017**	**38.1%**	**183381**	**118057**	39.8%

Хүснэгт 7.2 Хамгийн олон хүн амтай 25 суурин

	ХОТ / СУМЫН НЭР	Сум харъяалагдах аймаг	Сумын статус	Сум харъяалагдах бүс	Нийт хүн амын тоо	Нийт хүн ам хувиар	Хотын хүн ам хувиар
	Дүн				2373403		1344516
1	**Улаанбаатар**		Нийслэл		760077	32.0%	56.5%
2	**Баян-Өндөр (Эрдэнэт)**	Орхон	Аймгийн төв	Хангай	68310	2.9%	5.1%
3	**Дархан**	Дархан-Уул	Аймгийн төв	Төв	65791	2.8%	4.9%
4	**Хэрлэн (Чойбалсан)**	Дорнод	Аймгийн төв	Зүүн	40123	1.7%	3.0%
5	**Мөрөн**	Хөвсгөл	Аймгийн төв	Хангай	28903	1.2%	2.1%
	Эхний тав				**963204**	**40.6%**	**71.6%**
6	**Улаангом**	Увс	Аймгийн төв	Баруун	25993	1.1%	1.9%
7	**Өлгий**	Баян-Өлгий	Аймгийн төв	Баруун	25791	1.1%	1.9%
8	**Жаргалант**	Ховд	Аймгийн төв	Баруун	25765	1.1%	1.9%
9	**Мандал**	Сэлэнгэ	Сум	Төв	23964	1.0%	1.8%
10	**Сүхбаатар**	Сэлэнгэ	Аймгийн төв	Төв	22374	90.0%	1.7%
	Эхний арав				**1087091**	**45.8%**	**80.9%**
11	**Баянхонгор**	Баянхонгор	Аймгийн төв	Хангай	22066	0.9%	1.6%
12	**Арвайхээр**	Өвөрхангай	Аймгийн төв	Хангай	19058	0.8%	1.4%
13	**Эрдэнэбулган**	Архангай	Аймгийн төв	Хангай	18519	0.8%	1.4%
14	**Сайншанд**	Дорноговь	Аймгийн төв	Төв	18290	0.8%	1.4%
15	**Улиастай**	Завхан	Аймгийн төв	Баруун	18154	0.8%	1.4%
16	**Хэрлэн (Өндөрхаан)**	Хэнтий	Аймгийн төв	Зүүн	18003	0.8%	1.3%
17	**Есөнбулаг**	Говь-Алтай	Аймгийн төв	Баруун	15741	0.7%	1.2%
18	**Баруун-Урт**	Сүхбаатар	Аймгийн төв	Зүүн	15133	0.6%	1.1%
19	**Зуунмод**	Төв	Аймгийн төв	Төв	14837	0.6%	1.1%
20	**Сайнцагаан**	Дундговь	Аймгийн төв	Төв	14517	0.6%	1.1%
21	**Даланзадгад**	Өмнөговь	Аймгийн төв	Төв	14050	0.6%	1.0%
22	**Хархорин**	Өвөрхангай	Сум	Хангай	13964	0.6%	1.0%
23	**Булган**	Булган	Аймгийн төв	Хангай	12684	0.5%	0.9%
24	**Бунай**	Завхан	Сум	Баруун	9776	0.4%	0.7%
25	**Ногооннуур**	Баян-Өлгий	Сум	Баруун	9208	0.4%	0.7%
	Эхний хорин тав				**1321091**	**55.7%**	**98.3%**

Хүснэгт 7.3 Таван том суурин газар болон бусад нутгийн орон сууцны нөхцөл байдал

Нэр төрөл	Улаанбаатар	Орхон аймгийн Баян-Өндөр сум (Эрдэнэт)	Дархан-Уул аймгийн Дархан сум	Дорнод аймгийн Хэрлэн сум (Чойбалсан)	Хөвсгөл аймгийн Мөрөн сум	Таван хотын нутаг дэвсгэр	Бусад нутаг дэвсгэр	Нийт өрх
Орон сууцны төрөл								
Нийт өрхийн тоо	161273	16516	15305	9285	6669	209048	332101	541149
Өрх тоо, хувиар	29.8	3.1	2.8	1.7	1.2	38.6	61.4	100.0
Тохиромжийн орон сууц								
Тохиромжийн орон сууцны тоо	126043	13595	13760	7606	2862	163866	101679	265545
Өрхийн тоо, хувиар	78.2	82.3	89.9	81.9	42.9	78.4	30.6	49.1
Нийтийн орон сууц								
Нийтийн орон сууцны тоо	72223	9299	10430	3689	590	96230	22776	119006
Тохиромжийн орон сууцанд эзлэх %	57.3	68.4	75.8	48.5	20.6	58.7	22.4	44.8
Амины орон сууц								
Амины орон сууцны тоо	48274	3847	3000	3529	2178	60829	73006	133834
Тохиромжийн орон сууцанд эзлэх %	38.3	28.3	21.8	46.4	76.1	37.1	71.8	50.4
Гэр								
Гэрийн тоо	35230	2921	1545	1679	3807	45182	230422	275604
Өрх, хувиар	21.8	17.7	10.1	18.1	57.1	27.6	69.4	50.9
Үйлчилгээний түвшин								
Цахилгаантай Тохиромжийн орон сууцны %	99.3	99.0	99.4	90.5	97.5	97.2	82.0	92.4
Төвлөрсөн халаалттай Тохиромжийн орон сууцны %	60.4	76.3	80.1	55.9	6.7	62.1	15.4	44.3
Халуун, хүйтэн устай Тохиромжийн орон сууцны %	57.4	72.7	75.1	50.6	0.0	58.9	9.0	39.8
Шугамын хүйтэн устай Тохиромжийн орон сууцны %	3.9	3.4	5.4	3.9	17.7	3.9	9.9	6.4
Худгаас усаа авдаг Тохиромжийн орон сууцны %	34.1	20.6	13.2	29.7	74.2	30.5	33.9	32.6
Дотор угаалгын өрөөтэй Тохиромжийн орон сууцны %	57.9	71.7	74.2	45.8	18.6	58.9	15.5	42.4
Гадуурх угаалгын өрөө Тохиромжийн орон сууцны %	40.9	27.6	25.0	53.5	81.0	38.4	83.8	56.6
Бие засах өрөө дотроо Тохиромжийн орон сууцны %	60.2	73.8	79.1	51.9	23.6	61.5	17.7	45.0
Бие засах газар гадаа Тохиромжийн орон сууцны %	37.5	23.7	18.9	43.5	71.2	34.5	81.1	53.1

8. Хотын хөрөнгө оруулалт ба санхүү

Төсвийн үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог өргөтгөж, нэмэгдүүлэх зорилгоор Улсын Их хурлаас Төсвийн Байгууллагын Удирдлага Санхүүжилтийн хуулийг (ТБУСХ) 2002 оны 6-р сард баталж, 2003 оны 1-р сараас хэрэгжүүлж эхэлсэн. ТБУСХ нь улсын санхүү болон төсвийн явцыг тодорхой болгож өгсөн бөгөөд үүнийг Төрийн захиргааны өөрчлөлт, шинэчлэлийн хөтөлбөрийн хүрээнд дөрвөн жил гаруй хугацаанд боловсруулсан байна. Энэ нь сумаас аймаг, аймгаас ЗГ гэсэн доороос дээш чиглэсэн хуучин арга барилыг доороос дээш болон дээрээс доош чиглэсэн хосолсон аргаар өөрчилсөн. Энэ хууль нь (i) улсын санхүү ба төсвийн явцыг сайжруулах, (ii) төрийн захиргааны өөрчлөлт, шинэчлэл гэсэн үндсэн хоёр хэсгээс бүрдэнэ. Хоёр дахь хэсэг нь өмнө нь хэрэгжиж байсан төрийн захиргааны өөрчлөлт, шинэчлэлийн хөтөлбөртэй холбоотой юм.

ТБУСХ-аар тодорхойлсон төсөв боловсруулах үе шат, хугацааг Хүснэгт 8.1-д харуулж, энд нэгтгэн дүгнэлээ. Төсөв боловсруулах үйл ажиллагаа нь үндсэн хоёр үе шаттай, эхний үе шатанд төсвийн төсөл, саналыг багтаасан Төсвийн Хүрээний Мэдэгдэл (ТХМ) боловсруулж, хоёр дахь үе шатанд Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө (ҮАХТ), Сангийн Яамнаас баталсан Төсвийн Ерөнхийлэн Захирагч (ТЕЗ) нарын төсөвт үндэслэн боловсруулсан төсвийн төлөвлөгөөг боловсруулна.

ТБУСХ-д тусгагдсан төсвийн шинэ явц нь аймаг орон нутгийн санхүүжилтэнд мөн нөлөөлсөн. ТБУСХ хэрэгжиж эхэлснээр 2002 оноос 2003 оны хооронд томоохон өөрчлөлт гарсныг Хүснэгт 8.2-оос харж болно. Үүгээр, орон нутагт төсөв нь (i) орон нутгийн төсвийн орлого, (ii) орон нутгийн төсболсоноорчиглэсэн" төсөв боловсруулж, баталдаг байсан хуучин тогтолцоог өөрчилж байгаа гол өөрчлөлт юм. Тухайлбал /Хүснэгт 8.2/, 2003 оноос өмнө нь орон нутгийн орлого ба төсвийн байгууллагуудын зардлыг тооцсон орон нутгийн зардлын зөрүүг улсын төсвөөс нөхөж татаас олгож байсан бөгөөд энэ нь 2002 онд 38 %-тай байсан байна. Харин 2003 оноос ТЕЗ-ын улсын төсвийн зардалд орон нутагт зарцуулах зардал тусах болсон. Ингэснээр, орон нутагт зарцуулж байгаа улсын төсвийн зардал эрс нэмэгдэж, нийт орон нутгийн хэмжээгээр 2003 онд 73 хувь, 2004 онд 76 хувь болж, Архангай аймгийн хувьд 79 хувь, 81 хувь болж тус тус нэмэгдсэн байна.

Түүнчлэн орон нутгийн захиргаанд хүн амын орлогын татвар, аж ахуйн нэгжийн орлогын татвар, НӨТ, онцгой татвар гэсэн үндсэн дөрвөн татварыг хураан аваад улсын төсөвт төвлөрүүлж байна. 2003 оноос өмнө орон нутгийн төсвийн орлогод хүн амын орлогын татвар, орон нутгийн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгжүүдийн аж ахуйн нэгжийн болон НӨТ-ын орлого ордог байсан. Эдгээр татварын орлогыг шинэ төсвийн өөрчлөлтийн дагуу аймгуудад улсын төсвөөр дамжуулан буцаан хувиарилж байна. Улсын төсвөөс авах НӨТ-н шилжүүлэг нь орон нутгийн хураан авсан НӨТ-н хэмжээ, хүн амын тооноос хамаарах бөгөөд орон нутгийн төсвийн орлогын дүнд ордог. Хүснэгт 8.3-аас улсын хэмжээний 2004 оны орон нутгийн төсвийн байдлыг харж болох ба үүгээр орон нутгийн төсөв ба улсын шилжүүлгээр санхүүжигдсэн орон нутгийн зардлын хувь, хэмжээг харуулаа. Энэ хүснэгтээс харахад дөрөвхөн газарт, тухайлбал, Орхон (Эрдэнэт), Дархан-Уул (Дархан), Дорноговь (Сайншанд), Улаанбаатарт орон нутгийн төсвийн орлого нь орон нутгийн төсвийн зардлаа нөхөх хэмжээтэй байна.

Хүснэгт 8.1. Төсөв боловсруулах үе шат, хугацаа

№	Төсвийн боловсруулах үе шатууд	II	III				IV				V				VI				VII				VIII				IX				Хууль, тогтоомжийн заалт
		4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	
1	Засгийн газраас дунд хугацаанд баримтлах төсөв, санхүүгийн үндсэн үзүүлэлтийн хязгаарыг ТЕЗ нарт хүргүүлэх	III.01																													ЗГ.2004.№73
2	Ерөнхий менежерүүд ирэх 3 жилд хэрэгжүүлэх ҮАХТ, ТЕЗ нар төсвийн төсөл, саналаа боловсруулж СЭЗЯ-д хүргүүлэх				III.20																										ЗГ.2004.№73
3	СЭЗЯ-аас ТЕЗ тус бүртэй ҮАХТ, төсвийн талаар санал солилцох							IV.10																							ЗГ.2004.№73
4	Дунд хугацааны төсвийн хүрээний баримт бичгийн төсөл, холбогдох тооцоог эцэслэн боловсруулж Засгийн газарт хүргүүлэх								IV.20																						ЗГ.2004.№73
5	Дунд хугацааны төсвийн хүрээний баримт бичгийн төсөл, дунд хугацаанд баримтлах эдийн засаг, санхүүгийн үндсэн зорилтын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах									IV.30																					ЗГ.2004.№73
6	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөл, УИХ-ын тогтоолын төслийг УИХ-д өргөн мэдүүлэх										V.01																				ТБУСТХ.25-р зүйл. ЗГ.2004.№73
7	Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг УИХ-аар хэлэлцэн батлах										Хаврын чуулганаар																				ТБУСТХ.25.3-р зүйл.
8	УИХ-аас хэлэлцэн зөвшөөрсөн ТХМ-д тусгагдсан үзүүлэлтийг холбогдох ТЕЗ нарт хүргүүлэх															VI.10															ЗГ.2004.№73
9	Ерөнхий менежерүүд дараа жилийн төсөв, ҮАХТ-ний саналаа боловсруулж ТЕЗ-д хүргүүлэх																		VII.01												ТБУСТХ.26,27,29, 30-р зүйл.
10	ТЕЗ нар дараагийн жилд зарцуулах төсвийн төсөл, ҮАХТ-ний саналыг СЭЗЯ-д хүргүүлэх																							VIII.15							ТБУСТХ.26,27,29, 30-р зүйл.
11	ТЕЗ-аас ирүүлсэн төсвийн саналыг СЭЗЯ-ны холбогдох газар хэлтсээс судлан үзэж, ТЕЗ-тай зөвшилцөх																									IX.01					ЗГ.2004.№73
12	Төсвийн төсөл, дунд хугацаанд баримтлах эдийн засаг, санхүүгийн үндсэн зорилтын төслийг эцэслэн боловсруулж Засгийн газарт хүргүүлэх																											IX.15			ТБУСТХ.31.1-р зүйл. ЗГ.2004.№73
13	Ирэх оны төсвийн төсөл, дунд хугацаанд баримтлах эдийн засаг, санхүүгийн үндсэн зорилтын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх																													IX.30	ТБУСТХ.31.2-р зүйл. ЗГ.2004.№73
14	Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн болон улсын төсвийн төсөл, ТЕЗ бүрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх																													X.01	ТБУСТХ.32-р зүйл. ЗГ.2004.№73

ХҮСНЭГТ 8.2 УЛСЫН БОЛОН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА

(сая төгрөгөөр)

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО	Нийт/Орон нутгийн төсөв			Архангай		
	2002	2003	2004	2002	2003	2004
	Бодит	Бодит	ХБГ	Бодит	Бодит	ХБГ
I. НИЙТ ОРЛОГО	**106,168.9**	**49,222.0**	**51,958.9**	**2,893.4**	**883.4**	**913.6**
УРСГАЛ ОРЛОГО	**104,359.5**	**47,169.9**	**49,515.4**	**2,893.4**	**883.4**	**913.6**
ТАТВАРЫН ОРЛОГО	**85,897.1**	**34,885.3**	**40,880.0**	2,495.6	789.6	848.9
Орлогын албан татвар	**26,175.5**	**4,492.3**	**4,490.8**	326.2	191.2	178.2
ХАОАТ	**26,165.1**	**4,492.3**	**4,490.8**	326.2	191.2	178.2
Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	**10.5**	**0.0**	**0.0**	0.0	0.0	0.0
Өмчийн татвар	**3,159.8**	**4,597.4**	**4,601.5**	21.6	28.5	27.1
Бараа ба үйлчилгээний албан татвар	**43,628.7**	**13,046.6**	**14,483.4**	1,653.7	413.6	467.7
НӨАТ	**36,472.5**	**9,063.0**	**9,843.3**	1,472.9	336.9	387.7
Онцгой албан татвар	**3,411.0**	**0.0**	**0.0**	109.5		
Авто болон өөрөө явагч хэрэгслийн татвар	**3,745.3**	**3,983.6**	**4,640.0**	71.4	76.7	80.0
Бусад татвар	**12,933.0**	**12,749.0**	**17,304.4**	494.1	156.3	176.0
Татварын бус орлого	**18,462.5**	**12,284.6**	**8,635.4**	397.8	93.8	64.7
Хөрөнгийн орлого	**1,809.4**	**2,052.1**	**2,443.4**	0.0	0.0	0.0
Хөрөнгө борлуулсаны орлого	**458.6**	**350.2**	**517.5**	0.0	0.0	
Өмч хувьчлалын орлого	**1,350.8**	**1,701.9**	**1,925.9**	0.0	0.0	
НИЙТ ОРЛОГО (өмч хувьчлалыг хассанаар)	**104,818.2**	**47,520.0**	**50,033.0**	**2,893.4**	**883.4**	**913.6**
ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРДАЛ						
II. НИЙТ ЗАРДАЛ	**168,904.4**	**35,485.0**	**43,698.0**	**5,687.2**	**983.8**	**1,255.3**
УРСГАЛ ЗАРДАЛ	158,333.5	28,132.2	34,575.4	5,467.6	913.5	1,127.2
Бараа, үйлчилгээний зардал	**155,575.4**	**26,775.4**	**31,721.1**	**5,388.6**	**900.2**	**1,111.1**
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	62,437.0	8,011.8	9,416.1	2,327.1	384.6	405.9
Нийгмийн даатгалын шимтгэл	15,153.5	1,997.4	2,487.1	574.5	88.3	107.2
Бусад бараа, үйлчилгээний зардал	77,984.8	16,766.2	19,817.9	2,487.0	427.3	598.0
Татаас ба урсгал шилжүүлэг	**2,758.1**	**1,356.8**	**2,854.3**	**79.0**	**13.3**	**16.2**
Өрх гэрт олгох шилжүүлэг	2,618.0	469.0	414.7	79.0	13.3	16.2
Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	140.1	887.8	2,439.6	79.0	13.3	16.2
Хөрөнгийн зардал	**10,570.9**	**7,352.7**	**9,122.6**	219.6	70.3	128.1
Дотоод хөрөнгө оруулалт	7,038.0	6,680.6	7,690.7	63.9	70.3	80.0
Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт	7,038.0	3,314.0	3,050.7	63.9	0.0	0.0
Орон нутгийн замын сангийн хөрөнгөөр санхүүжих	0.0	3,366.6	4,640.0	0.0	70.3	80.0
Малын тэжээл	6.0	0.0	0.0			
Ойжуулалтын зардал	7.4	0.0	0.0			
Хөрөнгийн шилжүүлэг	3,519.6	672.2	1,431.9	155.7	0.0	48.1
Цагаатгах ажлыг зохион байгуулах төсөв	3,519.6	672.2	1,431.9	155.7	0.0	48.1
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	**168,904.4**	**35,514.9**	**43,698.0**	**5,687.2**	**985.3**	**1,255.3**
Авто замын сан	0.0	118.8	4,640.0	0.0	0.0	80.0
Эрүүл мэндийн даатгал	10,415.0	0.0	0.0	528.2	0.0	0.0
Үйл ажиллагааны орлого	6,785.0	1,565.6	986.3	171.1	15.0	0.0
Туслах үйл ажиллагааны орлого	3,351.4	458.4	247.8	17.5	0.0	3.0
Төсөв (орон нутгийн төсөв ба улсын шилжүүлэг)	148,353.1	33,372.1	37,823.8	4,970.3	970.4	1,172.3
УЛСЫН ТӨСВИЙН ОРОН НУТГИЙН ЗАРДАЛ						
III. НИЙТ ЗАРДАЛ	0.0	**141,104.7**	**166,959.3**		**3,146.6**	**3,598.1**
УРСГАЛ ЗАРДАЛ	0.0	138,169.3	166,726.3		3,072.1	3,582.1
Хөрөнгийн зардал	0.0	2,935.4	233.0		74.5	16.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	**0.0**	**142,367.8**	**166,959.3**		**3,160.0**	**3,598.1**
Эрүүл мэндийн даатгал	0.0	11,770.7	13,230.4		0.0	0.0
Үйл ажиллагааны орлого	0.0	6,491.1	6,014.4		82.5	104.0
Туслах үйл ажиллагааны орлого	0.0	1,821.7	1,318.7		45.3	21.6
Нийтийн боловсролын сан	0.0	433.5	0.0		0.0	0.0
Төсөв	0.0	121,850.8	146,395.8		3,032.3	3,472.5
IV. УЛСЫН БОЛОН ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН НИЙТ ОРОН НУТГИЙН ЗАРЛАГА (II+III)	**168,904.4**	**176,589.7**	**210,657.2**	**5,687.2**	**4,130.5**	**4,853.4**
V. УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ ОРОН НУТГИЙН НИЙТ ЗАРЛАГА (IV-I)	**64,086.3**	**129,069.6**	**160,624.3**	**2,793.8**	**3,247.1**	**3,939.9**
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ ЗАРДЛЫН ХУВЬ (V/IV)	**38%**	**73%**	**76%**	**49%**	**79%**	**81%**

ХҮСНЭГТ 8.3. 2004 ОНЫ УЛСЫН БА ОРОН НУТГИЙН ТӨСӨВ ХООРОНДЫН ШИЛЖҮҮЛГИЙН ТООЦОО

(сая төгрөгөөр)

	ЭДИЙН ЗАСГИЙН БҮС АЙМГУУД		Хүн ам (мянган)	ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА	ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО	ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГЫН (НӨАТ-ын шилжүүлэг орсон) ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГАД ЭЗЛЭХ ХУВЬ	УЛСЫН ТӨСВӨӨС АВАХ НӨАТ-ЫН ШИЛЖҮҮЛЭГ	УЛСЫН ТӨСВӨӨС АВАХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ	ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГАД ЭЗЛЭХ САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГИЙН ХУВЬ	ӨМЧ ХУВЬ-ЧЛАЛ	УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ
	Баруун бүс										
1	1	Баян-Өлгий	98.9	1,114.5	753.3	68%	393.3	361.2	32%	0.0	0.0
2	2	Говь-Алтай	62.7	1,308.0	525.0	40%	249.3	766.0	59%	17.0	0.0
3	3	Завхан	84.5	1,315.1	663.9	50%	336.0	651.2	50%	0.0	0.0
4	4	Увс	83.6	1,283.5	649.9	51%	332.4	633.6	49%	0.0	0.0
5	5	Ховд	88.5	1,324.1	756.9	57%	351.9	567.2	43%	0.0	0.0
			418.2	**6,345.2**	**3,349.0**		**1,663.0**	**2,979.2**		**17.0**	**0.0**
	Хангайн бүс										
6	1	Архангай	97.5	1,255.3	913.6	73%	387.7	341.7	27%	0.0	0.0
7	2	Баянхонгор	84.4	1,299.5	674.5	52%	335.6	625.0	48%	0.0	0.0
8	3	Булган	63.5	1,184.6	797.4	67%	252.5	387.2	33%	0.0	0.0
9	4	Орхон	77.4	1,967.4	8,494.5	432%	307.8	0.0	0%	0.0	6,527.2
10	5	Өвөрхангай	113.9	1,513.7	966.5	64%	452.9	547.1	36%	0.0	0.0
11	6	Хөвсгөл	121.9	1,374.6	1,078.0	78%	484.7	296.6	22%	0.0	0.0
			558.6	**8,595.1**	**12,924.6**		**2,221.3**	**2,197.6**		**0.0**	**6,527.2**
	Төвийн бүс										
12	1	Говь-Сүмбэр	12.5	475.5	298.2	63%	49.7	177.2	37%	0.0	0.0
13	2	Дархан-Уул	87.8	1,370.6	1,538.4	112%	349.1	0.0	0%	0.0	167.8
14	3	Дорноговь	52.0	1,407.8	1,515.2	108%	206.8	0.0	0%	0.0	107.4
15	4	Дундговь	51.2	967.6	513.3	53%	203.6	454.3	47%	0.0	0.0
16	5	Өмнөговь	47.2	1,073.0	598.9	56%	187.7	474.1	44%	0.0	0.0
17	6	Сэлэнгэ	102.2	1,690.5	1,260.9	75%	406.4	429.6	25%	0.0	0.0
18	7	Төв	96.5	2,056.5	1,236.9	60%	383.7	819.6	40%	0.0	0.0
			449.4	**9,041.4**	**6,961.8**		**1,787.0**	**2,354.9**		**0.0**	**275.2**
	Зүүн бүс										
19	1	Дорнод	74.6	1,015.2	839.8	83%	296.6	166.5	16%	8.9	0.0
20	2	Сүхбаатар	56.1	953.3	570.3	60%	223.1	383.1	40%	0.0	0.0
21	3	Хэнтий	72.0	1,154.5	764.7	66%	286.3	389.8	34%	0.0	0.0
			202.7	**3,123.1**	**2,174.7**		**806.0**	**939.4**		**8.9**	**0.0**
	Улаанбаатар										
22	1	Улаанбаатар	846.5	16,593.2	24,622.8	148%	3,366.1	0.0	0%	1,900.0	9,929.6
	ДҮН		**2475.4**	**43,698.0**	**50,033.0**		**9,843.3**	**8,471.1**		**1,925.9**	**16,732.0**

9. Хот, суурин газрын байгаль орчны байдал төлөв

2003 оны усны чанарын хяналтын судалгаанаас үзэхэд, Улаанбаатар хотын төв хэсэгт Туул голын усны бохирдол бага буюу чанарын шаардлага хангах түвшинд байна. Харин урсгал дагуу 25 км-т буюу Яармаг, Сонгинын орчмоор Туул голын ус цэвэр усны чанарын стандартын түвшнээс арав дахин их бохирдолтой байдаг. Сонгино орчмоос 10 км зайтай орших Хадан Хясаа орчмын хотоос захдуу нутгаар Туул голын ус бохирдолтой байдгийн дээр Улаанбаатар хотоос 50 км зайтай орших Алтанбулан суманд ч усны чанар хангалтгүй байна.

Улаанбаатар хотын газрын доорх усны эх үүсвэрээр хотын хүн амын 91 хувийг хангадаг. Тус хотын усан хангамжийн систем дөрвөн үндсэн эх үүсвэр болон 156 худгаас бүрдэнэ. Хотын төвийн орон сууцны хороллын оршин суугчид Дээд эх үүсвэр буюу Амгалангийн 1,2-р эх үүсвэрээс хангагддаг. Эдгээр эх үүсвэрийн ус чанарын шаардлага хангадаг. Харин Толгойт орчмын гэр хороллын айлууд болон Үйлдвэр орчмынхон ундны усны доод эх үүсвэр болох 3,4-р эх үүсвэрээс хангагддаг. Энэ орчмын усанд бактери, колititр, колибакцин илэрдэг.

МУ-ын хот байгуулалтын цаашдын хөгжилд ихээхэн хүндрэл бэрхшээл учруулж байгаа асуудлын нэг бол гол гол томоохон хотуудын бохир ус цэвэрлэх байгууламжуудын өнөөгийн байдал юм. Ихэнх хотын бохир ус цэвэрлэх байгууламжууд бохир усыг зөвхөн механик аргаар цэвэрлээд, шууд лагийн талбайд гаргаж орхиж байгаа нь хөрс болон газрын доорх усны бохирдолд хүргэж байна. Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн төслийн хүчин чадал өдөрт 230000-240000 м3 боловч одоогийн байдлаар өдөрт зөвхөн 150000-170000 м3 ус цэвэршүүлж байна. Тус байгууламж усыг механик болон биологийн цэвэрлэгээний долоон дамжлагаар цэвэршүүлээд Туул голд нийлүүлдэг. Арьс ширний үйлдвэр зэрэг химийн бодис ашигласан үйл ажиллагаа явуулдаг зарим үйлдвэрт өөрийн гэсэн бохир ус цэвэрлэх төхөөрөмж байдаггүйгээс бохир усаа цэвэршүүлэлгүйгээр шууд төв коллекторт нийлүүлдэг. Үүний дүнд 6 валентын хром, сульфит зэрэг бодис төв цэвэрлэх байгууламжид орж, улмаар цэвэршүүлэгч бактериудыг устган, цэвэршүүлэлтийн түвшнийг бууруулж байна.

Хотын баруун хэсгийн гэр хорооло буюу нисэх, Баянгол хороо орчимд бохир ус цэвэршүүлэх хоёр жижгэвтэр байгууламж байдаг. Тэдгээр байгууламжид бүхэлд нь болон тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх шаардлагатай байгаа. Хотын зүүн хэсэг буюу Налайхын цэвэр ус цэвэршүүлэх байгууламж ашиглалтгүй болсон. Улаанбаатар хотын ундны усны дээд эх үүсвэрийн орчинд байрладаг Налайх хот болон цэргийн анги бохир усаа шууд ил гадагшлуудгаас хөрс болон газрын доорх ус бохирдоход хүргэж байна.

Дархан хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн төслийн хүчин чадал 50000 м3/өдөр боловч өнөөгийн ашиглаж буй хүчин чадал нь ердөө 15000-17000 м3/өдөр байгаагийн дээр хлоржуулах төхөөрөмж нь эвдэрсэн. Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн төслийн хүчин чадал 24000 м3 боловч одоогийн ажиллаж байгаа хүчин чадал нь 32000 м3. Цэвэршүүлэлтийн зэрэг өндөр бөгөөд Хангалын голын усанд бохирдол үзүүлдэггүй. Харин Эрдэнэт үйлдвэр ашигласан усаа шууд голд хаядагаас үүдэлтэй хөрсний бохирдол Хангалын голын усны чанарт сөргөөр нөлөөлж байгаа юм. Цаашдаа Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийг Эрдэнэт үйлдвэрийн харьяаллаас гаргаж хотын нийтийн аж ахуйн байгууллагын мэдэлд шилжүүлэн, хүчин чадлыг нь нэмэгдүүлэх нь зүйтэй.

МУ-ын хот суурин газруудаас агаарын бохирдлын асуудал хамгийн хурцадмал шинжтэй болсон хот нь нийслэл Улаанбаатар хот юм. Харин орон нутгийн хотуудын агаарын бохирдолтын түвшин харьцангуй доогуур бөгөөд хоорондоо

ойролцоо байгаа юм. Улаанбаатар хотын агаарын бохирдолтын гол эх үүсвэрүүд нь, дулааны цахилгаан станцуудын утаа (1), уурын болон гэрийн зуух тэдгээрийн дутуу шаталтаас үүдэлтэй утаа (2), автомашины утаа униар (3) юм. Гэр хорооллын айлуудын зуухан дахь дутуу шаталтаас үүдэлтэй утаа униар нь зөвхөн ойр орчмын агаарыг бохирдуулаад зогсохгүй хотын төв хэсгийн агаарт ч сөргөөр нөлөөлж байдаг. Агаарын бохирдол улирлын байдлаас шалтгаалан өөр өөр байдаг бөгөөд уул хөндийн салхины горимын нөлөөгөөр өвлийн цагт хотын агаар улам ч их утаа униартай байдаг.

Толгойт, Баянхошуу, Улаанхуаран, Амгалан зэрэг газруудын гэр хорооллын орчмын агаарын бохирдол хотын бусад хэсгийнхээс хавьгүй их байдаг. Дээрх газруудын агаар дахь нүүрсхүчлийн хийн агууламж 40 мкг/м3-аас дээш, нитритын давхар исэл 5мг/м3-ээс дээш байдаг. Гэр хорооллын 85 мянга шахам айл өрх болон 250 бага оврын уурын зуух жилд 600,000 тонн орчим нүүрс хэрэглэж, улмаар агаарт 30,000 тонн орчим нитритын давхар исэл үүсгэж байна.

Улаанбаатар хотын өмнө тулгамдсан томоохон асуудлуудын нэг нь амжиргааны нөхцөл, хот орчны байдалд ихээхэн нөлөөтэй хотын хогны асуудал юм. Улаанбаатар хотын хогийн төв цэгүүд нь хотуудын хойд болон зүүн хойд зүгт Улаанчулуут, Хамбын Овоо, Мөрөнгийн даваа зэрэг газруудад байрладаг. Хотын 6 дүүргээс 150 ачааны тэргээр хогийг зөөвөрлөдөг. Хотын хог хаягдлын дундаж хэмжээ жилд 97500 тонн байдгийн 32 хувь нь орон сууцны айлуудаас, 17 хувь нь албан газар, дэлгүүр, зоогийн газруудаас, 51 хувь нь гэр хорооллоос, үүний дотор айл өрхөөс 48 хувь, гудамжны хог 3 хувь гарч байна.

Цэцэрлэг хот бусад аймгийн төвүүдийн жишгээр хуурай хог хаягдлын цэг маш цөөнтэй. Тус хотоос 10 км-ийн зайтай цорын ганц албан ёсны хог хаях цэг байдаг. Хотын хүн амын 84 орчим хувь нь аж төрдөг гэр хорооолод хогийн албан бус 10 цэг байдаг. Нийт гэр хорооллын 4 багийн задгай хогийн цэгээс жилд ойролцоогоор 1700 тонн орчим хог гардаг байна. Халзангийн даваа болон Мааньт голын сав газарт 700 тонн орчим хог хуримтлагддаг 3 га орчим талбай хамарсан хогийн цэг ашиглагдаж байгаа бөгөөд энэ байдал нь орчныг бохирдуулж эхлээд байгаа юм. Зөвшөөрөлгүй өөр нэг хогийн цэг нь худагтай маш ойрхон байрладаг. Харин эмнэлгийн орчимд байх 480 м3 орчим хог хуримтлагддаг Гахайн булагийн хогийн цэгийг устгасан.

10. Хандивлагчдын тусламжтай хэрэгжиж буй холбогдох төслүүд

Санхүүжүүлэгч байгууллага	Төсөл	Зорилго
АХБ	Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйг хөгжүүлэх	Монголын зүүн 8 аймгийн төвд үндсэн дэд бүтцийн үйлчилгээг сайжруулах
АХБ	Орон сууцны салбарын санхүүжилт	Зах зээлийн эдийн засагт тулгуурласан орон сууцны санхүүгийн тогтвортой тогтолцоог бий болгох, түүнчлэн ОСХХТ-ний арг хэмжээг хэрэгжүүлэн гэр хорооллын нөхцлийг сайжруулах
АХБ	Кадастрын судалгаа, газрын бүртгэл	Газрын удирдлага, үл хөдлөх хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх институцийн суурийг бүрдүүлэх

АХБ (Ядуурлыг бууруулах Японы сан)	Монголын гэр хорооллын ядуучуудын амьдралын нөхцлийг сайжруулах	Зарим гэр хорооло́лд орон сууцтай холбоотой ядуурлын асуудлыг шийдэх шинэ инновацийн аргуудыг турших
Дэлхийн банк	Улаанбаатар хотын нийтийн үйлчилгээний 2 дахь төсөл	Улаанбаатар хотын гэр хорооллын ядуучуудад үндсэн нийтийн үйлчилгээг үзүүлэх
Дэлхийн банк	Утаагүй зуух	Агаарын бохирдлыг бууруулахад, түүнчлэн гэр хорооллын айл өрхийн зуухыг сайжруулснаар тэдний зардлыг бууруулахад дэмжлэг үзүүлэх
Дэлхийн банк (Японы нийгмийн хөгжлийн сан)	Олон нийтийн оролцоо чиглүүлсэн дэд бүтцийн төсөл	Гэр хорооллын оршин суугчдын дэд бүтцийн оролцооны аргаархи төлөвлөгөөг боловсруулах
Дэлхийн банк, Хотуудын холбоо	Хоёрдогч хотуудын Хотын хөгжлийн стратеги	Хоёрдогч таван хотуудын ХХС-ийг боловсруулахад үндсэн хөрөнгөд тулгуурлах аргыг хэрэглэх
НҮБХХ	Гэр хорооллын зураглалын судалгаа	Улаанбаатар хотын гэр хорооллын оршин суугчдын нийгэм-эдийн засгийн судалгаа
НҮБХХ	Хотын ядуурлын туршилтын төсөл	Улаанбаатар хотын гэр хорооллын нэн ядуучуудад чиглэсэн санаачлага хөдөлгөөнөөр дамжуулан олон нийтийн оролцоог хөгжүүлэх туршилтууд
НҮБХХ	Супер-дулаалгын барилгын технологийг арилжаалах	Эрчим хүчний хэмнэлттэй, үнэ өртөг боломжийн барилгын материал болох сүрлээр байшин барих технологийг дэмжих
ЖАЙКА	Зам сайжруулах	Улаанбаатар хотын зам, уулзварыг барих, сайжруулах
ЖАЙКА	Усны шугам сүлжээний системийг сайжруулах	Улаанбаатар хотын худаг, насосны станцийг барих, сайжруулах
ЖАЙКА	Улаанбаатар хотын хуурай хог хаягдлын удирдлагын ерөнхий төлөвлөгөө	Улаанбаатар хотын хуурай хог хаягдлын удирдлагын ерөнхий төлөвлөгөө боловсруулах
АНУ-ны ОУХБ	Гэр санаачлага ба бизнесийн хөгжил	Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотуудад орлого нэмэгдүүлэх жижиг бизнесийг хөгжүүлэх

ХАВСРАЛТ Б. Канадын орон сууцны үндэсний код болон Монголын “Нэг айлын сууц” БНбД-ийн харьцуулалт

Канадын Орон Сууцны Үндэсний Норм 1998 он /3 давхар хуртэл орон сууц/	*Нэг айлын сууц БНбД 31-05-04, Монгол Улс /4 давхар хуртэл орон сууц/ -төсөл 2004 он*
Бичиглэлийн хэсэг 1-р хэсэг. Эхний хэсэг 2-р хэсэг. Суурь 3-р хэсэг. Шалны тулгуур хийц бүтээц 4-р хэсэг. Өрөө тасалгаа ба орон зайн хэмжээ 5-р хэсэг. Барилгаас гарах арга хэрэгсэл 6-р хэсэг. Галын аюулгүйн байдал & Дуу чимээнд тавих хяналт 7-р хэсэг. Ханын бүтэц 8-р хэсэг. Дээврийн хучилт 9-р хэсэг. Цонх, гэгээвч & Хаалга 10-р хэсэг. Задгай зуух, яндан & Утааны суваг 11-р хэсэг. Тусгаарлалт, агаар тусгаарлах систем & Уур тусгаарлалт 12-р хэсэг. Механик систем 13-р хэсэг. Сантехник & Цахилгаан тоног төхөөрөмж 14-р хэсэг. Дотор заслын ажил 15-р хэсэг. Гадна заслын ажил 16-р хэсэг. Гараж & Саравч Алгасалтын хүснэгт, Жагсаалт	**Бичиглэлийн хэсэг** 1.Хамрах хүрээ 2.Ашигласан холбогдох норматив баримт бичгүүд 3.Нэр томъёо, тодорхойлолт 4.Ерөнхий зүйл 5.Хийц бүтээцийн даацын чадавхи ба гажилт 6.Галын аюулгүй байдал 7.Ашиглалтын үеийн аюулгүй ажиллагаа 8.Ариун цэвэр-эрүүл ахуйн шаардлагыг хангах 9.Эрчим хүч хэмнэлт 10.Эдэлгээний тогтворшилт ба засварлахад тохиромжтой байдал Хавсралт А. Ашигласан холбогдох норматив баримт бичгүүд Хавсралт Б. Нэр томъёо ба тодорхойлолт
Зурагтай тайлбар, заавар 1-р хэсэг. Эхний хэсэг 2-р хэсэг. Суурь 3-р хэсэг. Шалны тулгуур хийц бүтээц 4-р хэсэг. Өрөө тасалгаа ба орон зайн хэмжээ 5-р хэсэг. Барилгаас гарах арга хэрэгсэл 6-р хэсэг. Галын аюулгүйн байдал & Дуу чимээнд тавих хяналт 7-р хэсэг. Ханын бүтэц 8-р хэсэг. Дээврийн хучилт 9-р хэсэг. Цонх, гэгээвч & Хаалга 10-р хэсэг. Задгай зуух, яндан & Утааны суваг 11-р хэсэг. Тусгаарлалт, агаар тусгаарлах систем & Уур тусгаарлалт 12-р хэсэг. Механик систем 13-р хэсэг. Сантехник & Цахилгаан тоног төхөөрөмж 14-р хэсэг. Дотор заслын ажил 15-р хэсэг. Гадна заслын ажил 16-р хэсэг. Гараж & Саравч Хавсралт А /1995 оны Канадын Барилгын Үндэсний код, 1998 оны Канадын Орон сууцны Үндэсний код/ Холимог ишлэл, Өөрчлөлтийн үзүүлэлтүүд	**Зурагтай тайлбар, заавар** - - - - - - - - - - - - - - - -

Канадын Орон сууцны Үндэсний код болон Монголын “Нэг айлын сууц” БНбД-ийн харьцуулалт

Канадын Орон Сууцны Үндэсний Норм /3 давхар хүртэл орон сууц/	*Нэг айлын сууц БНбД 31-05-04, Монгол Улс /4 давхар хүртэл/ төсөл*	*Тайлбар БНбД 31-05-04-ыг хэрэглэхэд хавсарч ашиглах норм, дүрэм, стандартууд*
1-р хэсэг. Эхний хэсэг	**1-р хэсэг. Эхний хэсэг**	
1.1. Хамрах хүрээ, тодорхойлолт		
1.1.1.Засаг захиргаа	Засаг захиргаа	-
1.1.2. Хамрах хүрээ	1.Хамрах хүрээ /БНбД 31-01-01/	-
1.1.3.Нэр, томъёоны тодорхойлолт	3.Нэр томъёо & Тодорхойлолт /Хавсралт Б/	-
1.1.4.Товчлол	-	-
1.2. Ерөнхий шаардлага	**4. Ерөнхий зүйл**	Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм, БНбД 31-01-01, хавсралт 2
1.2.1. Барилгын хэмжээ тогтоолт	4.2, 4.8	-
1.2.2. Материал, цахилгаан хэрэгсэл, систем ба тоног төхөөрөмж	7.1	-
1.2.3. Эквивалент /ижил, тэнцүү/	1	Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт, БНбД 2.01.01-93,Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм, БНбД 22-01-01-2001, Хавсралт 1, 2
1.2.4. Уур амьсгалын үзүүлэлтүүд	-	Барилгын дулаан техник, БНбД 2.01.03-92
1.2.5. Ашигласан баримт бичгүүд	2. Ашигласан, холбогдох норматив баримт бичгүүд /Хавсралт А/	-
1.3.Төлөвлөгөө, зөвшөөрөл & Хяналт		
1.3.1. Шаардлагатай мэдээлэл	4.1, 4.7 /9-р бүлэг/, 10.1	-
1.4. Барилгын материал & хийц бүтээцэд тавих шаардлага		
1.4.1. Бетон	-	Бетон ба төмөр бетон бүтээц,БНбД 2.03.01-90
1.4.2. Зүсмэл ба модон эдлэхүүн	-	Бетон, ангилал, техникийн ер.шаардлага, МНС 3996-87, Портландцемент, MNS 0947: 99, г.м
1.4.3. Ган	-	Модон бүтээц, БНбД 3.03.08-88
1.4.4. Хийц бүтээцэд тавих ерөнхий шаардлага	-	Стальные конструкции, СНиП II-23-81,2. Барилга байгууламжийн ган, техникийн шаардлага, MNS4237-94
1.4.5. Модон хийц бүтээцийг бэхлэгч хэсэглэлүүд	-	Модон бүтээц, БНбД 3.03.08-88
1.4.6. Зүсэлт ба өрөмдлөг	-	Модон бүтээц, БНбД 3.03.08-88 /2.12, 2.13/
2-р хэсэг. Суурь		
2.1. Хөрс хуулалт, ухлагын ажил		Барилгын газар шороо ба буурь суурийн ажил, БНбД 3.02.01-90
2.1.1. Ерөнхий зүйл	-	1.Ерөнхий зүйл
2.1.2. Гүн	-	3. Ухлага ба өндөржилтийн ажил
	5. Хийц бүтээцийн даацын чадавхи ба хэв	

2.2. Ул суурь	**гажилт**	“Барилга байгууламжийн буурь, суурийн зураг төсөл зохиох норм ба дүрэм”,БНбД 2.02.01-94 /хавсралт 3/
2.2.1. Ерөнхий зүйл	5.4, 5.5	“Ачаалал ба үйлчлэл”, БНбД 2.01.07-90
2.2.2. Төслийн хязгаарлал	5.1, 5.2	Инженерийн бус хийцтэй барилгыг төлөвлөх, барих зөвлөмж , 2.11, 4.8
2.2.3. Ул суурийн хэмжээ	-	Детали фундаментов жилых и общественных зданий, Серия 02-11, 1975 г.
2.2.4. Шаталсан ул суурь	-	“Барилга байгууламжийн буурь, суурийн зураг төсөл зохиох норм ба дүрэм”,БНбД 2.02.01-94
2.2.5. Ул суурийн онцгой нөхцөл	-	
2.3. Суурийн хана		Цутгамал бетон, төмөр бетон эдлэл, БНбД 3.03.01-88
2.3.1. Цутгамал бетон & чулуун суурь хананы нэгж	-	
2.4. Багана, пилястр & Дам нуруу,баганын тулгуур		Өрөгт ба арматурласан өрөгт бүтээц, БНбД 2.03.02-90
2.4.1. Багана: Ерөнхий зүйл	-	Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх, БНбД 22-01-01, /Каркасан барилга/
2.4.2. Ган багана	-	Стальные конструкции, СНиП II-23-81, Барилга байгууламжийн ган. Техникийн шаардлага.MNS 4237:94
2.4.3. Модон багана	-	Инженерийн бус хийцтэй барилгыг төлөвлөх, барих зөвлөмж /газар хөдлөлттэй бүс нутагт/, 2002 он
2.4.4. Чулуун багана	-	Тоосгон барилгыг газар хөдлөлтийн үйлчлэлд тооцох заавар, БД 31-105-02, 2003 он
2.4.5. Цул бетонон багана	-	Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх, БНбД 22-01-01,/Төмөр бетон бүтээц/
2.4.6. Пилястр	-	Тоосгон барилгыг газар хөдлөлтийн үйлчлэлд тооцох заавар, БД 31-105-02, 2003 он
2.4.7. Даацын хамар хана	-	Инженерийн бус хийцтэй барилгыг төлөвлөх, барих зөвлөмж /газар хөдлөлттэй бүс нутагт/, 2002 он, /Даацын тоосгон ханатай барилга/
2.4.8. Тулгуурт тавих шаардлага	-	Тоосгон барилгыг газар хөдлөлтийн үйлчлэлд тооцох заавар, БД 31-105-02, 2003 он
2.5. Зоорийн хөндий		Өрөгт ба арматурласан өрөгт бүтээц, БНбД 2.03.02-90 /6.65-6.68/
2.5.1. Ерөнхий зүйл	-	Цутгамал бетон, төмөр бетон эдлэл, БНбД 3.03.01-88,
2.5.2. Орц	-	Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер, БНбД 41-01-02
2.5.3. Зай хэмжээ	-	Олон нийт, иргэний барилга, БНбД 31-03-03 /1.3,1.6/
2.5.4. Ус зайлуулах хоолой	-	Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм, БНбД 21-02-02 /3.2-3.6/
2.5.5. Агааржуулалт	-	Усан хангамж, бохир ус татуургын гадна шугам сүлжээ, түүний барилга байгууламж, БНбД 3.05.04-90
2.5.6. Гадаргуугийн хучилт	-	Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер,БНбД41-01-02
		Шалны ажил, БНбД 3.04.04-90
2.6. Талбайн хучилт/ шал		
2.6.1. Хамрах хүрээ	-	Шалны ажил, БНбД 3.04.04-90 /1/
2.6.2. Шалан доорх материал	-	Шалны ажил, БНбД 3.04.04-90 /2-8/

2.6.3. Дренаж /шүүрүүл/	-	Усан хангамж,бохир ус татуургын гадна шугам сүлжээ, барилга барилга байгууламж, БНбД 3.05.04-90
2.6.4. Бетон	-	Шалны ажил, БНбД 3.04.04-90 /Бетон, цемент-элсэн ба шиттгэмэл өнгөн үе,Хүчилд тэсвэртэй бетонон өнгөн үе, Асфалтбетонон ба давирхайт бетонон өнгөн үе/
2.6.5. Мод	-	Шалны ажил, БНбД 3.04.04-90 /Банзан шал/
2.7. Бусад төрлийн суурь		
2.7.1. Модон бүтээц	-	Инженерийн бус хийцтэй барилгыг төлөвлөх, барих зөвлөмж /газар хөдлөлттэй бүс нутагт/, 2002 он /Модон барилга/
2.7.2. Тулгуур /кессонон суурь/	-	"Барилга байгууламжийн буурь, суурийн зураг төсөл зохиох норм ба дүрэм",БНбД 2.02.01-94
2.7.3. Хэв гажилт эсэргүүцэх барилга	-	Өрөгт ба арматурласан өрөгт бүтээц, БНбД 2.03.02-90 /6.78-6.82/
2.8. Чийг тусгаарлалт & Ус тусгаарлалт	**10. Эдэлгээний тогтворшилт ба засварлахад тохиромжтой байдал**	
2.8.1. Ерөнхий зүйл	10.4, 10.5	Байгууламж ба барилгын бүтээцийг зэврэлтээс хамгаалах, БНбД 3.04.03-90
2.8.2. Чулуун суурь ханын заслын ажил & Ус тус-гаарлагч цементэн үе	-	Защита строительных конструкций от коррозии, СНиП 2.03.11-85
2.8.3. Ханын чийг тусгаарлалт	-	Дээвэр, ус, уур, дулаан тусгаарлалтын ажил, БНбД 3.04.01-88
2.8.4. Хөрсөн дээрх шалны чийг тусгаарлалт	-	Дээвэр, ус, уур, дулаан тусгаарлалтын ажил, БНбД 3.04.01-88 /Уур, ус тусгаарлалт, 4.1-24/
2.8.5. Ханын ус тусгаарлалт	-	Шалны ажил, БНбД 3.04.04-90,/ 6.2, 6.3, 7.8/
2.8.5. Хөрсөн дээрх шалны ус тусгаарлалт	-	Дээвэр, ус, уур, дулаан тусгаарлалтын ажил,БНбД 3.04.01-
2.9. Суурь & Гадаргын шүүрүүл		
2.9.1. Хамрах хүрээ	-	Барилгын газар шороо ба буурь суурийн ажил, БНбД 3.02.01-90
2.9.2. Суурийн шүүрүүл/ хатаалт	-	1.Ерөнхий зүйл
2.9.3. Шүүрүүлийн шаазан хоолой & Шугам хоолой	-	2. Хөрсний усны түвшинг доошлуулах ба гадаргын ус зайлуулах ажил
2.9.4. Үйрмэг шүүрүүлэгч давхрага үе	-	Канализация. Наружные сети и сооружения, СНиП 2.04.03-85
2.9.5. Шүүрүүлийн хуримтлах /шүүх хэсэг	-	
2.9.6. Гадаргын шүүрүүл	-	
2.10. Хөрсний хийнээс хамгаалах хяналт	**8. Ариун цэвэр-эрүүл ахуйн шаардлагыг хангах**	
2.10.1. Ерөнхий зүйл	8.7	-
2.10.2. Ханын хөрсний хийн хяналт	8.7	-
2.10.3. Хучилтын хөрсний хийнээс хамгаалах хяанлт	8.7	-
2.11. Овоолго ба буллагын ажил		
2.11.1. Тавих шаардлага	-	Барилгын газар шороо ба буурь суурийн ажил, БНбД 3.02.01-90, 4. Овоолго ба буллагын ажил
3-р хэсэг. Шалны тулгуур хийц бүтээц		
3.1. Ерөнхий зүйл		Инженерийн бус хийцтэй барилгыг төлөвлөх,барих зөвлөмж /газар хөдлөлттэй бүс нутагт/, Модон барилга
3.1.1. Хамрах хүрээ	-	

3.2. Хотойлт 3.2.1. Хотойлтын шалгуур **3.3. Барилгын каркасыг анкерлах** 3.3.1. Суурга /анкер/ 3.3.2. Босгоны үе/ хавтан **3.4. Дам нуруу & Гулдмай** 3.4.1. Хамгаалалт 3.4.2. Хамгийн их алгасал 3.4.3. Хучилтыг тулах дам нуруу 3.4.4. Дам нуруу & Гулдмайн тулгуур **3.5. Хучилтын нүх** 3.5.1. Гулдмайд тавих шаардлага/богиносгосон модон балк, дам нурууны хоорондох ригель/ **3.6. Дотор ханын тулгуур** 3.6.1. Гулдмай, хавтан & Дам нуруунд тавих шаардлага **3.7. Тагт** 3.7.1. Тавих шаардлага **3.8. Шаллагаа** 3.8.1 Шаллагаанд тавих шаардлага	- - - - - - - - - - -	Ачаалал ба үйлчлэл, БНбД 2.01.07-90 /10, хавсралт 5/ Барилгын газар шороо ба буурь суурийн ажил, БНбД 3.02.01-90 Инженерийн бус хийцтэй барилгыг төлөвлөх,барих зөвлөмж /газар хөдлөлттэй бүс нутагт/, Модон барилга Деревянные конструкции, СНиП II-25-80, Стальные конструкции, СНиП II-23-81 Орон сууц, олон нийтийн барилгын дам нурууны тулгуур дэр, MNS 1118:82 Деревянные конструкции, СНиП II-25-80 Деревянные конструкции, СНиП II-25-80 Орон сууц, олон нийтийн барилгын тагтны ба саравчны төмөр бетон хавтан, MNS1917:82 “Шалны ажил”, БНбД 3.04.04-90
4-р хэсэг. Өрөө тасалгаа ба орон зайн хэмжээ **4.1. Орон зай, талбайн төлөвлөлт** 4.1.1. Ерөнхий зүйл 4.1.2. Таазны өндөр 4.1.3. Коридор	**4. Ерөнхий зүйл** 4.3, 4.4, 4.8 4.5 -	 “Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм”, БНбД 31-01-01
5-р хэсэг. Барилгаас гарах арга хэрэгсэл **5.1. Ерөнхий зүйл** 5.1.1. Хамрах хүрээ 5.1.2. Ерөнхий зүйл **5.2. Гарц** 5.2.1. Гарцанд хүрэх 5.2.2. Сууцны хэсгээс гарах гарц **5.3. Хаалга & Цонх** 5.3.1. Гарц бүхий хаалга	 - - **6. Галын аюулгүйн байдал** - 6.6 **4. Ерөнхий зүйл** 4.6	“Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм”, БНбД 31-01-01 “Барилга, байгууламжийн галын аюулгүйн байдал”, БНбД 21-01-02 Барилга, байгууламжийн галын аюулгүйн байдал, БНбД 21-01-02 Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлт-ийн нормаль, БД 31-101-04 Орон сууц, олон нийтийн барилгын шил ба шилэн

5.3.2. Цонх	-	багцтай модон цонх, тагтны хаалга, нэр төрөл, бүтэц бүтэц, хэмжээ, MNS 4754:99
	6. Галын аюулгүй байдал	
5.4. Шат, налуу зам, шатны бариул & Хайс, хашлага	**7. Ашиглалтын үеийн аюулгүй ажиллагаа**	
5.4.1. Хамрах хүрээ	7.2	Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм, БНбД 31-01-01
5.4.2. Ерөнхий зүйл	6.7,6.8	Барилга, байгууламжийн галын аюулгүйн байдал, БНбД 21-01-02 /6.29-45/, Олон нийт, иргэний барилга, БНбД 31-03-03
5.4.3. Шатны хэмжээ	-	Шатны чулуун гишгүүр, MNS 2270:75
5.4.4. Шатны талбайн хэсэг	-	Орон сууц, олон нийтийн барилгын угсармал төмөр бетон шатны өгсөл, талбайн хавтан, MNS 1008:82
5.4.5. Муруй шат & Шат гишгүүр	-	-
5.4.6. Хайсны бүтэц	-	-
5.4.7. Өнцгөн тулгуурт /консолон/ угсармал бетон гишгүүр	-	Олон нийт, иргэний барилга, БНбД 31-03-03 /3.64, 3.65/
5.4.8. Налуу зам /рамп/	-	
5.4.9. Шатны бариул	-	
5.4.10. Хайс, хашлага	6.10, 7.3, 7.4	
6-р хэсэг. Галын аюулгүйн байдал & Дуу чимээнд тавих хяналт	**6. Галын аюулгүйн байдал**	
6.1. Галаас хамгаалах		Барилга, байгууламжийн галын аюулгүйн байдал" БНбД 21-01-02
6.1.1. Ерөнхий зүйл	6.1	Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм, БНбД 21-02-02 /2-р хэсэг/
6.1.2. Гал тэсвэршилийн хязгаар	6.2, 6.3, 6.4, 6.5	Олон нийт, иргэний барилга, БНбД 31-03-03 /3/
6.1.3. Галын хурд	-	Барилга, байгууламжийн галын аюулгүйн байдал" БНбД 21-01-02 /Барилгын материал/
6.1.4. Пенопласт	-	Олон нийт, иргэний барилга, БНбД 31-03-03 /3.9, 3.45/
6.1.5. Зоорийн хөндий	-	Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм, БНбД 21-02-02 /3.2-3.6, 5.4, 5.5/
6.1.6. Хий & Цахилгаан зуух /плитк/	-	-
6.2. Гал илрүүлэлт		Гал түймэр илрүүлэх ба унтраах автомат тоног төхөөрөмжөөр хамгаалах шаардлагатай б/б, өрөө тасалгаа, т/т-ийн жагсаалт, НПБ 110-96
6.2.1. Утааны дохиолол	6.13	
6.3. Гал тэсвэрлэлт		
6.3.1. Ерөнхий зүйл	-	Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн байдал, БНбД 21-02-02
6.3.2. Барилгын орон зайн тусгаарлалт	6.10	5.17-5.21
6.3.3. Гал тусгаарлагч хана, нам хана & Гал эсэргүүцэх тусгаарлагч	-	5.12-5.14
6.3.4. Гал унтраалт	6.18, 6.19	8.1-8.14
6.3.5. Гал тусгаарлалтын нүх болон гал эсэргүүцэх тусгаарлагчийн нэвтрүүлэх үйлчилгээ	-	Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм, БНбД 21-02-02 /Галаас хамгаалах хаалт/
6.3.6. Галаас тусгаарлах хаалга, чийгшүүлэгч, бусад хаалт, хашлага	6.6	Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм, БНбД 21-02-02 /Галаас хамгаалах хаалт/
6.4. Гал унтраах		
6.4.1. Шүршилтийн систем	-	

6.4.2. Гал унтраагуур	6.18, 6.19	
6.5. Дуу чимээнд тавих хяналт	**8. Ариун цэвэр-эрүүл ахуйн шаардлагыг хангах**	
6.5.1. Дуу дамжуулалтын зэрэглэлийн үнэлгээ /агаарын чимээ/	-	“Защита от шума”, СНиП II-12-77
6.5.2. Дуу чимээг хянах шаардлагатай төхөөрөмжийн байрлал /агаарын чимээ/	8.8	“Защита от шума”, СНиП II-12-77
7-р хэсэг. Ханын бүтэц		
7.1. Модон бүтэц бүхий хана барих		Модон бүтээц, БНбД 3.03.08-88
7.1.1. Ерөнхий зүйл	-	1.Ерөнхий ойлголт
7.1.2. Ханын тулаас /тулгуур/	-	-
7.1.3. Ханын тулаасуудыг холбох хөндөл /дүнз/	-	-
7.1.4. Цонхны онгорхойг хөвөөлөх	-	4.19, 4.20,4.21, 4.22
7.1.5. Ханын бүтээц хадаасаар хадах	-	2.13
7.1.6. Хана өнгөлгөө	-	-
7.1.7. Бүтээцийн хэсэглэлийн зүсэлт & Өрөмдлөг	-	4.13
7.2. Газрын түвшнээс дээшх чулуун өрлөгийн ажил		
7.2.1. Ерөнхий зүйл	-	“Өрөгт бүтээц”, БНбД 3.03.05-90 /1,2/
7.2.2. Чулуун өрөгт тулгуур	-	Инженерийн бус хийцтэй барилгыг төлөвлөх, барих зөвлөмж, 2002 он /3.Даацын тоосгоны ханатай барилга/, “Өрөгт бүтээц”, БНбД 3.03.05-90 /4,6/
7.2.3. Даацын тулгуур	-	
7.2.4. Зузаан & Өндөр	-	
7.2.5. Барилгын зуурмаг	-	“Өрөгт бүтээц”, БНбД 3.03.05-90 /3/
7.2.6. Зуурмагийн холбогч	-	“Өрөгт бүтээц”, БНбД 3.03.05-90 /3/
7.2.7. Холбоос & Зангилаа	-	“Өрөгт бүтээц”, БНбД 3.03.05-90 /3/
7.2.8. Хамгаалалт	-	“Өрөгт бүтээц”, БНбД 3.03.05-90 /8/
7.2.9. Газар хөдлөлтийг эсэргүүцэх арматурлалт	-	“Өрөгт бүтээц”, БНбД 3.03.05-90 /9/
7.2.10. Нарийн хоолой & Ханын хөндий	-	Ханын өргийн хэсэглийн нэг маягийн цоморлиг, Цуврал Д.232-1
7.2.11. Борооны ус нэвтрэлтийг хянах	-	Дээвэр, ус, уур,дулаан тусгаарлалтын ажил,БНбД 3.04.01-8
7.3. Ган тулаас бүхий хана барих		
7.3.1. Ерөнхий зүйл	-	Стальные конструкции, СНиП II-23-81
7.3.2. Бүтээцийн хэмжээ	-	Барилга байгууламжийн ган.Техникийн шаардлага, MNS 4237:94
8-р хэсэг. Дээврийн хучилт		
8.1. Модон бүтээц		Дээврийн хучлага, БНбД 31-02-03
8.1.1. Хамрах хүрээ	-	“Ачаалал ба үйлчлэл” БНбД 2.01.07-90 /5.Цасны ачаалал/, Орон сууц, олон нийтийн тоосгон барилгын хучилтын хэсэглэл, Цуврал Г1.040-2Г, 1986 он, Адрын хучлага
8.1.2. Тусгай ачаалал	-	
8.1.3. Дээвэр хадаасаар хадах	-	
8.1.4. Ачааллын тулгуур	-	

8.1.5. Хамгийн их алгасал	-	
8.1.6. Дээвэр & Таазны даацын бүтээц		
8.1.7. Шувуу нурууны татанга	-	
8.1.8. Хэрчилт & Өрөмдлөг	-	
	-	
8.2. Дээврийн хучлага		
8.2.1. Дээврийн хучлага	-	Дээврийн хучлага, БНбД 31-02-03
8.3. Дээвэр & Адрын агааржуулалт		
8.3.1. Агааржуулга	-	Дээврийн хучлага, БНбД 31-02-03 /8.3-5/
8.4. Адрын ашиглалт		
8.4.1. Ашиглалт	-	Орон сууц, олон нийтийн тоосгон барилгын хучилтын Хэсэглэл, Цуврал г1.040-2Г, Адрын хучлага Дээврийн хучлага, БНбД 31-02-03 /2.14/
8.5. Дээврийн хучилт		
8.5.1. Ерөнхий зүйл		Дээврийн хучлага, БНбД 31-02-03 /1/
8.5.2. Хадаас & Дэгээ	-	Дээвэр, ус, уур, дулаан тусгаарлалтын ажил, БНбД 3.04.01-88
8.5.3. Дээврийн налуу	-	Дээврийн хучлага, БНбД 31-02-03 /1.2, 1.6/
8.5.4. Уулзварт хийх гагнаас	-	Инженерийн бус хийцтэй барилгыг төлөвлөх,барих зөвлөмж /газар хөдлөлттэй бүс нутагт/, Модон барилга
8.5.5. Саравчны хамгаалалт & Ан цав, савх модонд зориулсан ивээс	-	
8.5.6. 1 ба 3-аас илүү налуутай дээврийн хар тос сайр чулуу	-	
8.5.7. 1 ба 3-аас бага налуутай дээврийн хар тос сайр чулуу	-	
8.5.8. Модон дээврийн савх мод	-	
8.5.9. Гар аргаар хуваасан дээврийн савх мод	-	
8.5.10. Угсармал дээвэр	-	
8.5.11. Дээврийн захын хучлага	-	
8.5.12. Нимгэн гөлмөн төмөр хучилт	-	Дээврийн хучлага, БНбД 31-02-03 /5/
8.5.13. Хуванцар хучилт	-	-
8.5.14. Хар цаасан хучилт	-	Дээврийн хучлага, БНбД 31-02-03 /4/
8.5.15. Поливинил хлорид хавтан хучилт	-	-
3.5.16. Бетон хавтан хучилт	-	Дээврийн хучлага, БНбД 31-02-03 /6.1-4/
8.5.17. Дээврийн ус зайлуулах хоолой ба цорго	-	Дээврийн хучлага, БНбД 31-02-03 /7.1-9/
	-	
9-р хэсэг. Цонх, гэгээвч & Хаалга		Орон сууц, олон нийтийн барилгын шил ба шилэн багцтай модон цонх, тагтны хаалга. Нэр төрөл, бүтээц, хэмжээ. MNS 4754:99
9.1. Цонх		
9.1.1. Цонхны стандарт	-	Орон сууц, олон нийтийн барилгын 3 давхар модон цонх, тагтын хаалга, MNS 4948:2000
9.1.2. Цонхны хамгийн бага талбай	-	
9.1.3. Чигжээс & Шиллэгээ	-	Заслын ажил. БНбД 3.04.02-88 /Шилний ажил/

9.2. Гэгээвч 9.2.1. Гэгээвч **9.3. Хаалга** 9.3.1. Ерөнхий зүйл 9.3.2. Шаардлагатай хаалга 9.3.3. Орцны хэмжээ 9.3.4. Хаалганы өндөр 9.3.5. Гадна талын хаалга 9.3.6. Дулаан алдагдал 9.3.7. Шил **9.4. Зайлшгүй орцны тэсвэрлэлт** 9.4.1. Гадна талын хаалга 9.4.2. Цонх	- **4.Ерөнхий зүйл** 4.6 - 4.6 4.6 4.6 - - - -	Естественное и искусственное освещение, СНиП 23-05-95 “Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль”, БД 31-101-04 - - - Модон хаалга.Дулаан дамжуулалтын эсэргүүц-лийг тодорхойлох арга, MNS 4194: 1993 Заслын ажил. БНбД 3.04.02-88 /Шилний ажил/ Наамал шилэн багц. Техникийн шаардлага, MNS 4753:99 Барилгын модон хаалга, цонх, тагтны хаалга. Техникийн шаардлага. MNS 0531: 2002
10-р хэсэг. Задгай зуух, яндан & Тогоо **10.1. Задгай зуух /камин зуух/** 10.1.1. Ерөнхий зүйл 10.1.2. Задгай зуухны агаарын шаталт 10.1.3. Шатамхай материалын зай хэмжээ 10.1.4. Зуухны агаар сорох суваг хоолой 10.1.5. Задгай зуухны хана ба пийшин 10.1.6. Үйлдвэрийн задгай зуух 10.1.7. Задгай зуухны завсар зай **10.2. Яндан & Утааны суваг** 10.2.1. Ерөнхий зүйл 10.2.2. Шатамхай хийц бүтээцээс авах зай хэмжээ 10.2.3. Утааны суваг 10.2.4. Утааны сувгийн өнгөлгөө/ доторлогоо 10.2.5. Чулуун өрлөгөн & Бетон яндан	**6. Галын аюулгүй байдал** - 6.16 - - - - - 6.15 - - - -	Өрөгт бүтээц, БНбД 3.03.05-90, 12-р хэсэг 1.1, 12.1- 4 - 12.23, хүснэгт 17, 12.24, 12.25 12.26-29 12.5-23, 12.30-40 - - Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер, БНбД 41-01-02 Өрөгт бүтээц, БНбД 3.03.05-90, 12.21-24, хүснэгт 17 12.18-20, 12.26-28 12.34, 35, 37 12.27
11-р хэсэг. Тусгаарлалт, агаар тусгаарлах систем & Уур тусгаарлалт 11.1. Ерөнхий шаардлага 11.1.1. Хамрах хүрээ **11.2. Тусгаарлалт**	**8. Ариун цэвэр-эрүүл ахуйн шаардлагыг хангах** 8.10 -	Дээвэр, ус, уур, дулаан тусгаарлалтын ажил, БНбД 3.04.01-88 Дээвэр, ус, уур, дулаан тусгаарлалтын ажил,

11.2.1. Ерөнхий зүйл 11.2.2. Угсралт **11.3. Агаар тусгаарлалтын систем** 11.3.1. Ерөнхий зүйл 11.3.2. Системийн шинж чанар 11.3.3. Үргэлжлэл **11.4. Уур тусгаарлалт** 11.4.1. Ерөнхий зүйл 11.4.2. Материал 11.4.3. Угсралт	- - - - - 8.10 - -	БНбД 3.04.01-88 Барилгын хашлага бүтээц.Агаарын дуу тус-гаарлалтыг хэмжих арга”, MNS 5070:2001 Дээвэр, ус, уур, дулаан тусгаарлалтын ажил, БНбД 3.04.01-88
12-р хэсэг. Механик систем **12.1. Халаалт & Агаар зохицуулалт** 12.1.1. Ерөнхий зүйл 12.1.2. Шаардлагатай халаалтын систем 12.1.3. Тооцооны температур 12.1.4. Халаалт & Агаар зохицуулалтын системд тавих ерөнхий шаардлага 12.1.5. Халаалт & Агаар зохицуулалтын хэрэгсэл 12.1.6. Хөргөх систем & Агаар зохицуулалтын тоног төхөөрөмж 12.1.7. Яндан & Агааржуулалтын тоног төхөөрөмж **12.2. Хуваарилах систем** 12.2.1. Агаар дамжуулах систем 12.2.2. Радиатор & Конвектор 12.2.3. Халаалт & Хөргөлтийн системийн шугам хоолой **12.3. Агааржуулалт** 12.3.1. Ерөнхий зүйл 12.3.2. Халаалтын бус үеийн агааржуулалт 12.3.3. Халаалтын үеийн /механик/ агааржуулалт	 - 6.14 8.2 6.15, 7.6, 9.1-9.8, 12.1.2 - - - 8.3 - - - 8.4 8.4	Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер,БНбД 41-01-02 Хийн хангамжийн төлөвлөлтийн норм, БНБД42-01-04 - Халаалт, агаар сэлгэлт ба кондиционер,БНбД 41-01-02 Дулааны шугам сүлжээ, БНбД 3.05.03-95 Халаалт, салхивчийн агааржуулалтын ажлын зураг, MNS 3240:2003 Халаалт, салхивчийн агааржуулалтын ажлын зураг, MNS 3240:2003
13-р хэсэг. Сантехник & Цахилгаан тоног төхөөрөмж **13.1. Сантехникийн тоног төхөөрөмж** 13.1.1. Ерөнхий зүйл 13.1.2. Усан хангамж & Хуваарилалт 13.1.3. Шаардлагатай тоног төхөөрөмж 13.1.4. Ахуйн хэрэгцээний халуун ус 13.1.5. Бохир ус зайлуулалт	 - 8.11, 8.12 - 7.6 8.12	Дотор сантехникийн систем, БНбД 3.05.01-88 Дотуур ус түгээгүүр, MNS 3239:1989 Усан хангамж, бохир ус, гадна шугам сүлжээ, түүний б/б-мж, БНбД 3.05.04-90 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт, MNS 0090:1992 Усан хангамж, ариутгах татуургын төвлөрсөн системд хэрэглэгчдийг холбох техникийн

13.2. Цахилгааны тоног төхөөрөмж 13.2.1. Ерөнхий зүйл 13.2.2. Гэрлийн нүх/ хоолой & Унтраагуур	 6.17 -	нөхцөл, MNS 4236:2003 Цахилгаан техникийн ажил, БНбД 3.05.06-90 Дотор цахилгаан, гэрэлтүүлэг.Ажлын зураг, MNS 3757:1984, Орон сууцны барилгын гэр-лийн самбар, MNS 2285:1994
14-р хэсэг. Дотор заслын ажил **14.1. Хана, таазны заслын ажилд тавих ерөнхий шаардлага** 14.1.1. Ерөнхий зүйл 14.1.2. Модон өнгөлгөө 14.1.3. Гипсэн банзны заслын ажил 14.1.4. Шавардлага 14.1.5. Фанерын заслын ажил 14.1.6. Шахмал банзны заслын ажил 14.1.7. Нарийн ширхэг бүхий банзан тусгаарлагчийн заслын ажил 14.1.8. Модны үртсэн хавтан, зоргодсон хавтангийн заслын ажил 14.1.9. Ханын заслын ажил **14.2. Шалны дэвсгэр үе/ хучилт** 14.2.1. Ерөнхий зүйл 14.2.2. Панелен төрлийн ивээс 14.2.3. Шулуун модон дэвсгэр 14.2.4. Паркетан шал 14.2.5. Шалны зөөлөн хучилт 14.2.6. Керамик хавтанцар	 - - - - - - - - - - - - - - -	 Заслалын ажил, БНбД 3.04.02-88 1. Ерөнхий заалт - - 7. Шавардлага, баримлын ажил - - - - - Шалны ажил, БНбД 3.04.04-90 1. Ерөнхий заавар 3. Дэвсгэр үеийг тавих Зүймэл шал - Полимер материалаар хийх өнгө үе Хавтанцараар хийх өнгө үе Шалны керамик хавтанцар. Техникийн шаардлага МНС 0230-82
15-р хэсэг. Гадна заслын ажил **15.1. Борооны ус нэвтрэлтээс хамгаалах** 15.1.1. Ханыг бүрэх үе 15.1.2. Гадна ханын дотор заслалын ажил **15.2. Чулуун гадар** 15.2.1. Ерөнхий зүйл 15.2.2. Зузаан 15.2.3. Барилгын зуурмаг 15.2.4. Зуурмагийн холбогч 15.2.5. Өргийн зөрлөг, ам даралт & Зангилаа, холбоос 15.2.6. Чулуун өрлөгтэй тулгуур 15.2.7. Борооны ус нэвтрэлтээс хамгаалах, хянах	 - - - - - - - - 8.10	 Заслалын ажил, БНбД 3.04.02-88 Заслалын ажил, БНбД 3.04.02-88

15.3. Шилэн блок 15.3.1. Ерөнхий зүйл	 -	Барилгын шил, шилэн эдлэхүүний техникийн нөхцөл. MNS …
15.4. Гадна талын ханыг бүрэх материал 15.4.1. Хамрах хүрээ 15.4.2. Ерөнхий зүйл 15.4.3. Ус тусгаарлах дэвсгэр үе 15.4.4. Битүүлэлт 15.4.5. Ханыг бүрэхэд хавсарч хэрэглэх материалууд 15.4.6. Модон хөвөө/ гадарлагаа 15.4.7. Модон дранк 15.4.8. Асцестоцементэн дранк ба нимгэн хавтан 15.4.9. Фанер 15.4.10. Зоргодсон хавтан 15.4.11. Метал 15.4.12. Поливинилхлоридэн хажуугийн хөвөө/ бүрхүүл	 - - - - - - - - - - - - -	Заслын ажил, БНбД 3.04.02-88 /8/ Хана өнгөлгөөний материал.Ус шингээлт, хүйтэн тэсвэрлэлтийг тодорхойлох арга, MNS 0983:1980 Дээвэр, ус, уур, дулаан тусгаарлалтын ажил,БНбД 3.4.1-88 - Хана өнгөлгөөний материал,нягт тодорхойлох арга, MNS 2915:1980 Барилгын харуулдсан тууш модон эд анги. Техникийн шаардлага. MNS 0914:1986 Асбестоцементные конструкции, СНиП 2.03.09-85 Фанер, техникийн шаардлага. MNS 0355:1987 Зоргодсон хавтан.Технологи, MNS 0122:1988 Төмөр хийц эдлэл. Техникийн шаардлага,MNS 2630:1989, Метал бүтээц. Техникийн шаардлага, MNS 2630:2001 -
15.5. Гадна шавардлага заслын ажил 15.5.1. Ерөнхий зүйл 15.5.2. Гадна заслын хөвөө & Бэхэлгээ 15.5.3. Гадна заслын материал 15.5.4. Гадна заслын зуурмаг 15.5.5. Гадна заслын ашиглалт	 - - - - -	Заслын ажил, БНбД 3.04.02-88 /7/
16-р хэсэг. Гараж & Саравч **16.1. Ерөнхий шаардлага** 16.1.1. Хамрах хүрээ 16.1.2. Суурь 16.1.3. Хана & Багана	 6.11 - -	Цөөн давхар сууц барих газрын төлөвлөлт-зохион байгуулалт, барилгажуулалт, БД 30-101-04 “Барилга байгууламжийн буурь, суурийн зураг төсөл зохиох норм ба дүрэм”,БНбД 2.02.01-94 Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх, БНбД 22-01-01, /Каркасан барилга/
Алгасалтын хүснэгт	-	-
Жагсаалт	-	-

ХАВСРАЛТ Д. Хархорин хотын хөгжлийн Ерөнхий төлөвлөгөөнд хийсэн үнэлэлт

Хотын түүхийн болон соёлын онцлог шинж нь Хархорин хотыг Хангай бүсийн тулгуур хоёр төвийн нэг болгоход суурь болж өгсөн бөгөөд хотыг бүсийн тулгуур төв болгон цаашид хөгжүүлэхэд шинэлэг, онцгой чиг хандлага болон дүрэм журам шаардагдах нь гарцаагүй юм. Түүнчлэн МУ-ын ЗГ Хархорин хотыг загвар хот болгох хөгжүүлэх тухай мэдэгдсэн.

Хархорин хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөг 2004 оны 6 дугаар сард МУ-ын Ерөнхий сайдын тогтоолоор баталсан бөгөөд "Хот байгуулалт" улсын үйлдвэрийн газар боловсруулсан байна. Бусад бүс нутгийн тулгуур төвүүдийн Ерөнхий төлөвлөгөөг боловсруулахад ашигласан ажил үүргийн хуваарьтай төстэй дээрээс доош чиглэсэн буюу төвлөрсөн төлөвлөлтийн чиг хандлагыг ашигласан байна.

Энэхүү Ерөнхий төлөвлөгөө нь үндэсний, бүс нутгийн болон орон нутгийн түвшин дэхь Хархорин хотын давуу талуудыг ашиглахад чиглэсэн байна. Мөн хотыг хөгжүүлэх нь Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын онцлог хэсэг болохыг тэмдэглэхийн зэрэгцээ Монгол улсын Засгийн газраас баталсан төлөвлөлтийн журам, баримт бичгүүдийг үндэслэн боловсруулсан байна. Төлөвлөгөөний зарим онцлог шинжээс дурьдвал.

Зам тээврийн үндсэн сүлжээ

Үндэсний болон бүс нутгийн хэмжээнд зам тээврийн салбарт хэрэгжүүлэх арга хэмжээнээс Хархорин хотын хөгжлийн ирээдүй ихээхэн хамаарна, үүнд:

- Хот Мянганы замаас 60 км-ын хүрээнд байрлах
- Хархорин-Хөшөө цайдамын хатуу хучилттай авто зам барих
- Тэшиг- Булган – Хархорин – Арвайхээр – Шивээхүрэнгийн босоо тэнхлэгийн хэсэг Элсэн тасархайгаас Хархорин хүртлэх хатуу хучилттай замыг сайжруулж, Хархорин – Хужиртын хатуу хучилттай замыг барих, Хужирт – Арвайхээр, Хужирт – Бат-Өлзийн замыг барих
- Ойрын хугацаанд Эрдэнэтээс Хархорин хүртэл төмөр зам тавих
- Баруун аймгуудын чиглэлд тус хотыг дайран өнгөрөх зам нь хотын барилгажсан хэсгийн гол магистраль зам болох, түүнийг сайжруулах зэрэг болно.

Газар ашиглалт

Ерөнхий төлөвлөгөөгөөр Хархорин хотын газар ашиглалтыг дараах үндсэн бүсээр ангилжээ. Үүнд:

- Хотын төвийн бүс
- Одоо байгаа болон төлөвлөлт бүхий орон сууцны бүс
- Одоо байгаа болон төлөвлөлт бүхий аж үйлдвэрийн бүс
- Түүх соёлын дурсгалт зүйлсийн хамгаалалтын бүс
- Спорт, амралт зугаалга, нийтийн хэрэгцээний болон хамгаалалттай ногоон бүс

Төлөвлөж буй хотын төвийн хэсэг нь хөгжлийн 3 үндсэн хэсгээс бүрдэнэ: 1/ шинэ бизнесийн төв, 2/ олон улсын аялал жуулчлалын төв, 3/ Их хаадын цогцолбор.

Шинээр төлөвлөж байгаа бизнесийн төвд бүсийн засаг захиргааны ордон; шинжлэх ухаан мэдээлэл-технологийн төв; интернет, бизнес мэдээллийн төв; бүс нутгийн агентлагууд; банк; театр зэрэг томоохон цогцолборууд багтана.

Олон улсын аялал жуулчлалын төвд өндөр зэрэглэлийн зочид буудал, үзэсгэлэн, үзвэрийн танхим, банк санхүү, холбоо мэдээлэл болон худалдаа үйлчилгээний цогцолборууд орно.

Их хаадын цогцолборт хүндэтгэл, ёслолын өргөө бүхий их хаадын үзэсгэлэнгийн танхимууд, Монгол судлал, Угсаатны зүйн судалгаа шинжилгээний төв, Түүх археологи, палентологийн олон улсын шинжилгээ судалгааны төв, нүүдлийн соёл иргэншил, угсаатны зүйн музей, үзмэр үйлчилгээний цогцолборууд байна.

Төлөвлөлт бүхий орон сууцны хэсэг нь доороо үйлчилгээтэй нийтийн давхар сууц, эдэлбэр газартай буюу эдэлбэр газаргүй амины орон сууц, их дээд сургуулийн хэсэг, эмнэлэгийн хэсэг, худалдаа үйлчилгээний хэсэг гэж ангилан гэр хорооololд багийн төв, жижиг үйлчилгээний цэгүүд мөн төлөвлөгдсөн байна.

Аж үйлдвэрийн бүсийг одоо байгаа үйлдвэрлэлийн хэсэгт барихаар төлөвлөсөн байна. Ашиглаж байгаа байр бүхий үйл ажиллагаагаа амжилттай явуулж байгаа компаниуд тэндээ үлдэнэ. Зарим нэгж байгууллагууд нүүх шаардлагатай болох байх. Хархорин хотын байгалийн баялаг, нөхцөл байдал нь хүнд үйлдвэр хөгжүүлэх боломж муутай. ХАА-н бүтээгдэхүүн боловсруулах болон аялал жуулчлалын чиглэлийн хөнгөн үйлдвэрийг хөгжүүлэх боломжтой.

Түүх соёлын зүйлсийн хамгаалалттай бүс нь Эрдэнэзуу хийд, түүний хамгаалалтын бүс, малталт хийж байгаа туйрын нутаг дэвсгэрүүдийг хамарна.

Ерөнхий төлөвлөгөөний одоогийн байдал, хэрэгжилтийн эхний үе шат, төлөвлөлтийн хугацаа зэрэг техник-эдийн засгийн зарим үндсэн үзүүлэлтийг Хүснэгт 1-т үзүүлэв. Энэхүү ерөнхий төлөвлөгөөнд хэрэгжилтийн нэгдүгээр үе шат үргэлжлэх хугацааны талаар тодорхой тусгаагүй атлаа сүүлийн 3 жилд Хархорин хотод оруулсан хөрөнгө оруулалтаас 20 дахин ихийг оруулахаар төлөвлөжээ.

Уг төлөвлөгөөнд шинээр хэрэгжүүлэх арга хэмжээ ба барих барилга байгууламжийг нэлээд тодорхой заасан боловч хэрхэн хэрэгжүүлэх талаар чиглэл зөвлөмжүүд цөөн байна. Орон нутгийн шийдвэр гаргагчид энэхүү төлөвлөгөөг ашиглахад тодорхой бус асуудлууд нэлээд байна.

Хүснэгт1: Техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Одоогийн байдал	Эхний ээлж	Төлөвлөлтийн хугацаа
1	Хархорины хүн ам – бүгд	Хүн	13496	19000	38000
	• Үүнээс хотын төвд	Хүн	8977	15000	30000
2	Хүн амын насны бүтэц				
	• Сургуулийн өмнөх насны хүүхэд	Хүн	2237	3200	6000
	• Сургуулийн насны хүүхэд	Хүн	2648	4000	7700
	• Хөдөлмөрийн насны хүн ам	Хүн	7591	10700	22000
	• Тэтгэврийн насны хүн ам	Хүн	1020	1100	2300
3	Өрх – бүгд	Тоо	3391	4520	9500
	• Үүнээс хотын төвд	Тоо	2146	3570	7500
4	Нутаг дэвсгэр	Га	2050	2050	2050
	а/ Орон сууцны хэсэг	Га	930,6	930,6	930,6
	• Нийтийн орон сууц	Га	2,5	29,8	87,5

	• Гэр хороолол	Га	295	397,5	532,5
	• Нийтийн соёл ахуйн үйлчилгээ	Га	45	72,3	119,7
	• Нийтийн хэрэгцээний ногоон байгууламж	Га	2	23	47
	• Гудамж, зам, талбай	Га	25	42	68
	• Нөөц талбай	Га	561,1	366	75,9
	b/ Аж үйлдвэрийн хэсэг	Га	58	68,5	68,5
	c/ Тусгай зориулалтаар ашиглаж буй газар	Га	10,5	-	-
	d/ Бусад	Га	1050,9	1050,9	1050,9
5	Хүн амын нягтрал				
	• Орон сууцны хэсэгт	Хүн/ га	9,6	16,1	32,2
6	Оршин суугчид /сууцны төрлөөр/	Хүн	8977	15000	30000
	• Нийтийн орон сууц	Хүн	470	1970	10500
	• Хувийн орон сууц	Хүн	-	455	4500
	• Гэр, ердийн сууц	Хүн	8507	12575	15000
7	Орон сууцны хангамж	%	100	100	100
	• Нийтийн орон сууц	%	5,2	13	35
	• Хувийн орон сууц	%	-	3	15
	• Гэр, ердийн сууц	%	94,8	84	50
9	Сүүлийн 3 жилийн ойролцоох хөрөнгө оруулалтын хэмжээ / эх үүсвэрээр/	Сая. Төг	637,4		
	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	Сая.төг	349,5		
	Орон нутгийн хөрөнгө оруулалт	Сая.төг	28,0		
	Хувийн хөрөнгө оруулалт	Сая.төг	234,9		
	Гадаадын хөрөнгө оруулалт	Сая.төг	25,0		
10	Эхний ээлжийн хөрөнгө оруулалт	Сая.төг	-	12895,0	
	Хот доторх зам /30 км/	Сая.төг	-	75,0	
	Цэвэрлэх байгууламжийн шинэчлэлт	Сая.төг	-	600,0	
	Усны эх үүсвэр тогтоох, усан сан	Сая.төг	-	20,0	
	Хотын төвийн барилгажилт, цэвэр, бохир усны шугам	Сая.төг	-	2500,0	
	Дулааны станц ба гадна дулааны шугам сүлжээ засварлах	Сая.төг	-	2000,0	
	Орон сууц /480 айл/ 22000 □2/	Сая.төг	-	7700,0	

Ерөнхий төлөвлөгөө, түүний хэрэгжилтэнд хийх тайлбар

Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга замын талаар хангалттай тусгаагүй байна Ойрын хугацааны үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилтийн эх үүсвэр тодорхой бус, хэрэгжилтийн үйл ажиллагааны талаарх үүрэг хариуцлагыг тодорхой шийдээгүй байна. Барилгажилтын төлөвлөгөөг ерөнхийд нь боловсруулсан хэдий ч түүхийн ач холбогдолтой энэхүү нутаг дэвсгэрийг жинхэнэ бодит утгаар нь хэрхэн хөгжүүлэх болох талаар тусгаагүй байна. Шаардлагатай бүх зүйлийг тусгаснаар Ерөнхий төлөвлөгөө жинхэнэ утгаар хэрэгждэг.

Ерөнхий төлөвлөгөөний зарим нэгэн зүйлүүд Хархорин хотын онцлог шинж чанартай уялдаж байгаа хэдий ч барилгажилтын төлөвлөгөөний хувьд МУ-ын бусад хот суурин газарт ашигладаг барилгажилтын төлөвлөгөөнөөс ялгарах онцлог зүйл байхгүй байна. Хархорин хотыг хөгжүүлэх нь өнгөрсөн одоо болон ирээдүй үеээ нэгтгэх цорын ганц боломж бүрдэж байгаа учраас түүний хөгжлийн төлөвлөлтийг шинэлэг, онцгой хэлбэрээр хийх шаардлагатай юм.

Түүнчлэн МУ-ын архитекторууд энэ олдож буй боломжийг бүрэн дүүрэн ашиглан бүх төрлийн барилга байгууламжийг жинхэнэ Монгол архитектурын хэв маягаар төлөвлөлт хийх эрин үеийн эхлэлийг тавих боломжтой юм.

Хотын төв хэсэг

Хотыг төгс утгаар нь хөгжүүлэх явдал нь Хархориныг загвар хот болгох магадгүй МУ-ын ирээдүйн нийслэл болгоход чухал ач холбогдолтой юм. Энэхүү төгс хотын Их хаадын цогцолборын хэсэгт бие даасан томоохон барилга барих ажлыг хийж эхлэх нь зүйтэй. Уг барилгыг Наадмын дараагаар түүх, урлаг соёл, уран зохиол яруу найргийн их наадам болон олон улсын соёлын бусад арга хэмжээг жил бүр зохион байгуулах зориулалтаар ашиглана. Дотоод, гадаадын мэргэжилтнүүд, жүжигчдийг их наадамд урьж оролцуулах бөгөөд түүнээс олсон орлогыг хотыг хөгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулах боломжтой. Их наадамд оролцогчид тохижуулсан гэрт байрлана.

Дээрх аргыг Морокко улсын далайн эргийн Асилах хотод хэрэгжүүлсэн нь амжилттай болсон юм. Далайн эргийн энэ түүхт хот 11000 хүн амтай бөгөөд ойролцоогоор жилд 150000 аялагчид тус хотод зохион байгуулдаг урлагийн их наадамд оролцохоор ирдэг байна. Их наадмаас олсон хөрөнгийг хотыг сэргээн засварлахад зарцуулсан.

Орон сууцны зориулалттай газар

Хархорин хотод 470 иргэд давхар орон сууцанд амьдарч байгаа бөгөөд Ерөнхий төлөвлөгөөний дагуу энэ тоо төлөвлөгөөний эхний үе шатанд 2000, эцсийн хугацаанд 10500 хүртэл нэмэгдэхээр төлөвлөсөн байна. Эхний үе шатны дараа өрхийн тоо 480 нэмэгдэнэ гэж үзвэл 7,7 тэрбум төгрөгийг орон сууц барихад зарцуулах тооцоо гарч байна. Дээрх орон сууцны барилгын дийлэнхийг барилгын хувийн байгууллагууд барихаар тусгасан хэдий ч орон сууцны эрэлт байхгүй тохиолдолд барилга барих эсэх талаар тодорхой тусгаагүй байна. Орон сууцыг эхний ээлжинд жуулчид, оюутнуудад түрээслүүлэн дараа нь иргэдэд зарах зарчмаар орон сууцны барилга барьж болох бөгөөд энэ нь барилгын хувийн байгууллагуудыг тулгарч болзошгүй зарим эрсдлээс хамгаалж өгнө.

Ач холбогдол бүхий байршилтай гэр хорооллыг дахин төлөвлөн (блоклох) сайжруулан, дэд бүтцээр хангах замаар хотын орон сууцны нөхцлийг сайжруулах үйл ажиллагааг хийж эхлэх хэрэгтэй юм. Хархориныг загвар хот болгоход энэ үйл ажиллагааг хэрэгжүүлж эхлэнэ.



Орон сууцны хорооллын хэсэгчилсэн төлөвлөгөөний төсөлд дараахь хэд хэдэн үйл ажиллагааг хамруулан зэрэг хэрэгжүүлж болно.

- **Гэр хорооллыг дахин төлөвлөх, нөхцлийн сайжруулах;**
- **Орон сууцны нягтрал сайжруулах ;**
- **Хотын замыг сайжруулах;**
- **Хотын дэд бүтэц, байгаль орчныг сайжруулах**

Аж үйлдвэрийн бүс

Хотын аж үйлдвэрийн бүсийг аж үйлдвэрийн одоо байгаа газар дээр тулгуурлан эрхлэх үйлдвэрлэлийн төрөлд хяналт тавих замаар хөгжүүлэхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөнд 28 жижиг үйлдвэрлэлийн жагсаалтыг хамруулсан ба тэдгээрийн хэд хэдэн үйлдвэрлэл нь түүхийн болон тусгай хамгаалалттай газрын ойролцоо үйл ажиллагаа явуулахад тохиромжгүй байна. Түүнчлэн санал болгож буй зарим үйлдвэр, тухайлбал бетонон хийцийн үйлдвэр, савангийн үйлдвэр, авто засварын газар нь энэ бүсэд байрлах хориотой юм. Байгаль, түүхийн ач холбогдолтой газрын ойролцоо үйл ажиллагаа явуулахад тохиромжгүй үйлдвэрийг хотын зүүн хойд хэсэгт шилжүүлэхээр төлөвлөгөөнд тусгасан байна. Эко-үйлдвэрийн шинэ бүсийг хамгаалалттай болон сүм хийдийн газраас хол энэ бүсэд байгуулж болно. Үйлдвэрийн одоогийн бүсийг хатуу хяналтан дор цаашид дуу чимээ бага, бохируулдаггүй, гар урлал болон үндэсний онцлог бүхий үйлдвэрлэл эрхлэхэд ашиглаж болно.

Дэд бүтэц

Хотын дэд бүтцийг бүхэлд нь сайжруулах шаардлагатай байна. Дулаан, цэвэр бохир усан хангамж, цахилгаан холбооны орчин үеийн дэвшилтэт технологийг судлах, нэвтрүүлэн хэрэгжүүлэхэд судалгааны ажлыг өргөн хүрээтэй эрчимтэй явуулах шаардлагатай юм. Экологийн болоод техникийн шинэлэг чиг хандлагыг нэвтрүүлэх шаардлагатай. Хүрээлэн буй байгаль орчинтой харьцан хандах монголын уламжлал зан үйлийг шинэ дэвшилтэт технологитой хослуулснаар өнгөрсөн болон ирээдүйн харилцааг шинэ түвшинд хөгжүүлэн улмаар олон улсын анхаарал сонирхлыг татах ач холбогдолтой юм.

Хавсралт Е. 40000 ОРОН СУУЦНЫ ХӨТӨЛБӨРТ ОРОЛЦОХООР БХБЯ-д БҮРТГҮҮЛСЭН КОМПАНИУД

№	Компаниуд	Төслийн нэр	Байршил	Барих орон сууцны тоо			Шугам сүлжээ	Төсөвт өртөг	Хөрөнгийн эх үүсвэр /сая төг/	
				Нийтийн	Амины	Бүгд			Өөрийн	Бусад
1	Барилгачдын холбоо	Хайлааст төгөл	ЧД		30	30	48			
2	"Хар чонот" ХХК			112		112				859
3	Дэмэндээ Хоршоо	Гэр хорооллыг цогц хөгжүүлэх								
4	Дорноговь ЗДТГ			200	2	202				
5	Монтед ХХК	ТАХ-ын 1400	БГД, БЗД	1400		1400				1,000,000
6	Заг ХХК	Ногоон төгөл 600	СХД, СБД, БГД	600		600				500
7	Авзага трейд" ХХК	ТАХ-ын 200	СХД, СБД, БГД,БЗД	200		200				
8	Барилгын цэрэг 022,182,110,030	Офицеруудийн 1095	СХД, Эрдэнэт, Дархан,	1095		1095		61,618		16,765
9	"Цагаан бэлчир"ХХК	Батс-Өргөө 389	СХД, СБД, Сайншанд	388		388				
10	Хан хайрхан ХХК	Тамирчдын 72 айл	БГД	72		72		10,948		230
11	Нэгдсэн монгол ХХК	Сайншанд 96 айл	Дорноговь Сайншанд	96		96				
12	Эрдкон инженеринг кор	Эрдэнэт 500 айл	Эрдэнэт хот	500		500				
13	Сэргэн мандалт групп	Залуус 380 айл	СХД-54, Багануур 326	380		380				580
14	Өгөөж хишиг ХХК	Өгөөж хишиг хороолол	ХУД	15		15			121	500
15	Пума констракшн ХХК	Пума орон сууц 144		144		144		1,000,000		46
16	Сигма констракшн ХХК	Сэрүүн сэлбэ	БЗД	54		54				1,000,000
17	Хар хорин өргөө ХХК	Сайхан булаг	БГД	108		108				
18	Ганьт ХХК	Төрийн албан хаагчдын	ЧД БГД БЗД	1310		1310				
19	Засагт хан Андууд ХХК	Улиастай 200 айл	Завхан аймагт	200		200				205
20	Стройка ХХК	Барилгачдын 48 айл	БЗД	48		48				
21	Их барилга төсөл ХХК	Бугат	БЗД	198		198				
22	Москва комплекс	Амины орон сууц	СХД		980	980				
23	БНААХДТөв	БХБНААГ-ын 48 айл	БЗД	48		48				
24	Монсан групп	нэмэлт давхар	БГД	180		180				
25	Сантехмон ХХК		СХД	30		30				
26	Мажган ХХК	Офицеруудийн хотхон	СХД	100		100				зээл
27	Бага нуур Засаг дарга	Бага нуурт		555		555				50 о/с зээл авах
28	Шинэ дэлхий ХХК	о/с гүйцэтгэгчээр оролцох цемент оруулж ирэх лаборторитой								
29	Юнико ХХК	гүйцэтгэгчээр								
30	"Алтан дуулга хаус" ХХК	гүйцэтгэгчээр								
31	"Арвит" ХХК	гүйцэтгэгчээр								
32	иргэн Д.Нямдорж			20		20				газар хэрэгтэй
33	Завхан Засаг дарга	Улиастай 200	Улиастай							
34	"Рица"ХХК	гүйцэтгэгчээр	БГД	64		64				1944000ам.дол
				8,117	**1,012**	**9,129**		**1,072,565**	**120.8**	**2,019,685**

Тайлбар: 9,129-н 1,500 орчим нь аймгуудад баригдахаар төлөвлөсөн.

ХАВСРАЛТ Ё. Хотын Ерөнхий Төлөвлөгөө боловсруулах ажил үүргийн хуваарийн загвар

I. Үндэслэл

Төлөвлөлтийн хуучин бодлогод Засгийн газар нь хотын хөгжлийн асуудалд голлох үүрэг гүйцэтгэхээр хуульчилсан байдаг. Өнөөгийн нөхцөл байдлаас харахад стратеги төлөвлөлтийн тогтолцоонд хувийн салбар болон бусад талуудын оролцоог нэмэгдүүлэхэд ач холбогдол өгөх шаардлага зүй ёсоор урган гарч байна. Өөрөөр хэлбэл уг чиг хандлага тасралтгүй үргэлжлэх үйл явц бөгөөд Засгийн газар түүнийг хэрэгжүүлэх бодит механизмыг боловсруулах, дэд бүтцийн шугам сүлжээ болон үйлчилгээг сайжруулахад хязгаарлагдмал эх үүсвэрийг зөв хуваарилахад туслах зорилгоор зохицуулалт хийх бодлогын чанартай арга хэмжээ авах үүргийг гүйцэтгэнэ.

Ерөнхий төлөвлөгөө нь хотын ирээдүйн хөгжлийг өргөн хүрээнд төсөөлөх, хөгжлийн үйл ажиллагааг тусгасан төлөвлөлтийн арга хэрэгсэл юм. Өөрөөр хэлбэл ерөнхий төлөвлөгөө нь ирээдүйг зохион байгуулах үйл явц юм. Мөн газар ашиглалтын хэтийн төлөвлөгөөг боловсруулдаг. Ерөнхий төлөвлөгөөнд газрын ашиглалт, түүний байгалийн онгон төрх, түүх соёлын өвийг хамгаалан, бизнесийн болон эдийн засгийг хэрхэн, ямар үе шаттайгаар сайжруулах талаар тодорхой тусгадаг. Түүнчлэн нийтийн аж ахуйн үйлчилгээгээр хангах, орон сууцны нөхцлийг сайжруулах замаар иргэдийн амьжиргааг дээшлүүлэн, иргэдийн нийгмийн асуудлыг сайжруулахад хотын зүгээс хэрэгжүүлэх арга хэмжээ, стратегийг тодорхойлдог.

II. Зорилго

Ерөнхий төлөвлөгөө нь дараах хэлбэрээр үйлчилдэг:

- Хотын иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал хангасан, сэтгэл санааг дэмжин газар ашиглалтыг цаашид сайжруулах багц удирдамж;
- Хувь хүн, хэсэг бүлэг хүмүүсээс илүү хотын нийт иргэдийн ашиг сонирхлыг илэрхийлэх арга хэрэгсэл;
- Хотын хөгжлийн асуудалтай холбоотой шийдвэр гаргахад олон нийтийг бодлогыг чиглүүлэх;
- Газар ашиглалт, орон сууц, эдийн засгийн хөгжил, байгаль, соёл болон түүхийн үнэт зүйл, зам тээвэр, инженерийн шугам сүлжээ, нийгмийн үйлчилгээ, соёл амралтын хүрээлэн болон бусад ашиглагдаагүй газрын асуудлаар шийдвэр гаргахад хотын удирдлагуудад стратеги болох;
- Хотын өнгөрсөн болон ирээдүйн нөхцөл байдлыг талаарх тайлан/тайлбар болох;
- Хотыг эдийн засаг, нийгмийн асуудлыг хэрхэн ямар үе шаттайгаар хөгжүүлэх тухай танилцуулга; болон
- Хөгжлийн ирээдүйн загварын талаар иргэдийн төсөөлөл;

Ерөнхий төлөвлөгөөнд байгаль орчин хамгаалал, зам тээврийн үндсэн асуудал, шинэ орон сууцны болон гэр хорооллын нөхцөл сайжруулах газрын хэмжээ, байршлын стратеги төлөвлөлтийн хамрах хүрээг тогтоож өгнө. Хот байгуулалтын шийдвэр гарахад шаардлагатай цар хүрээг тогтоох нь төлөвлөгөөний зорилго оршино. Түүнчлэн төрийн болон хувийн салбарын түвшинд гаргасан хөрөнгө оруулалт хийх шийдвэрийн нийтэд мэдээлдэг байна.

III. Ерөнхий төлөвлөгөөний элемент

Ерөнхий төлөвлөгөө дараахь бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдэнэ.

- Төсөөллийн нэгдсэн тайлан, тайлбар цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилго, зорилт, онцлог, байршил
- Газар ашиглалтын төлөвлөгөө
- Орон сууцны хэтийн төлөвлөгөө: өнөөгийн болон цаашид хотод амьдрахаар тооцоолсон өрхийн орон сууцны эрэлт, шинээр бий болгох төрөл бүрийн орон сууцны тоо, орлогын бүх түвшингийн өрхүүдийн дундаж хэмжээг тусгасан төлөвлөгөө
- Зам, тээврийн төлөвлөгөө;
- Дэд бүтэц, инженерийн шугам сүлжээний төлөвлөгөө;
- Нийгмийн үйлчилгээний төлөвлөгөө.
- Байгаль, соёл болон түүхийн үнэт зүйлсийг хамгаалах хөтөлбөр;
- Байгаль орчин, эрчим, санхүү, эдийн засгийн хөгжил болон нийгмийн үр дагавар зэрэг төлөвлөгөөнд туссан тодорхой элементийн уялдаа холбоог хангахад чиглэсэн зүйл заалт
- Богино хугацааны стратегийн үйл ажиллагааны төлөвлөгөө

Дээрх бүрэлдэхүүн хэсгүүд нь хотын өнөөгийн нөхцөл байдлыг бодитой тодорхойлсон үнэлгээ, SWOT шинжилгээ болон иргэд, олон нийттэй хийсэн уулзалт, ярилцлагыг үндэслэн боловсруулагдана. Түүнчлэн төлөвлөгөөний бусад бүрэлдэхүүн хэсггэй нягт уялдаа холбоотой, болон иргэдийн төсөөллийн зорилт зорилготой бүрэн нийцсэн байна.

IV. Олон нийтийн оролцоо

Төлөвлөлтийн үйл явцад иргэд, олон нийтийн оролцоо чухал үүрэгтэй. Зөвлөхүүд үйл явцын туршид иргэд, олон нийт үйл ажиллагаанд хангалттай оролцуулахыг баталгаажуулна.

<u>Оролцогч талыг тодорхойлох.</u> Төлөвлөлтийн үйл явцад ямар талууд оролцогч байж вэ гэдгийг тогтоох нь эхний үйл ажиллагаа юм. Засгийн газар болон бусад холбогдох байгууллага, төрийн бус байгууллага, холбоод, нийтийн аж ахуйн байгууллага, аж ахуйн нэгж болон оршин суугчдын холбоодын төлөөлөгчид ерөнхий төлөвлөгөөтэй танилцдаг. Хотын ядуу хүмүүс, эмэгтэйчүүд, хотод шилжиж ирсэн иргэд, гудамжны хүүхдүүд, ажил олгогч байгууллага, худалдаа аж үйлдвэрийн танхимын эрх ашгийг ерөнхий төлөвлөгөөнд тусгаж өгнө. Түүнчлэн дотоодын болон олон улсын бизнесийн байгууллага, хөгжлийн агентлаг болон хөрөнгө оруулагчдын төлөөлөгчид адил ач холбогдолтой байна.

Энэхүү ажил үүргийн хуваарийн дагуу төлөвлөлтийн үйл ажиллагаанд оролцогч талуудыг сонгох арга хэлбэр болон олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглах стратегийг зөвлөхүүд тодорхойлдог.

Иргэд, олон нийтийн оролцоо болон үйл ажиллагаа дараахь хэлбэртэй байна.

1. Эхлэлийн олон нийтийн хурал : Энэ хурлаар иргэд, олон нийтэд Ерөнхий төлөвлөгөөний үйл ажиллагааны талаар танилцуулан, юуг, яаж хэрхэн хэрэгжүүлэх, хэн оролцох хэрэгжүүлэх болон хичнээн хэмжээний хөрөнгө мөнгө шаардлагатай болох, судалгааг хэзээ явуулах, хэрэгжүүлэх дуусах хугацаа зэргийг тусгасан тайлбарыг хийнэ.

2. Төсөөллийн семинар: Хотын ирээдүйн хөгжлийн дүр төрхийг төсөөлөхөд иргэд, олон нийтийг хамарсан үйл ажиллагаа юм. Ерөнхий төлөвлөгөөнд ерөнхий чиглэл өгдөг.

3. Стратеги төлөвлөлтийн семинар: Зөвлөхүүд хөгжлийн хэд хэдэн (2-3) хувилбарыг танилцуулан семинарт оролцогчдоор хэлэлцүүлэх бөгөөд оролцогчид дээрх хувилбаруудаас Ерөнхий төлөвлөгөөний бодлого болон хөрөнгө оруулалтын зөвлөмжийн үндэс болох хамгийн боломжтой хувилбарыг сонгодог.

4. Ерөнхий төлөвлөгөөний төслийг нийтээр хэлэлцүүлэх: Ерөнхий төлөвлөгөөг эцэслэн шийдвэрлэхээс өмнө зөвлөхүүд төлөвлөгөөний төслийг санал авахаар олон нийтэд нээлттэй хэлэлцүүлнэ.

5. Олон нийтийн санал авах төв: Зөвлөхүүд төлөвлөлтийн туршид иргэд, орон нутгийн захиргаадаас саналыг авах нээлттэй хаалганы бодлогыг баримтлана. Иргэдээс баримт бичиг, зураг, төсөв, судалгаа болон дүн шинжилгээнд санал авах зорилгоор Олон нийтийн санал авах төвийг байгуулна. Төлөвлөгөөг боловсруулан батлуулахаас өмнө санал авах төвөөс дамжуулан олон нийтээс санал авна.

V. Ажлын цар хүрээ

Энэхүү хэсэгт Ерөнхий төлөвлөгөө боловсруулахад зөвлөхүүдийн хийж гүйцэтгэх ажил үүргийг тусгав.

А. Мэдээлэл цуглуулан түүнд дүн шинжилгээ хийх (1-2 сар)

Бодит, нийгэм эдийн засаг болон санхүүгийн орчны талаар статистикийн мэдээллийн баазыг бүрдүүлэн мэдээллийг холбогдох хууль тогтоомж болон захиргааны асуудлын дагуу нэгтгэх болон газрын гадаргуун зургийг авна. Судалгаа боловсруулахад түүхийн баримт бичиг, хотын захиргааны мэдээ, хөрсний болон геологийн судалгаа тайлангууд зэрэг олон төрлийн мэдээллийн эх үүсвэрийг ашиглан цуглуулдаг. Ерөнхий төлөвлөгөө боловсруулах зорилгоор төсөөлөл, таамаглалыг дараах салбар тус бүрийн өнөөгийн бодит байдал, түүний чиг хандлагыг судлан шинжилгээ хийдэг. Судалгааг дараах агуулгын дагуу хийнэ. Үүнд:

a. Хүн ам зүйн— Хотод амьдарч байсан болон одоо байгаа хүн амын тоо, хэмжээ, нягтрал, тархалт, нас хүйс, үндэстэн ястан болон иргэдийн шилжилт хөдөлгөөн зэрэг мэдээллийг багтаана. Түүнчлэн хүн амын өсөлтийн хэтийн төлөвийг тооцдог.
b. Эдийн засгийн нөхцөл байдал—Орон нутгийн болон бүс нутгийн эдийн засгийг бүрдүүлж буй үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх .
    1. Иргэдийн орлогын шинжилгээ—Орлогыг эх үүсвэр, хуваарилалтаар нь судлах

2. Ажиллах хүч.— Ажиллах хүчний болон зах зээлийн хэмжээ, онцлогийг судлах.
3. Аж үйлдвэр, бизнес болон худалдааны салбарын үйлдвэрлэлийн бүртгэл — Бүртгэлд тухайн үйлдвэрлэлийн хэмжээ, тоног төхөөрөмж, болон хөрөнгө эрэлт, цалингийн хэмжээг тусгана.
4. ХАА үйлдвэрлэл — ХАА-н үйл ажиллагааг судлах.
5. Уул, уурхайн, боловсруулах үйлдвэрлэлийн үйл ажиллагаа.
6. Ашиглагдаагүй аж үйлдвэрийн болон бизнесийн зориулалттай газар— дээрх газруудыг тогтоон тэдгээрийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд шаардлагатай зөвлөмжийг боловсруулах.

c. Орон сууц—Орон сууцны эрэлт, хандлага болон нөөцийг тогтоох.
1. Орон сууцны үзүүлэлт—Орон сууцыг ашиглалтын хугацаагаар шинжилгээ хийх, барилгын төрлийг тогтоох:
2. Орон сууцны төрөл—Амьдрах зориулалтаар ашиглаж буй орон сууцны тоог гаргах: гэр, орон сууц, амины сууц, болон жижиг сууц гэх мэт.
3. Орон сууцны чанар, өртөг болон эрэлтийг тооцох—Орон сууцны үнэ, өртгийг тооцох судалгаа хийх

d. Газар ашиглалт—Газар ашиглалтын өнөөгийн байдлыг тодорхойлон цаашид хэрэгжүүлэх загварыг төлөвлөх.

e. Инженерийн шугам, сүлжээ дэд бүтэц— цэвэр, бохир усан хангамж, дулаан болон цахилгаан зэрэг инженерийн шугам сүлжээний цаашдын эрэлтийг шинжлэн, төлөвлөх

f. Байгаль орчин ба байгалийн баялаг
1. Газрын тогтолцоо—Хотын болон бүс нутгийн газрын тогтолцооны онцлог;
2. Байгалийн баялаг— Хөрс, ус болон эрдэс бодис, хий, түлш ой, загас зэрэг байгалийн баялгийн бүртгэл
3. Усны нөөц—Усны нөөцийн, усан хангамж, намаг болон голын ойролцоо үерт өртөмтгий газрын бүртгэл
4. Байгалийн тогтолцооны онцлог - экологийн онцлог зүйлүүдийн бүртгэл
5. Ногоон байгууламж—Олон нийтийн болон хувийн эзэмшлийн задгай талбай, соёл амралтын хүрээлэн, гэм мэт
6. Байгалийн аюултай бүс— байгалийн үзэгдэл болон хүний хүчин зүйлийн дүнд бий болсон аюултай бүс газруудын (үерт өртөмтгий газар, эгц налуу, химийн гэх мэт) жагсаалт,
7. Соёлын өв — түүхт газар нутаг болон театр, музей гэх мэт соёлын бусад эд зүйлийн бүртгэл

g. Нийгмийн үйлчилгээ—эрүүл мэнд, боловсрол болон бусад нийгмийн үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдал болон цаашид хөгжүүлэхэд шаардлагатай асуудлыг тодорхойлох.

h. Хуулийн болон засаг захиргааны бүтэц зохион байгуулалт
1. Засаг Захиргааны байгууллага —Хотын удирдлага, захиргааны байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг тайлбарлах.
2. Төлөвлөгөөнүүдийн уялдаа холбоо — бүс нутгийн болон үндэсний хэмжээний хөгжлийн бусад төлөвлөгөөнүүдийн хоорондын уялдаа холбоог судлан, үнэлэлт дүгнэлт өгөх

i. Тээвэр —Тээврийн хэрэгсэл, түүний тогтолцоог судлах
1. Зам, гудамжны ангилал
2. Замын тэмдэглэгээ, хэмжээ,хүчин чадалд дүн шинжилгээ хийх

Б. SWOT шинжилгээ ба асуудлыг тодорхойлох (2 сар)

Өнөөгийн нөхцөл байдал болон иргэд, олон нийтийн дунд хийсэн уулзалт хэлэлцүүлгийг үндэслэн Ерөнхий төлөвлөгөөнд тусгах гол асуудлуудыг тодорхойлох зорилгоор SWOT буюу давуу сул тал болон боломж, аюул заналын дүн шинжилгээг хийдэг.

SWOT дүн шинжилгээ нь хотын хөгжилд тулгарч буй давуу болон сул тал, түүнээс гарах боломж, аюул заналд дүн шинжилгээг хийх өөрөөр хэлбэл хотын хөгжилд нөлөөлж буй гадаад болон дотоод хүчин зүйлийн шинжилгээ юм. Бусад хотуудаас тухайн хотын ялгарах онцлогийг тодорхойлох үйл явц юм. SWOT шинжилгээг хийснээр хотын давуу тал, бусдаас ялгарах боломжид тулгуурлан хотын стратегийг боловсруулахад дөхөмтэй байдаг.

Давуу тал: Хотын бусдаас ялгарах давуу талууд буюу дотоод хүчин зүйл юм. Давуу талыг тодорхойлоход дараах асуултыг тавьдаг:
- Хотод ямар давуу талууд байна вэ ?
- Хот/иргэд юуг илүү сайн хийж байна, ямар бизнес ашигтай байна вэ?
- Өөр ямар эх үүсвэрүүдийг ашиглах боломжтой вэ?

Сул тал: Хотын сөрөг сул талууд буюу дотоод хүчин зүйл юм. Давуу талыг тодорхойлоход дараах асуултыг тавьдаг:
- Юуг сайжруулах боломжтой вэ?
- Хотын юу болохгүй байна вэ?

Боломж: Хотыг цаашид хөгжүүлэх боломж буюу гадаад хүчин зүйл юм. Боломжийг тодорхойлоход дараах асуултыг тавьдаг:
- Танай хотод ямар ямар болж байна вэ?
- Ямар хандлагууд байж болох вэ?

Боломжууд дараах хүчин зүйлээс хамааралтай байдаг. Тухайлбал:
- Технологи болон зах зээлийн өөрчлөлт
- Засгийн газрын бодлогын өөрчлөлт
- Нийгмийн хэв маяг, хүн амын гэх мэт өөрчлөлт

Аюул занал: Хотын ирээдүйн хөгжилд сөргөөр нөлөөлөх гадаад хүчин зүйлүүд юм. Өөрөөр хэлбэл эдгээр аюул заналууд нь хотын хяналтаас гадуур тулгарах байгалийн гамшиг, эдийн засгийн хямрал зэрэг гадаад хүчин зүйлүүд байна.

Б. Олон нийтийн төсөөлөл буюу зорилго тодорхойлох (3 сар)

Хотын хэтийн хөгжлийн талаарх олон нийтийн төсөөллийг нэгтгэх зорилгоор төсөөллийн семинарыг зохион байгуулна. Төсөөлөл нь иргэд оршин суугчид өөрсдийн амьдрах орчныг ирээдүйд хэрхэн хөгжүүлж болох талаар тэднийг төсөөлөхөд туслах үйл ажиллагаа юм. Иргэд оршин суугчдын төсөөлөл нь байгаль орчин, нийгэм эдийн засаг, газар ашиглалт болон иргэдийн эрэлтийн талаар оршин суугчдын санал бодлыг тусгасан байна.

Төсөөлөх үйл явц нь :

- эрэлтээс илүү иргэдэд өөрсдөд нь байгаа боломжид ач холбогдол өгөх;
- Иргэд, оршин суугчдад байгаа боломжийг судлах,
- Олон нийтийн оролцоог тасралтгүй байх зарчмыг баримтлах

Төсөөллийн тайлбар/тайланд тавигдах шаардлагууд:

- Одоо цаг дээр бичих;
- Хотын онцлог шинж;
- Хүн амын өсөлтийг тооцсон
- Амжилтанд хүрэх хэм хэмжээний тайлбар
- Хүмүүсийн амьжиргааны асуудлыг хөндсөн
- Нийтэд хялбар ойлгогдох хэлийг ашиглах.

Төсөөллийн семинарт иргэд, олон нийтийг өргөнөөр татан оролцуулах шаардлагатай. Семинарт оролцох хүмүүсийн тоог хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлах болон урилга хүргүүлэн тогтоодог.

Семинарт өнөөгийн нөхцөл байдалд хийсэн дүн шинжилгээг товч танилцуулсны дараа SWOT шинжилгээг оролцогчдоор хийлгэнэ. Оюуны дайралтын дасгал хийсний дараа оролцогчдыг 7-10 хүний бүрэлдэхүүнтэй хэд хэдэн ажлын жижиг хэсгүүдэд хуваана. Ажлын хэсгүүдэд бусад хотуудаас авч болох туршлага жишээ тайлбарлан төсөөлөл гэж юу вэ гэдэгт зааварчлга өгнө. Өгсөн зааварчлагын дагуу ажлын хэсгийн гишүүд төсөөллийн талаар өөр өөрсдийн санаа бодлыг гаргаж ирэх бөгөөд саналаа нэгтгэн боловсруулан бусад бүлгүүдэд танилцуулах үйл ажиллагааг явуулна. Жижиг ажлын хэсгүүдийн төсөөллийн нэгтгэн төсөөллийн тайлбар буюу тайлан болгон холбогдох байгууллагуудад баталгаажуулахаар танилцуулна. Төсөөллийн тайлан/тайлбартай холбоотой зорилго, зорилтыг тодорхойлоход холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. Тодорхойлсон зорилго, зорилтууд нь тодорхой, оновчтой товч байна.

г. Хувилбарууд ба газар ашиглалтын төлөвлөгөө боловсруулах (3-4 сар)

Дүн шинжилгээг үндэслэн хотын хэтийн хөгжлийн талаарх гурван хувилбарыг боловсруулна. Эхний хувилбарт хотын хэтийн хөгжлийн асуудлаар ямар нэгэн арга хэмжээ, үйл ажиллагааг хэрэгжүүлэхгүй бол ямар үр дагавар, үр дүн гарах вэ гэдгийг тусгах бол бусад хоёр хувилбарт бүс нутгийн болон үндэсний эдийн засагт хотын эзлэх байр суурь ямар байж болох вэ гэдэг асуудлыг тусгаж өгнө.

Хувилбар тус бүрт газар ашиглалтын хэтийн төлөвлөгөө боловсруулна. Газар ашиглалтын хэтийн төлөвлөгөөг одоо ашиглаагүй хоосон газарт шинээр барих зам, талбайн байршлын зааж өгнө.

д. Стратеги төлөвлөлтийн семинар зохион байгуулах (4 сар)

Хэтийн хөгжлийн талаар боловсруулсан хувилбаруудыг холбогдох байгууллагуудын оролцогчдод танилцуулан хэлэлцэн боломжит хувилбарыг сонгох зорилгоор стратеги төлөвлөлтийн семинарыг зохион байгуулна.

ХАВСРАЛТ Ж. Олон нийтийн оролцоотой үйл ажиллагааны төлөвлөлтийн чиг хандлага

Санал болгож буй олон нийтийн оролцоотой үйл ажиллагааны төлөвлөлтийн загвар нь иргэд, оршин суугчид, хотын удирдлага болон мэргэжлийн төлөвлөгч нарын хооронд Монгол улсад өмнө нь байгаагүй харилцааг бий болгоход чиглэгдэнэ. Төлөвлөлтийн бүх шатанд, тухайлбал үйл ажиллагааны төлөвлөгөөг санаачлах, хэрэгжүүлэх болон хяналт тавих зэрэг үйл явцад дээрх иргэд, байгууллагын үүрэг оролцоо ижил тэнцүү байх шаардлагатай. Энэхүү шинэ чиг хандлага нь гэр хорооллын нөхцлийг сайжруулахад иргэдийн оролцоо, шаардлагатай эх үүсвэрийг ашиглах улмаар амьдрах орчноо сайжруулахад бусад гэр хорооллын иргэдийн үйл ажиллагааг дэмжихэд чиглэгдэнэ. Ялангуяа, өөрсдийн хэрэгцээнд тулгуурласан өртгөө нөхөх боломж бүхий амьдрах орчныг сайжруулах багц төсөл боловсруулах сонирхол бүхий иргэд, оршин суугчдад дэмжлэг үзүүлэх юм. Амьдрах орчныг сайжруулах олон нийтийн оролцоотой төлөвлөлтийн чиг хандлагыг бий болгон удирдан зохион байгуулахад мэргэжлийн болон орон нутгийн захиргаад, байгууллагууд гэр хорооллын иргэдтэй нягт хамтран ажиллах болно. Эхний загвар төслийг амжилттай хэрэгжүүлснээр иргэд, аймаг, хот болон байгууллагуудын түвшинд тодорхой туршлага хуримтлуулан улмаар өөр бусад хот сууринд цаашид хэрэгжүүлэх боломжтой болох юм. Иргэдийн эрэлтэд тулгуурлан хэрэгжүүлэх гэр хорооллын нөхцлийг сайжруулах энэхүү санал болгож буй үйл ажиллагаа нь өргөн утгаараа барилгын салбарын зорилтыг хангах, улмаар хот байгуулалт, орон сууц нийтийн аж ахуйн үйлчилгээг удирдан зохицуулах бодлогын түвшний төлөвлөлтийг үр дүнтэй, зардал хэмнэхэд ач холбогдолтой юм.

А. Чиг хандлагын үндсэн шинж чанар

Олон нийтийн оролцоотой үйл ажиллагааны төлөвлөлтийн (ОНОҮАТ) төрлүүд нь өөрсдийн шинж чанраараа өөр хоорондоо ялгаатай байдаг. ОНОҮАТ-ийн үйл явц нь дараахь шинжийг агуулдаг.

- Тулгарч буй асуудлыг хөндсөн: Иргэд, оршин суугчид болон оролцогч талууд тулгарч буй асуудлыг нэн тэргүүнд тодорхойлон улмаар бэрхшээлтэй асуудлаа шийдвэрлэхэд байгууллага, иргэдэд бодитой , санхүү, хүний нөөцийн ямар эх үүсвэр боломж байна вэ гэдгийг тогтоодог;

- Шийдлүүд нь хэрэгжүүлэх боломжтой байх: Оршин суугчдын тогтоосон ач холбогдлыг үндэслэн тухайн асуудлыг шийдвэрлэж хэрэгжүүлэх цаг хугацааг нь тогтоож өгнө. ОНОҮАТ үйл явц нь эцсийн шатанд үүсэх нөхцөл байдлаас илүү үйл ажиллагааг эхлүүлэх цаг хугацаанд илүү ач холбогдол өгдөг;

- Байгууллага, иргэдийн оролцоо хамтын ажиллагааг дэмжих: ОНОҮАТ нь эвсэл холбоо байгуулах, орон нутгийн захиргаад болон төрийн бус байгууллагын хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, захиргааны байгууллагын газар хэлтсүүд, мэргэжлийн байгууллага болон иргэд оршин суугчдын хоорондын хамтын ажиллагааг ихээхэн дэмждэг юм. Үр ашигтай төлөвлөлт болон хөтөлбөр хэрэгжүүлэх ажиллагаа нь дээрх иргэд байгууллагын нэгдсэн хүсэл сонирхол бүхий хамтын ажиллагаанд тулгуурладаг бөгөөд амжилтанд хүрэхийн тулд хичээл зүтгэлийг шаарддаг байна.

- Мэдээлэл шаардагдахгүй: ОНОҮАТ-ийн үйл явц нь иргэд оршин суугчдын мэдлэг, ур чадвар дээр тулгуурлан хэрэгждэг. Түүнчлэн хэрэгжүүлэх эхний үе шатанд багц мэдээлэл шаардагдахгүй бөгөөд “хийх явцдаа суралцах” зарчимд үндэслэгддэг.

- Иргэдийн үйл ажиллагаанд тулгуурласан жижиг хэмжээний үе шаттай амьдрах орчинг сайжруулахад чиглэсэн байдаг.

- Богино хугацаанд бодитой үр дүнд хүрдэг.

Олон нийтийн оролцооны үйл ажиллагааны төлөвлөлтийн чиг хандлага нь газрын зураг, агаарын гэрэл зураг, судалгаа, мэдээллийн хоёрдогч эх үүсвэрүүд болон бусад тооллого, кадастрын мэдээлэл зэрэг бэлэн байгаа мэдээлэл дээр тулгуурлахын зэрэгцээ иргэд, оршин суугчдын ахлагчид, аж ахуйн нэгж байгууллага болон төрийн байгууллагын удирдлагуудтай уулзан ярилцан хотын хөгжлийн тогтолцоо, цаашдын хөгжилд нөлөөлж буй нөлөөллийн үндсийг судлан, тэдгээрийн санал бодлыг сонсоход гол анхаарал хандуулдаг.

Б. ОНОҮАТ-ийн чиг хандлагыг хэрэгжүүлэх үе шат

Гэр хорооллын нөхцлийг иргэдийн оролцоотой сайжруулах үйл ажиллагааны төлөвлөлт нь дараахь хэд хэдэн үе шаттай. Үүнд:

Тулгарч буй асуудлыг шинжлэн, түүнээс гарах боломжит шийдлийг тодорхойлох нь ОНОҮАТ-ийн үйл явцын эхний үе шат юм. Иргэдийн дунд нийтлэг тулгардаг боловч ойрын хугацаанд шийдвэрлэх боломжтой асуудлуудыг тодорхойлно. Энэ үе шатанд тухайн нөхцөл байдлын талаарх дүр зургийг бодитой тодорхойлох, түүнчлэн асуудлыг шийдвэрлэх боломжит шийдлийг үнэн зөв тогтоох шаардлагатай юм. Мөн тулгарч буй бэрхшээлтэй гол асуудлын өнөөгийн нөхцөл байдлыг судлах, өөр хоорондоо зөрчилдөж буй асуудлуудыг тодруулах, эцсийн бүлэгтээ ижил боловч өөр байдлаар илэрхийлсэн бэрхшээлтэй асуудлыг нэгтгэх зэрэг үйл ажиллагааг энэ шатанд хэрэгжүүлдэг. Холбогдох шийдлийг тогтоохыг тулд тулгарч буй асуудлууд, түүнээс гарах боломжийг бодитой тогтоох нь чухал юм.

Бэрхшээлтэй асуудал, боломжийг тодорхойлон тэдгээрийн үр дагавар, учир шалтгааныг үндэслэн зорилгоо тодорхойлно. Энэ нь хоёрдахь үе шат юм. Зорилгоо тодорхойлсны дараа тэдгээрийг иргэдийн эрэлт хэрэгцээ болон ач холбогдлоор нь эрэмбэлэнэ. Зорилгуудын ач холбогдол, боломжит байдлыг үндэслэн өөр стратеги боловсруулж болох бөгөөд гагцхүү стратеги нь үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад тулгарч болзошгүй эрсдэл, хөрөнгө оруулалт тооцсон байна.

Олон нийтийн оролцоотой үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх гурав дахь үе шат нь шийдлүүдэд дүн шинжилгээ хийн, боломжит хувилбарыг сонгох үйл явц юм. Янз бүрийн эх сурвалж бүхий асуудлууд, бэрхшээлийг нарийвчлан хянах, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог судлах замаар дүн шинжилгээг хийдэг.

Тулгарч буй асуудлуудын хоорондын уялдаа холбоонд дүн шинжилгээг дараах хоёр үйл явцын хүрээнд хийнэ. Эхний үйл ажиллагаа нь төслийн үйл ажиллагааны бүрэлдэхүүн болон үе шатыг ач холбогдлоор нь эрэмбэлдэг бөгөөд хоёр дахь үйл ажиллагааг хэрэгжүүлснээр гарах үр дагавар, зөрчилдөөнийг хэрхэн шийдвэрлэхэд үйлчилдэг байна.

Төслийг хэрэгжүүлэх багийг бүрдүүлэн, хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх. Энэ үе шатанд төрийн бус байгууллага, орон нутгийн захиргаа болон гэр хорооллын иргэд оршин суугчдын хамтын ажиллагаа чухал үүрэгтэй юм.

Эцсийн үе шат буюу үйл ажиллагааг хэрэгжүүлэн, түүнд хяналт тавих. ОНОУАТ–ийн үйл ажиллагааны хэрэгжилтийг нийгэм-эдийн засаг, техникийн болон байгаль орчны тодорхой шалгуур үзүүлэлтүүдийн тусламжтайгаар хянах боломжтой. Техникийн үзүүлэлтүүдийг тоо болон чанарын үзүүлэлтээр нь үнэлэн хянах боломжтой (ундны усны хэмжээ, чанар гэх мэт). Төсөл, хөтөлбөрийн өртгийг хэмнэх болон ажлын байр бий болгосноос гарах ашгийн түвшинг тооцоход эдийн засгийн үзүүлэлтийг ашиглана. Үйл ажиллагааны болон байгууллагын үзүүлэлтийг төслийн хэрэгжилт, зохион байгуулалт болон ашиглалтыг тооцоход ашиглана. Харин гэр хорооллын нөхцөл сайжруулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд иргэд оршин суугчдад тулгарч буй бэрхшээлийг тодорхойлоход нийгмийн үзүүлэлтүүдийг ашиглана. Байгаль орчны үзүүлэлтүүд нь төлөвлөгөөг хэрэгжүүлснээр орчин тойрны нутаг дэвсгэрт хэрхэн нөлөөлөхийг тодорхойлно.

B. ОНОУАТ-ийн чиг хандлагыг хэрэгжүүлэхэд ашиглах арга хэрэгсэл

Үйл ажиллагааны төлөвлөлтийн чиг хандлага нь хэрэгжүүлэх нь ашиглах аргуудаас нэлээд хамааралтай байдаг. Төлөвлөлтийн баг дараахь аргыг дараалын дагуу хийж гүйцэтгэнэ.

- Шууд ажиглалтын арга: Төлөвлөлтийн баг хот байгуулалтын нөхцөл байдлыг өөрсдийн түвшинд судлах, газрын зураг, төлөвлөгөөнд тусгасан мэдээллийг хянах, хот болон хотын ойролцоох газрыг хэрхэн хөгжүүлж болох асуудлаар урьдчилсан санал боловсруулдаг. Төлөвлөлтийн багууд хамтран тухайн гэр хорооллын болон орон сууцны асуудлын судалгаа хийж болно.

- Албан бус ярилцлагын арга: Шууд ажиглалтын аргатай хослуулан тухайн газарт амьдардаг иргэд, оршин суугчид, эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настангууд болон мэдээлэгчдэд тулгарч буй асуудлыг сонсох замаар тэднээс албан бус хэлбэрээр ярилцлага авдаг. Шууд ажиглалтын арга нь суурьшлын бүтцийн тухай мэдээллийн тодорхойлдог бол албан бус ярилцлагын арга нь иргэд оршин суугчдын нийгэм, эдийн засгийн бүтцийн талаарх нуугдмал мэдээллийг гаргаж ирдэг. Албан ёсны ярицлагын аргыг асуулга явуулах хэлбэрээр явуулдаг бол албан бус ярилцлагыг чөлөөтэй асуулт тавих замаар хийдэг.

- Нөхцөл байдлын судалгаа, хэмжилт хийх арга: Тухайн нөхцөл байдлыг чанараас илүү тоон үзүүлэлтийг үндэслэдэг. Тухайлбал тухайн нутаг дэвсгэрийн зам, хашааг хэмжих, ус түгээх байрыг тоолох, хашаа болон байшинг хэмжих гэх мэт

- Эх үүсвэрийн судалгаа авах арга: Энэ аргыг гол төлөв иргэд оршин суугчид өөрсдөө хийдэг. Өөрөөр хэлбэл, гэр хорооллын нөхцөл байдлыг сайжруулахад ашиглах боломжтой тээврийн хэрэгсэл, иргэдийн ур чадвар, ажиллах хүчний боломж, санхүүгийн болон байгалийн эх үүсвэрийг газрын зураг болон схемийг ашиглан тооцно.

- Зорилго, үйл ажиллагааг ач холбогдлоор нь эрэмбэлэх арга: Оролцогч талууд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, зорилгоо ач холбогдлоор нь эрэмбэлдэг. Ач холбогдлоор нь эрэмбэлэх үйл явц нь тулгарч буй бэрхшээлтэй асуудлыг тодорхойлон хэрэгжүүлэх, боломжит төслийн боловсруулах хүртэл тасралтгүй

үргэлжилдэг. Боловсруулсан төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэхээс өмнө иргэд оршин суугчдад эрэмбэлсэн үйл ажиллагаанд өөрчлөлт оруулдаг.

- Оюуны дайралт хийх арга: Энэ аргыг холимог бүлгүүдээс бүрдсэн хэсэг бүлэг хүмүүсийн дунд загвар, зураг ашиглах замаар нээлттэй хэлэлцүүлэг хийхэд ашиглана. Энэ арга нь тулгарч буй асуудлыг шийдвэрлэх хамгийн оновчтой арга зам болох нь нотлогдсон юм.

- Бүдүүвчлэх. Цаг хугацаа, хүснэгт, диаграмм болон бусад төрлийн графикийг ашиглан хэрэгжүүлэх үйл ажиллагааг бүдүүвчлэн хамгийн энгийн байдлаар харуулдаг. Энэ бүдүүвчийг иргэд оршин суугчид тогтмол гаргадаг.

- Зураглал, загвар хийх: мэдээллийг баримтжуулах, бага орлоготой иргэд амьдардаг гэр хорооллын бодит амьдралыг харуулах ашигтай бөгөөд хамгийн оновчтой арга юм. Амьдрах орчныг сайжруулах талаар иргэд нэг бүрийн санал бодол, төсөөлөл, хүсэл сонирхол, зөвлөмжийг тусгах зорилгоор зураглалыг гараар хийж болно. Зураглал, загварыг иргэд оршин суугчид болон үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын тусламжтайгаар хийлгэх нь тэдний хоорондын зөрчилдөөнийг багасгах, мэргэжлийн болон мэргэжлийн бус байгууллагын хоорондын хамтын ажиллагааг бодит утгаар нь хөгжүүлэх ач холбогдолтой юм.

- Тоглоом, дүрийн тоглолтын арга: үйл ажиллагааны төлөвлөлтийн талаар иргэдийн ойлголтыг нэмэгдүүлэх, төлөвлөгчдөд асуудлыг ойлгуулах зорилгоор энэ аргыг ашигладаг. Дүрийн тоглолтын арга нь албан ёсны төлөвлөлтийн үе шатанд санал бодлоо илэрхийлэх боломжгүй байсан иргэд оршин суугчдын бүлгийн хүсэл сонирхол, бодлыг тодорхойлоход мөн ашигладаг байна. Энэ арга нь өөрсдийн гаргасан санал бодлыг бусад бүлгийн оролцогчдод ойлгуулахад нэлээд ач холбогдолтой.

- Бүлэг, хэсгээр ажиллах арга: мэдээлэл цуглуулах, төсөл хэрэгжүүлэх загвар зураглал боловсруулахад хэсэг, бүлгээр ажиллах арга юм.

Дээрх аргуудыг хамгийн энгийн бөгөөд ашигтай байдлаар хэрэглэснээр үр дүнд хүрнэ.

Г. Олон нийтийн оролцоотой үйл ажиллагааны төлөвлөлтөд иргэдийн оролцооны түвшин

Төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, ашиглах үе шатанд иргэдийн оролцоог дараахь таван түвшинд ангилдаг. Тухайлбал: Иргэдийн оролцоогүй, Шууд бус оролцоо, Зөвлөлгөө өгөх, Хамтарсан тэгш эрхтэй оролцоо болон Иргэдийн давуу эрхтэй оролцоо гэж ангилдаг.

- Иргэдийн оролцоогүй. Орчныг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөлтийг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд иргэд оролцохгүй бөгөөд зөвхөн төлөвлөгчид голлох үүрэгтэй оролцдог. Гэвч иргэдийн оролцоогүй энэ төлөвлөгөө нь тэдний бодит эрэлт хэрэгцээг хангаж чадахгүй байх эрсдэл өндөр байдаг.

- Шууд бус оролцоо: Энэ түвшинд иргэд оршин суугчид мөн идэвхтэй оролцдоггүй боловч тэдний талаар мэдээлэл нь тодорхой байх шаардлагатай байдаг. Дээрх мэдээллийг иргэд оршин суугчдаас шууд авдаг бус харин хоёрдогч эх үүсвэр, тайлан болон тооллогоос зэргээс авдаг байна. Үйл ажиллагааны төлөвлөгөөг амжилттай хэрэгжүүлэхэд дараахь хоёр хүчин зүйл ихээхэн үүрэг гүйцэтгэдэг. Үүнд аливаа мэдээлэл нь үнэн бодит, хангалттай

байх, мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээг чанарын өндөр түвшинд хийх зэрэг болно.

- Зөвлөлгөө өгөхөд оролцох: Энэ шатанд төлөвлөлтийн баг иргэд, оршин суугчдаас мэдээллийг цуглуулан авч, түүнд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг сонгодог. Иргэд энэ үйл явцад оролцогчийн зүгээс бус сонирхогч бүлгийн зүгээс ханддаг. Хэрэгжүүлж буй төсөл үйл ажиллагааны үр дүн нь иргэдээс авсан мэдээ, баримтаас хамааралтай юм. Төлөвлөлтийн баг өөрсдийн санал бодлыг оролцогчид танилцуулан тэдний саналыг авдаг. Гэвч иргэд зөвлөлгөө өгч оролцох энэхүү хэлбэр нь төслүүдийн талаар ерөнхий санаа бодлыг тусгахаас оршин суугчдын бодит хэрэгцээг тэр болгон тусгаж чаддаггүй байна.

- Хамтарсан тэгш эрхтэй оролцоо: Иргэд оршин суугчид болон төлөвлөлтийн багууд үйл ажиллагаанд тэнцүү тэгш эрхтэй оролцдог. Тэгш эрхтэй оролцоо болон шийдвэр гаргах энэхүү хэлбэр нь стратеги дээд шатны болон орон нутгийн үйл ажиллагааны төлөвлөлтийн доод шатны түвшинд асуудлыг тэнцүү эрхтэй тавьж шийдвэрлүүлдэг онцлогтой. Үйл ажиллагааг үр дүнтэй болгохын тулд оролцогчдын зүгээс харьцангуй жижиг бүлгүүд байх шаардлагатай байдаг. Хариуцлагыг энэ байдлаар тэнцүү хэмжээтэй хүлээх нь давуу болон сул талтай байдаг. Түүнчлэн нэлээд их эрсдлийг агуулдаг. Иргэд болон хотын захиргаанд хамтран хэрэгжүүлсэн үйл ажиллагаанд өөриймсөг ханддагүй. Тийм учраас дээрх эрсдлийг багасгахын тулд тодорхой арга барилыг ашиглан иргэд, хотын захиргаадад төслийн өмчлөл, эзэмшлийн мөн чанарыг ойлгуулах нь чухал юм.

- Иргэдийн бүрэн оролцоо. Амьдрах орчноо сайжруулах үйл ажиллагааны төлөвлөлтөд иргэд голлох үүрэг гүйцэтгэн оролцох бөгөөд төлөвлөлтийн багийг шаардлагатай үед нь техникийн туслалцаа авахад оролцуулдаг. Оршин суугчдын дунд гол үүрэг гүйцэтгэдэг цөөн хэдэн хүмүүс байна.

Д. Төслийг хэрэгжүүлэх үе шат болон иргэдийн оролцооны уялдаа холбоо

Иргэд, оршин суугчид төслийг төлөвлөх, боловсруулах дараахь үндсэн таван үе шатанд оролцдог байна. Үүнд: хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа санаачлах, төлөвлөх, төсөл боловсруулах, хэрэгжүүлэх болон түүнийг ашиглах гэх мэт.

- Иргэд оршин суугчид тулгарч буй бэрхшээл, дэд бүтцийн хомс үйлчилгээ зэрэг асуудлыг тодорхойлох, амьдрах орчноо сайжруулах төлөвлөгөөг боловсруулах ажлыг санаачилна. Энэ үе шатанд иргэд, оршин суугчид хүрэх зорилго, зорилт болон хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээг тодорхойлдог. Түүнчлэн энэ үе шатанд иргэд зөвлөгөө өгөх, тэгш эрхтэй буюу бүрэн эрхтэй оролцож болно. Аливаа үйл ажиллагааг санаачлах үйл явцад иргэд, оршин суугчдын оролцоо гол үүрэгтэй юм;

- Төлөвлөлтийн үе шат нь хэрэгжүүлэх үйл ажиллагаа,төсөв, шаардлагатай эх үүсвэрийг эцэслэн тодорхойлдог. Энэ үе шатанд иргэд болон хотын захиргааны хамтарсан оролцоо чухал үүрэгтэй.

- Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, төсөл боловсруулах үе шат: Иргэдийн оролцоо нь энэ үе шатанд бусад үе шаттай харьцуулахад чухал биш байдаг. Иргэд төсөл боловсруулах шинэлэг шийдлийг тэр болгон санал болгож чаддаггүй, иймд тэдэнтэй хамтран ажиллах хамгийн үр дүнтэй арга хэлбэрийг бий болгох шаардлагатай.

- Амьдрах орчноо сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхдээ жижиг аж ахуйн нэгж, оршин суугчдын холбоодод орлого нэмэгдүүлэх болон иргэдийн ур чадварыг нэмэгдүүлэхэд сургалт явуулах зэрэг хөтөлбөрийг хамт хэрэгжүүлэх боломжтой.

- Үйл ажиллагааны төлөвлөгөө болон төслийн үр дүнд сайжруулсан орчин тойрны дэд бүтцийн үйлчилгээ цаашид ашиглахад иргэд болон хотын захиргааны зүгээс оролцдог хэдий ч оршин суугчид ерөнхийд нь ашиглалтыг хариуцдаг.

Үйл ажиллагааны төлөвлөгөө, төслийг боловсруулан хэрэгжүүлэх үйл явцад иргэдийн оролцооноос гадна, төлөвлөх үе шатанд иргэд, оролцогч талуудын идэвхитэй оролцоо нь төслийг амжилттай хэрэгжүүлэх үндэс болдог. Төлөвлөлтийг иргэд, бусад талуудын оролцоогүй хийснээр эцсийн бүлэгтээ иргэд бага хэмжээний ашиг хүртдэг ч хөрөнгө мөнгө болон хүч хөдөлмөрийг дэмий урсгах талтай байдаг.

E. ОНОУАТ-ийн сургалт явуулах

Иргэдийн дунд хоёроос таван өдрийн эрчимтэй сургалт явуулах нь олон нийтийн оролцоотой үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахад чухал үүрэг гүйцэтгэнэ. Сургалт явуулснаар иргэд өөрсддөө тулгарч буй бэрхшээлтэй асуудлаа тодорхойлох, түүнээс гарах арга зам, стратегийг боловсруулах болон хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ, цаг хугацааг тогтоосон ажлын төлөвлөгөө зэрэг амьдрах орчноо сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах чадварыг эзэмших юм. Төслийг амжилттай хэрэгжүүлэхэд мэргэжлийн байгууллагуудын хамтарсан оролцоо чухал үүрэг гүйцэтгэнэ. Сургалт дараахь үндсэн хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Тулгарч буй асуудлаа тодорхойлох,шийдлийг боломжит шийдлийг тодорхойлох;

- Шийдлүүдэд дүн шинжилгээ хийн, боломжит хувилбарыг сонгох;

- Хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөх; болон

- Хяналт тавих

Ихэнхдээ, иргэд, оршин суугчдын түвшинд үйл ажиллагааны төлөвлөлт хийх үйл явц нь ижил төрлийн үйл ажиллагааг бусад газруудад хэрэгжүүлэх ачааллыг нэмэгдүүлдэг. Үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх энэхүү үзэл баримтлал гэр хорооллын нөхцөл сайжруулах загвар төслүүдийг цаашид үргэлжүүлэн өөр бусад газарт амжилттай хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй.

Түүнчлэн иргэдийн оролцоотой үйл ажиллагааны төлөвлөгөө нь орон нутгийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх, төлөвлөгчид болон орон нутгийн захиргааны байгууллагыг хүн амын асуудлаарх хариуцлагыг нэмэгдүүлэх, хот төлөвлөлтийн журам болон стандартыг оновчтой болгох, шийдвэр гаргах түвшинд хамтран ажиллан санал бодлоо илэрхийлэх зэрэг боломжуудыг олгодог. Эдгээр боломжууд нь хотын хөгжлийн стратеги төлөвлөлтийг өргөн хүрээнд хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулдаг.

ХАВСРАЛТ 3. Санхүүгийн удирдлагын үнэлгээний асуулга

Сэдэв		Хариулт	Тайлбар
1.	**Хэрэгжүүлэгч агентлаг**		
1.1	Агентлаг ямар хууль эрх зүйн статус/бүртгэлтэй вэ?	Яам	БХБЯам
1.2	Агентлаг өмнө нь гадны санхүүжилттэй төсөл хэрэгжүүлж байсан уу (хэрэв тийм бол дэлгэрэнгүй тайлбарлана уу)?	Тийм	Хуучин ДБЯ, БХБНААҮА-д Зээл No.1506 Зээл No.1907
1.3	Агентлаг тайлагнах хууль ёсны ямар шаардлагатай вэ?	Хууль	ТБУСХууль
1.4	Төслийг удирдах нэгж бие даасан уу?	Тийм	
1.5	Байгууллагын бүтэц зохион байгуулалт төслийн шаардлагад нийцэх үү?	Тийм	
2.	**Нөөцийн Урсгалын Тогтолцоо**		
2.1	АХБ, засгийн газар, бусад санхүүжүүлэгчээс авах хөрөнгийн урсгалын бүдүүвч, тайлбартайгаар төслийн хөрөнгийн урсгалын тогтолцоог (санал болгох) харуул.	Эцсийн Тайлангийн Төслийн IV.E-г үз.	
2.2	Агентлагт (засгийн газраас/Сангийн Яамнаас) зээлийг шилжүүлэх тогтолцоо (санал болгосон) нь шаардлага хангасан уу?	Тийм	
2.3	Байгууллагад өмнө нь мөнгө авахад ямар үндсэн хүндрэлүүд учирч байсан бэ?	Байхгүй	
2.4	Аль банканд Зээлийн данс нээх вэ?	Зөвшөөрөгдсөн Арилжааны Банк	СЯ-тай тохирно.
2.5	Төсөл хэрэгжүүлэх (санал болгох) нэгж (ТХН) нь АХБ-наас хувиарласан хөрөнгийг удирдаж байсан туршлагатай юу?	Тийм	
2.7	Байгууллага гадаад валютийн ханшны эрсдэлийг удирдах чадвартай/чадвар шаардлагтай юу?	Үгүй	
2.8	Засгийн газрын оролцооны хөрөнгийг хэрхэн олж авах вэ?	Төсвөөс шууд	
2.9	Засгийн газрын оролцооны хөрөнгийн төлбөр хэрхэн хийгдэх вэ?	Ихэнх тохиолдолд татвар хэлбэрээр	НӨТ, Импортын татвар
2.10	Төслийн зарим хэсгийг олон нийтийн болон төрийн бус байгууллагаар хэрэгжүүлэх болвол ТХН нь өөрийн системдээ эдгээр байгууллагын зарцуулах төслийн хөрөнгийг тайлагнах болон хянах тогтолцоог бүрдүүлсэн уу?	Тийм	
2.11	Төслийн өртөгт ашиг орлогыг оруулах шаардлагатай юу? Ашиг орлогыг ямар нэгэн хэлбэрээр оруулах (хөдөлмөрийн хэлбэрээр) бол хөдөлмөрийн оролцоог бүртгэж, үнэлэхэд тохиромжтой гарын авлага бэлтгэгдсэн үү?	Тийм	Гарын авлага бэлтгэнэ.
3.	**Боловсон хүчин**		
3.1	Бүртгэлийн хэлтсийн зохион байгуулалтын бүтэц (санал болгох) ямар вэ? Зохион байгуулалтын бүтцийн бүдүүвчийг хавсарга.	Одоогоор БХБЯ нэг нягтлантай	БХБЯ-д ТУА бүртгэлийн хэлтэстай байгуулагдана.
3.2	Бүртгэлийн ажилтнуудын (санал болгох) албан тушаал, үүрэг, боловсрол, ажлын туршлага зэргийг тодорхойл. Бүртгэлийн		Ер.Ня.Бо-Бурмаа 1998-ХААИ Ня.бо 2003.12-МНБ

	үндсэн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолт, CV-г хавсарга.		Хувийн салбарт 6 жил ажилласан.
3.3	Төслийн санхүү, бүртгэлийн ажил үүргүүдийг гүйцэтгэх хангалттай ажилтнууд бий юу?	Үгүй	
3.4	Санхүү, бүртгэлийн ажилтнууд хангалттай мэдлэг, туршлагатай болсон уу?	Зарим	ТББүртгэл, АХБ-ны журмаар сургах
3.5	Төслийн бүртгэл, санхүүгийн ажилтнууд АХБ-ны журамд суралцсан уу?	ТУА-ны ажилтнууд суралцсан. БХБЯ ня.бо суралцаагүй	
3.6	Санхүү болон бүртгэлийн ажилтнуудын гэрээ ямар хугацаатай вэ?	Одоогоор гэрээ байгуулаагүй	
3.7	Хараахан гэрээ байгуулаагүй гол орон тоог тодорхойлж, албан тушаалд томилох огноог урьдчилан тодорхойл.	Тодорхойгүй	
3.10	Бүх дарга, менежер, ажилтнуудын үүрэг, хариуцлага, удирдлагын чиг, эрх мэдлийн хязгаарыг тодорхойлон бичгээр илэрхийлсэн албан тушаалын тодорхойлолт төсөлд бий юу?	Төсөл хэрэгжүүлснээр СУС-тэй болно	
3.11	Албан тушаалтнуудыг ямар хугацаагаар томилдог вэ?	Тодорхойгүй	
3.12	Санхүү, бүртгэлийн ажилтнуудыг сургах ямар бодлоготой вэ?	АХБ Зээлийн Удирдлагын Гарын авлага	
4.	**Бүртгэлийн Бодлого ба Журам**		
4.1	Байгууллагын бүртгэлийн систем нь төслийн санхүүгийн ажил гүйлгээг бүрэлдэхүүн бүрээр, хувиарлалтын төрлөөр, эх үүсвэр бүрээр зардлыг хувиарлан үнэн зөв бүртгэх боломжтой юу? Байгууллагын бүртгэлийн системийг төсөлд ашиглах уу?	Тийм	БХБЯ нь Макс санхүүгийн программ ашигладаг.
4.2	Бүх ажил гүйлгээг үнэн зөв бүртгэж, хангалттай тайлбарласныг батлах, ажил гүйлгээг бэлтгэх болон зөвшөөрөхтэй холбогдсон хяналт бий юу?	Тийм	
4.3	Дансны жагсаалт нь төслийн үйл ажиллагаа, зардлын ангилалыг үнэн зөв бүртгэж, тайлагнахад хангалттай юу?	Үгүй	Төсөлд зориулж данс нэмэх шаардлагатай
4.4	Олон төрлийн нөөцийн эх үүсвэрүүдэд зардлын хувиарлалт нь яг тохирохоор, байгуулсан гэрээний дагуу хийгдсэн үү?	Тийм	
4.5	Ерөнхий дэвтэр болон туслах дэвтрүүд хоорондоо тохирч, балансалж байна уу?	Тийм	
4.6	Бүх бүртгэлийн болон туслах баримт бичгүүд тогтоосон системд байнга тогтмол хадгалагдаж, эрх бүхий ажилтан шаадлагтай зүйлээ хялбар олох боломжтой юу?	Тийм	
Ажил үүргийн хувиарлалт			
4.7	Дараах ажил үүргүүдийг өөр өөр нэгж, ажилтан гүйцэтгэдэг үү? (i) ажил гүйлгээг гүйцэтгэх эрх мэдэл; (ii) ажил гүйлгээг бүртгэх; (iii) ажил гүйлгээнд хамаарах хөрөнгийг хариуцан хадгалах	Тийм	Газрын Харилцаа, Геодези, Зураг зүйн газрын 2 нягтланг давхар ажиллуулдаг
4.8	Бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг захиалах, хүлээн авах, бүртгэх, төлбөр хийх үүргүүдийг зохистой байдлаар салгаж тусгаарласан уу?	Үгүй	БХБЯ нэг нягтлантай
4.9	Төлбөр гүйцэтгэгч болон зөвшөөрөл	Үгүй	БХБЯ нэг нягтлантай

	олгогчоос өөр хүн Банкны зохицуулалтыг бэлтгэдэг үү?		
Төсвийн тогтолцоо			
4.10	Төсөвт биет тоо хэмжээ болон санхүүгийн зорилтыг тусгадаг уу?	Тийм	
4.11	Гүйцэтгэлийг удирдан чиглүүлэхэд шаардагдах чухал хэрэгслийг бүрдүүлэхээр бүх шаардлагатай үйл ажиллагааны төсвийг хангалттай дэлгэрэнгүй бэлтгэсэн үү?	Тийм	
4.12	Бодит зардлыг төсөвтэй байнга зохистой харьцуулж, төсвөөс зөрж байгаа гол зөрүүг тайлбарлах шаардлага байдаг уу?	Тийм	
4.13	Зөрүүг гарахаас өмнө урьдчилан зөвшөөрөл авдаг уу эсвэл гарсаны дараа авдаг уу?	Дараа нь	
4.14	Хэн төсөв боловсруулж, батлуулах үүрэгтэй вэ?	Төрийн нарийн бичиг, УИХ	ТБУСХуулиар
4.15	Төслийн үйл ажиллагааг төлөвлөх, бүрэлдэхүүн хэсгүүдийг гүйцэтгэх үүрэгтэй нэгжүүдээс мэдээлэл олж авах, төсөв боловсруулах журам байна уу?	Тийм	
4.16	Төсвийн төлөвлөгөө болон төслийн үйл ажиллагааны төсөв нь бодитой, үнэн зөв таамаглалд үндэслэн, мэдлэгтэй хүмүүс боловсруулсан уу?	Одоогоор бэлэн болоогүй	
Төлбөр			
4.17	Нэхэмжлэл боловсруулах журамд дараах зүйлс тусгагдсан уу: (i) Худалдан авалтын захиалга болон бараа хүлээн авсан тайланг шууд тайлан бэлтгэж буй хэлтсээс авах; (ii) Нэхэмжлэл дээрх тоо хэмжээ, үнэ ба төлбөрийн нөхцөл зэргийг худалдан авалтын захиалга болон бодитоор хүлээн авсан барааны тайлантай харьцуулах; (iii) Нэхэмжлэл дээрх тоо хэмжээг бараа хүлээн авсан тайлантай харьцуулах; (iv) Тооцооллын үнэн зөвийг шалгах;	Тийм	БХБЯ нэг нягтлантай
4.18	Бүх нэхэмжлэл дээр ТӨЛСӨН гэсэн тамга дарж, огноог бичиж, шалгаж, зөвшөөрөл авагдаж, бичилт хийгдэх дансны кодыг тодорхой тэмдэглэдэг үү?	Тийм	
4.19	Цалин хөлсний тооцоог хянаж, цалингийн өөрчлөлтийг эрх бүхий хүний зөвшөөрлөөр хийдэг үү?	Тийм	
Бодлого ба журам			
4.20	Бүртгэл ямар суурьтай вэ? (мөнгөн, тохируулгат г.м)	Тохируулгат суурь	
4.21	Бүртгэлийн ямар стандартыг мөрддөг вэ?	ОУНББСтандарт	ТБУСХуулиар 9.1.1
4.22	Ажилтнуудын тайлагналын үнэн зөвийг батлах, үйл ажиллагааны удирдамж болох бодлого, журмын хангалттай гарын авлага төсөлд бий юу?	Зээл зарцуулалтын гарын авлагын дагуу СУС-тэй болно	
4.23	Төслийн ажиллагаанд зориулж бүртгэлийн бодлого, журмын гарын авлагыг шинэчилсэн үү?	Зээл хүчин төгөлдөр болмогц шинэчлэгдэнэ	
4.24	Агентлагийн ашиглах бүртгэлийн зарчим, бодлого, журмыг зөвхөн эрх бүхий хүн өөрчлөх буюу шинээр тогтоох журам байдаг	Тийм	

	уу?		
4.25	Бичгээр илэрхийлсэн бодлого, журамд бүх байх ёстой санхүүгийн удирдлага, захиргааны холбогдох үйл ажиллагааг хамруулсан уу?	СЯ-ны бүртгэлийн бодлогын газар Төсвийн байгууллагын бүртгэлийн бодлого, журамыг боловсруулсан.	
4.26	Сонирхлын зөрчил ба холбоотой талуудын ажил гүйлгээг (бодитой ба мэдээжийн) бодлого ба журамд тодорхой тодорхойлж, үүнээс байгууллагыг хамгаалах зүйлийг тусгасан уу?	Тодорхойгүй	
4.27	Гарын авлагыг шаардлагатай хүмүүст тараасан уу?	Тийм	
Мөнгөн хөрөнгө ба Банк			
4.28	Банкны дансны гүйлгээний гарын үсэг зурах эрх бүхий хүний нэр, албан тушаалыг тодорхой бич.	1-р гарын үсэг Т.Самбасанчир-БХБЯ-ныТНБ 2-р гарын үсэг Н.Бурмаа-БХБЯ-ны Ер.ня.бо	
4.29	Байгууллага хүлээн авсан мөнгө болон төлбөрийг шаардлага хангахуйцаар өдөр тутам бүртгэдэг мөнгөн хөрөнгийн бүртгэлтэй юу?	Тийм	
4.30	Мөнгөн хөрөнгө хүлээн авдаг бүх газарт мөнгө хуримтлуулах, тодорхой хугацаанд банкны дансаар хүлээн авах мөнгө болон мөнгөний бүртгэлд хяналт байдаг уу?	Тийм	
4.31	Банк болон мөнгөн хөрөнгийн зохицуулалтыг сараар хийдэг үү?	Тийм	
4.32	Банкны зохицуулалтын бүх ердийн бус зүйлсийг хариуцлагатай албан тушаалтан хянаж, баталгаажуулдаг уу?	Тийм	
4.33	Банкны дансаар орж ирэх мөнгөний хугацаа тодорхой байдаг уу?	Тийм	
Хөрөнгийн хамгаалалт			
4.34	Хөрөнгийг хулгайлагдах, үрэгдэх, буруу ашиглагдахаас хамгаалах хангалттай хамгааллалтын тогтолцоотой юу?	Тийм	
4.35	Үндсэн хөрөнгө ба үнэт цаасны туслах бүртгэл нь өдөр тутам шинэчлэгдэн, хяналтын данстай зохицуулгддаг уу?	Тийм	
4.36	Үндсэн хөрөнгө ба үнэт цаасны биет тооллогыг тогтмол хийдэг үү?	Тийм	
4.37	Хөрөнгийг даатгалын бодлогод хангалттай хамруулсан уу?	Үгүй	
Бусад албан газар ба хэрэгжүүлэгч агентлаг			
4.38	Хэрэгжүүлэлтэнд оролцох орон нутгийн ямар нэгэн өөр албан газар буюу хэрэгжүүлэгч байгууллага бий юу?	Тийм	
4.39	Бусад албан газар буюу байгууллагад хамаарах нөөцийн урсгалын, санхүүгийн мэдээллийн, тайлагналын, аудитын хяналт ба журмыг төслөөр бий болгосон уу?	Болгоно	
4.40	Албан газрууд/хэрэгжүүлэгч агентлагуудын хооронд мэдээлэл үнэн зөвөөр, хугацаандаа очдог уу?	Тийм	
4.41	Албан газрууд/хэрэгжүүлэгч агентлагуудын хооронд зохицуулалтыг байнга тогтмол гүйцэтгэдэг үү?	Тийм	

Бусад			
4.42	Төслийн нөөц буюу хөрөнгө хулгайлагдсан, хаягдсан, зүй бус ашиглагдсан гэж сэжиглэхэд энэ тухай мэдээлэх тодорхой ажилтан, буюу энэ асуудлыг хүлээн авах хүнийг төсөлд зааж өгсөн үү?	Тийм, ерөнхий	
5.	**Дотоод аудит**		
5.1	Агентлагт дотоод аудитын хэлтэс байдаг уу?	Үгүй	
5.2	Аудитын хэлтсийн ажилтнууд ямар мэдлэг, туршлагатай вэ?	-	
5.3	Дотоод аудитор хэнд тайлагнадаг вэ?	-	
5.4	Дотоод аудитын хэлтэс ажлын хөтөлбөртөө төслийг хамруулах уу?	-	
5.5	Дотоод аудитын илрүүлсэн зөрчлийн талаар ажил хийгдсэн үү?	-	
6.	**Гадаад Аудит**		
6.1	Агентлагийн санхүүгийн тайлангууд хөндлөнгийн аудитын байгууллагаар тогтмол аудитлагддаг уу? Аудитор нь ямар байгууллага вэ?	Тийм. Монгол Улсын Үндэсний Аудитын Газар	
6.2	Агентлагийн аудит саатаж байсан тохиолдол бий юу? Аудитын тайлан хэдийд гардаг вэ?	СТ хүлээн авсаны дараа 1 сарын дотор	ТБУСХууль Зүйл-38.2 /3.15 орчим/
6.3	Агентлагт хийгдэж буй аудит Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийгддэг үү?	Тийм	
6.4	Өнгөрсөн гурван жилийн аудитын тайланд тусгасан ямар нэгэн чухал зүйл байна уу?	Үгүй	БХБЯ-ны СТ энэ жил анх удаа аудитлагдаж байна
6.5	Агентлагийн аудитор төслийн тайланд аудит хийх үү эсвэл төслийн санхүүгийн тайлангуудад аудит хийх өөр аудитор томилогдох уу?	Өөр аудитор	АХБ-ны хүлээн зөвшөөрсөн
6.6	Аудитор өмнөх аудитын тайлан буюу удирдлагын захидалд тусгасан ч хэрэгжүүлээгүй байгаа санал байна уу?	Үгүй	БХБЯ-ны СТ энэ жил анх удаа аудитлагдаж байна
6.7	Хөндлөнгийн аудитаас гадна засгийн газрын бие даасан агентлаг (аудитын дээд байгууллага)-аар аудит хийлгэх зүйл төсөлд бий юу?	Үгүй	
6.8	Төслийн жилийн аудит хийхэд тохиромжтой ажлын удирдамж төсөлд бий юу?	Одоогоор байхгүй	
7.	**Тайлагнал ба Хяналт**		
7.1	Агентлаг санхүүгийн тайлангууд бэлтгэдэг үү? Бүртгэлийн ямар стандартын дагуу бэлтгэдэг вэ?	Тийм. ОУНББСтандарт	
7.2	Хэрэгжүүлэгч нэгж санхүүгийн тайлан бэлтгэдэг үү?	Тийм	
7.3	Санхүүгийн тайлангуудыг ямар хугацаагаар бэлтгэдэг вэ? Удирдлага шийдвэр гаргахдаа тайланг ашиглахуйцаар тогтмол хэлбэрээр бэлтгэдэг үү?	Улирал тутам. Тийм	НББ-ын хуулиар
7.4	Төслийн бүрэлдэхүүн хэсгийг тайлагнахын тулд тайлагналын тогтолцоог тохируулах/засварлах шаардлагатай юу?	Тийм	

7.5	Тайлангийн тогтолцоо нь санхүүгийн мэдээллийг төслийн биет үйл ажиллагаатай холбох боломжтой юу? Хэрэв биет тоо хэмжээг цуглуулж, эмхэтгэх өөр систем ашигладаг бол биет тоо хэмжээ нь санхүүгийн мэдээлэлтэй таарахгүй байх эрсдэлийг багасгах ямар хяналт байдаг вэ?	Тийм	
7.6	Ямар тайлан бэлтгэх, түүнд ямар мэдээлэл агуулах, түүнийг хэрхэн ашиглах зэргийг тодорхойлсон санхүүгийн удирдлагын тайлагналын үүрэг хариуцлага төсөлд бий юу?	СУС бий болно.	
7.7	Удирдлага санхүүгийн удирдлагын тайлан ашигладаг уу?	Ашиглана	
7.8	Санхүүгийн тайланд бодит зардлыг төсөв болон хөтөлбөрийн хувиарлагдсан дүнтэй харьцуулдаг уу?	Тийм	
7.9	Санхүүгийн тайлангуудыг бүртгэлийн автоматчилагдсан системээс шууд бэлтгэдэг үү эсвэл гар аргаар болон өөр аргаар бэлтгэдэг үү?	Автоматчилагдсан бүртгэлийн системтэй	Макс санхүүгийн программ
8.	**Мэдээллийн Систем**		
8.1	Санхүүгийн удирдлагын систем компьютержсэн үү?	Тийм	
8.2	Систем нь төслийн шаардлагатай санхүүгийн тайлангуудыг бэлтгэж чадах уу?	Тийм	
8.3	Ажилтнуудыг системийг ажиллуулах хангалттай түвшинд сургасан уу?	Тийм	
8.4	Удирдлагын зохион байгуулалт, боловсруулах тогтолцоо нь мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, ашиглахад бэлэн байдлыг хамгаалсан байдаг уу?	Тийм	

ХАВСРАЛТ И. МОНГОЛЫН ХОТ СУУРИН ГАЗРЫН ОРОН СУУЦНЫ ХЭРЭГЦЭЭ

ХҮН АМ, ӨРХИЙН ТООЦОО	Оноор	Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар	Нийт
Хот, суурины хүн ам	2004	124467	192040	184067	75345	869912	1445831
Нэг өрхийн дундаж ам бүл		**4.71**	**4.59**	**3.92**	**3.78**	**5.39**	**4.88**
Нийт өрхийн тоо	2004	26429	41828	46949	19919	161273	296398
Бүсийн хот, суурины өрх (%)		**8.9**	**14.1**	**15.8**	**6.7**	**54.4**	**100.0**
Хүн амын жилийн өсөлт (%)		0.55	1.35	1.30	-0.04	2.50	1.90
Хот, суурины нийт хүн ам	2008	**127241**	**202609**	**193803**	**75221**	**960220**	**1559093**
Нэг өрхийн дундаж ам бүл		4.74	4.59	3.94	3.78	5.39	4.90
Нийт өрхийн тоо	2008	**26830**	**44115**	**49238**	**19879**	**178015**	**318077**
Хот, суурины өрхийн эзлэх хувь		**8.4**	**13.9**	**15.5**	**6.2**	**56.0**	**100.0**
Шинэ өрхийн тоо, төлөвлөсөн хугацаанд		**401**	**2287**	**2289**	**-40**	**16742**	**21679**
Шинэ өрхийн тоо, жилд		**100**	**572**	**572**	**-10**	**4186**	**5420**

ӨНӨӨГИЙН ОРОН СУУЦНЫ ФОНД БА ОРОН СУУЦНЫ ИРЭЭДҮЙН ХЭРЭГЦЭЭ		Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар	Нийт
Орон сууцны фонд	2004						
Дэд бүтцэд (ус, бохир, цахилгаан) холбогдсон сууц		2924	12631	19109	6715	76678	118057
Цаашид сайжруулж болох тохиромжийн сууц		9546	12460	16243	6724	49437	94410
Одоо байгаа нийт гэрийн тоо		13959	16737	11597	6480	35158	83931
Нийт нэгж сууцны тоо		**26429**	**41828**	**46949**	**19919**	**161273**	**296398**
Өрх/нэгж сууцны харьцаа							
өрх/нэгж сууцны харьцаа	2004	**1.00**	**1.00**	**1.00**	**1.00**	**1.00**	**1.00**
хүлээгдэж буй өрх/нэгж сууцны харьцаа	2008	1.00	1.00	1.00	1.00	1.00	1.00
харьцааг барихад шаардагдах сууц, жилд		**0**	**0**	**0**	**0**	**0**	**0**
харьцааг барихад шаардагдах сууц, төлөвлөсөн хугацаанд		**0**	**0**	**0**	**0**	**0**	**0**
Сууцны хорогдол (replacement)							
гэр (non-upgradeable), %, жилд		5.00	5.00	5.00	5.00	5.00	5.0
гэрийн тоо, жилд		**698**	**837**	**580**	**324**	**1758**	**4197**
гэрийн тоо, төлөвлөсөн хугацаанд		**2792**	**3347**	**2319**	**1296**	**7032**	**16786**
боломжийн сууц (acceptable), %, жилд		2.00	2.00	2.00	2.00	2.00	2.0
боломжийн сууцны тоо, жилд		**58**	**253**	**382**	**134**	**1534**	**2361**
боломжийн сууцны тоо, төлөвлөсөн хугацаанд		**234**	**1010**	**1529**	**537**	**6134**	**9445**
сайжруулсан сууц (upgradeable), %, жилд		4.00	4.00	4.00	4.00	4.00	4.0
сайжруулсан сууцны тоо, жилд		**382**	**498**	**650**	**269**	**1977**	**3776**
сайжруулсан сууцны тоо, төлөвлөсөн хугацаанд		**1527**	**1994**	**2599**	**1076**	**7910**	**15106**
Нийт хорогдол, жилд		**1138**	**2160**	**2184**	**717**	**9454**	**15654**
Нийт хорогдол, төлөвлөсөн хугацаанд		**4553**	**6351**	**6447**	**2909**	**21076**	**41336**
Хорогдлыг нөхөхөд шаардагдах шинэ сууц	2008	**4954**	**8639**	**8736**	**2869**	**37818**	**63016**
Жилд шинээр барих орон сууцны тоо		**1239**	**2160**	**2184**	**717**	**9454**	**15754**
Орон сууцны фонд	2008	**26830**	**44115**	**49238**	**19879**	**178015**	**318077**
Сайжруулах сууцны эзлэх хувь	2004	**36.1**	**29.8**	**34.6**	**33.8**	**30.7**	**31.9**
Сууц сайжруулалтын хувь, жилд		5.00	5.00	5.00	5.00	5.00	5.0
Сайжруулах сууц, жилд		**401**	**523**	**682**	**282**	**2076**	**3965**
Сайжруулах сууц, төлөвлөсөн хугацаанд	2008	**1604**	**2093**	**2729**	**1130**	**8305**	**15861**
Сайжруулах сууц, хувиар	2008	**23.9**	**19.0**	**22.2**	**22.7**	**18.7**	**19.9**
Газрын хөрвөх коеффициент (метр/нэгж сууц)		750	638	750	750	600	634
Шинэ газар баригдах нөхөх сууц, хувиар		20	33	22	17	20	21.9
Төлөвлөгдсөн хугацаанд шаардагдах газар, га		**78**	**248**	**256**	**32**	**1257**	**1871**

Загвараар тооцсон үр дүнгийн үзүүлэлтийг тодоор харуулав (тод бус тоог өөрчилж өөр хувилбараар тооцож болно).

МОНГОЛЫН ХОТ СУУРИН ГАЗРЫН ОРОН СУУЦНЫ ХЭРЭГЦЭЭ (үрг.)

ОРОН СУУЦНЫ ӨРТГИЙН ТООЦОО	Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар	Нийт
ШИНЭ СУУЦ						
Хашааны газрын дундаж хэмжээ (зам орно), м2	750	665	750	750	600	**648**
Газрын үнэ/м2	100	191	200	100	500	**366**
Дэд бүтцийн өртөг/м2	2672	4630	3409	2103	5000	**4414**
Нэг сууцны дундаж талбай, м2	60	60	60	60	60	**60**
Сууцны барилгын өртөг/м2	84390	97492	94724	92404	115000	**106354**
Боломжийн (acceptable) шинэ сууцны өртөг, суурь оноор	**7142740**	**9055925**	**8390106**	**7196466**	**10200000**	**9415153**
Нийт өртөгт газрын өртгийн эзлэх хувь	**1**	**1**	**2**	**1**	**3**	**2**
Газрын үнийн жилийн өсөлт, %	5	5	5	5	5	**5**
Нийт өртөгт дэд бүтцийн өртгийн эзлэх хувь	**28**	**34**	**30**	**22**	**29**	**30**
Дэд бүтцийн өртгийн жилийн өсөлт, %	2	2	2	2	2	**2**
Нийт өртөгт байшингийн өртгийн эзлэх хувь	**71**	**65**	**68**	**77**	**68**	**68**
Байшингийн өртгийн жилийн өсөлт, %	3	3	2	3	3	**3**
Тохиромжийн сууцны дундаж өртөг, төлөвлөгдсөн хугацаанд	**7551183**	**9563608**	**8771844**	**7617480**	**10788980**	**9942418**
Нийт өртөг, төлөвлөгдсөн хугацаанд (сая төгрөг)	**37412**	**82617**	**76628**	**21853**	**408017**	**626528**
САЙЖРУУЛАХ СУУЦ						
Хэсэгчлэн сайжруулах газар, га	91	125	176	65	250	**707**
Бүрэн сайжруулах газар, га	39	48	51	25	300	**463**
Хэсэгчлэн сайжруулах талбайн өртөг/м2	300	200	200	200	300	**262**
Бүрэн сайжруулах талбайн өртөг/м2	500	400	400	300	500	**455**
Газрын дундаж өртөг/нэг сууц	**89129**	**69765**	**71531**	**57922**	**89406**	**82363**
Хэсэгчлэн сайжруулах талбайн өртөг/м2	500	663	712	300	800	**701**
Бүрэн сайжруулах талбайн өртөг/м2	712	863	917	600	1200	**1015**
Нэгж сууцны дэд бүтцийн дундаж өртөг	**139567**	**196231**	**221314**	**97478**	**222522**	**200570**
Сууцны дундаж талбай, м2	30	30	30	30	30	**30**
Сууцны тохижилт сайжруулалтын өртөг/м2	30000	30000	30000	30000	60000	**45709**
Байшингийн тохижилт сайжруулалтын дундаж өртөг	**900000**	**900000**	**900000**	**900000**	**1800000**	**1371277**
Нэгж сууцны дундаж нийт өртөг, суурь оноор	**1128696**	**1165997**	**1192845**	**1055400**	**2111928**	**1654211**
Нийт өртөгт газрын өртгийн эзлэх хувь	**8**	**6**	**6**	**5**	**4**	**5**
Газрын үнийн жилийн өсөлт, %	3	3	3	3	3	**3**
Нийт өртөгт дэд бүтцийн өртгийн эзлэх хувь	**12**	**17**	**19**	**9**	**11**	**12**
Дэд бүтцийн өртгийн жилийн өсөлт, %	2	2	2	2	2	**2**
Нийт өртөгт сууцны өртгийн эзлэх хувь	**80**	**77**	**75**	**85**	**85**	**83**
Сууцны өртгийн жилийн өсөлт, %	3	3	3	3	3	**3**
Сайжруулах сууцны дундаж өртөг, төлөвлөсөн хугацаанд	**1196521**	**1234942**	**1262934**	**1119532**	**2239669**	**1753700**
Нийт өртөг, төлөвлөгдсөн хугацаанд, сая төг.	**1919**	**2585**	**3446**	**1265**	**18601**	**27816**
СУУЦ БҮГД						
Нийт өртөг, төлөвлөгдсөн хугацаанд	**39331**	**85202**	**80074**	**23118**	**426619**	**654344**
Газрын үнэ, сая төг.	**544**	**1313**	**1575**	**297**	**12788**	**16517**
Дэд бүтцийн өртөг, сая төг.	**10736**	**28529**	**23992**	**4906**	**121965**	**190128**
Сууцны өртөг, сая төг.	**28051**	**55360**	**54508**	**17914**	**291866**	**447699**
Жилийн дундаж өртөг, сая төг	**9833**	**21301**	**20019**	**5780**	**106655**	**163586**

МОНГОЛЫН ХОТ СУУРИН ГАЗРЫН ОРОН СУУЦНЫ ХЭРЭГЦЭЭ (үрг.)

ОРОН СУУЦНЫ НЭГЖ БҮТЭЭГДЭХҮҮН БА ӨРТГИЙН ТООЦОО								
ТӨГ//1 АМ. ДОЛ. = 1210			Баруун	Хангай	Төв	Зүүн	Улаанбаатар	Нийт
Шинэ сууцны тоо			4954	8639	8736	2869	37818	63016
Сайжруулсан сууцны тоо			1604	2093	2729	1130	8305	15861
Газрын үнэ	Шинэ газар	сая төг	393	1158	1368	228	12001	15147
		сая ам.дол	0.3	1.0	1.1	0.2	9.9	12.5
	Сайжруулах	сая төг	152	155	207	69	787	1370
		сая ам.дол	0.1	0.1	0.2	0.1	0.7	1.1
Дэд бүтцийн өртөг	Шинэ газар	сая төг	10498	28094	23352	4790	120005	186739
		сая ам.дол	8.7	23.2	19.3	4.0	99.2	154.3
	Сайжруулах	сая төг	237	435	639	117	1960	3388
		сая ам.дол	0.2	0.4	0.5	0.1	1.6	2.8
Сууцны өртөг	Шинэ газар	сая төг	26521	53365	51908	16836	276012	424641
		сая ам.дол	21.9	44.1	42.9	13.9	228.1	350.9
	Сайжруулах	сая төг	1530	1995	2600	1078	15854	23058
		сая ам.дол	1.3	1.6	2.1	0.9	13.1	19.1
Өртөг - бүгд	Шинэ газар	сая төг	37412	82617	76628	21853	408017	626528
		сая ам.дол	30.9	68.3	63.3	18.1	337.2	517.8
